

МОНГОЛ УЛС

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ
НҮБ-ЫН КОНВЕНЦИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХИ
МОНГОЛ УЛСЫН АНХДУГААР ИЛТГЭЛ**

УЛААНБААТАР ХОТ

2011 ОН

ҮНДЭСНИЙ ИЛТГЭЛ БОЛОВСРУУЛАХ АРГА ЗҮЙ БА ЗӨВЛӨЛДӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Үндэсний анхдугаар илтгэлийг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн заалтууд Үндэсний хууль тогтоомжтой хэрхэн нийцэж байгаа хийгээд нийцүүлэх талаар хийсэн зүйлс, тусгай эрхүүдийг эдлүүлэх тухайд гарсан амжилт ахиц ба хэрэгжүүлэх явцад гарч буй бэрхшээлтэй асуудал, алдаа дутагдал, энэ талаар цаашид авах арга хэмжээний талаарх санал зэргийг тусган, конвенцийн 35 дугаар зүйлийн 1 дүгээр заалтын дагуу “Конвенцид тусгасан тусгай заалтуудын хэрэгжилтийг боловсруулах Удирдамж” /2009 оны 11 дүгээр сарын 18 Женев хот/ болон тус Удирдамжтай холбогдуулан НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын илгээсэн тэмдэглэлийг баримтлан НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүн амын сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр боловсруулав.

2. Уг илтгэлийг боловсруулахад Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын тушаалаар НХХЯ-ны дэд сайдаар ахлуулсан НХХЯ, ГХЯ, ХЗДХЯ, БСШУЯ, ЭМЯ, ЗТБХБЯ, НЗДТГ, СЗҮТ зэрэг төрийн, түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, хөгжил, хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоо, Хараагүй иргэдийн Үндэсний холбоо, “Тэгш нийгэм” холбоо, Монголын дүлий иргэдийн байгууллагуудын Үндэсний холбоо, Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чөлөөт үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо, Монголын тэргэнцэртэй иргэдийн холбоо зэрэг ТББ-уудын төлөөллийг хамруулсан бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдаж, төлөвлөгөө батлуулан хамтран ажиллалаа.

Ажлын хэсэг батлагдсан төлөвлөгөөний дагуу хуралдаанууд зохион байгуулж, санал, мэдээлэл солилцож ажиллахын зэрэгцээ илтгэлийн төслийг хэлэлцүүлэх зөвлөлдөх уулзалт хэлэлцүүлгүүдийг төрийн болон ТББ-уудын дунд 2 удаа зохион байгуулав. Уг хэлэлцүүлэгт холбогдох яамд, агентлаг, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, хамгаалал, хөгжлийн чиглэлээр болон хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 100 гаруй ТББ-ууд, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, ДЭМБ-ын төлөөлөгчид, мэргэжлийн хүмүүсийг өргөнөөр оролцуулж, олон нийтийн оролцоог хангахад анхаарч ажилласан болно.

НЭГ. КОНВЕНЦИЙН ҮНДСЭН БАРИМТ БИЧИГ

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Газар зүй, цаг уурын байдал

Монгол Улс нь төв Азийн өндөрлөг газар дэвсгэр дээр ОХУ, БНХАУ-ын дунд оршдог, далайд гарцгүй, эх газрын улс бөгөөд 1562,0 мян.кв. км нутаг дэвсгэртэй. Нутаг дэвсгэрийн хэмжээгээр Азид 7-рт, дэлхийд 18-д эрэмбэлэгддэг.

Цаг уурын хувьд эрс тэс уур амьсгалтай бөгөөд хамгийн халуун, хүйтэн өдрийн температурын жилийн болон нэгэн өдөр шөнийн температурын зөрөө их, -45С хэмээс +40С хэмийн хооронд хэлбэлздэг. Хур тунадас багатай, нутгийн умард хэсгээр жилд дунджаар 250-400 мм, өмнөд хэсэгт 100-150 мм тунадас ордог.

Нутаг дэвсгэрийн нийт талбайн дийлэнх хэсгийг говь, тал хээрийн бүс, 10 хүрэхгүй хувийг ой мод эзэлдэг. Гол мөрний усны нөөц нутгийн нийт талбайтай харьцуулахад хангалтгүй, хөрс нимгэн, үржил шим дунд зэрэг, эвдрэл бохирдолд эмзэг боловч зөвхөн малын бэлчээрт ашиглагдах төдий ирснээр дийлэнх нь онгон зэлүүд хэвээр хадгалагдан ирсэн байна.

Эрдсийн түүхий эд, ашигт малтмалын, түүний дотор алт, зэс, уран, чулуун нүүрсний баялаг нөөцтэй бөгөөд эдгээрийн баялагийн ордоороо олон улсын ач холбогдолтой.

2. Түүх, соёлын талаар:

Тус улсын нутагт бараг нэг сая жилийн өмнөөс хүн нутаглажээ. Анхны төрт улс Хүннү гүрэн байгуулагдсаны 2200 жилийн ой 2011онд тохиож буй. XII-XIII зуунд Чингис хаан болон түүний үр ач нарын үүсгэн байгуулсан Их Монгол Улсын 800 жилийн ой 2006 онд болсон билээ. XVII зууны эцсээр Манж чин гүрний эрхшээлд Хятадын нэг адил орсон ба 200-аад жилийн дараа Хятадтай мөн нэг зэрэг үндэсний эрх чөлөөний тэмцэл хийснийхээ үр дүнд Богд хаант тусгаар Монгол Улсыг тунхагласан юм. 1921 онд үндэсний ардчилсан хувьсгалыг хийсэн боловч 1940-өөд оноос тэр үеийн ЗХУ-ын дагуул улс болж, социалист хамтын нөхөрлөлийн бүрэлдэхүүнд дөчөөд жилийг туулсан нь дэвшил болон хоцрогдлын аль алиныг дагуулсан билээ. Үүний гол ололт нь хүн ам эрүүлжиж, нийтийн боловсрол, ахуй, соёл эрс дээшилсэн явдал бөгөөд Монгол улс 1961 онд НҮБ-ын гишүүнд элссэн юм. Түүнчлэн 1990 онд ардчилсан хувьсгалыг хийснээр орчин үеийн соёл иргэншилт ардчилсан төрт улс болсон билээ.

Монголчууд бол эртний соёлт ард түмний нэг юм. Монгол хэл нь Алтай язгуурын баялаг үгийн сантай, боловсорсон хэл бөгөөд өдгөө бидний Монголчууд 1000 жилийн түүхтэй монгол бичгээ кирилл үсэгтэй зэрэгцүүлэн хэрэглэж байна.

Монгол бөх, морины уралдаан, нум сум харваа, уртын дуу, хөөмий, бий биелгээ зэрэг нь Монголчуудын дэлхийн оюуны соёлын санд оруулсан үнэт хувь нэмэр юм.

3. Хүн амын байдал

Монгол Улс 2,7 сая хүн амтай учир сийрэг суудаг, цөөн хүнтэйд тооцогддог. Цөөн тооны түрэг /казах/ угсаатныг эс тооцвол үндсэндээ Монголчуудаас бүрэлдэх учир нэг үндэстний улс юм.

Өнгөрсөн зууны сүүлийн хагаст хүн ам дунджаар 66.1 хувь өсч байсан бол энэ зууны эхний 10 жилд 13.7 хувь болж буурсан хэдий ч 2010 оны Дэлхийн банкны харьцуулалтаар төрөлт 238 промилль /дэлхийн дундаж-203/, нас баралт 56 промилль /дэлхийн дундаж-86/, цэвэр өсөлт 182 промилль /дэлхийн дундаж-118/ гарсан нь чамлах үзүүлэлт биш юм.

Нийт хүн амын 66,7 хувийг 35 хүртэлх насныхан, 5,8 хувийг 60-аас дээш насныхан эзэлж байгаа бөгөөд хүн ам зүйн хувьд харьцангуй залуу улс юм . Хүн амын насжих процесс ойрын 15-20 жилд алгуурхан явагдах төлөв ажиглагдаж буй нь хүн ам зүйн ачаалал хүлцэхүйц хэмжээнд, "хүн ам зүйн" цонх нилээд хугацаанд нээлттэй байх таатай боломжийг илтгэж байна. Дундаж наслалт 67.96, үүнд эрэгтэй 64.33, эмэгтэй 71.79 байна.

Харин 2010 оны байдлаар Хүний хөгжлийн индекс шинэ аргачлалаар 0.622 болсон нь дэлхийн 169 орноос 100 дугаар байрт жагсч байгаа юм. Хүний хөгжлийн индекс 2000 онд хуучин аргачлалаар 0.655, харин шинэ аргачлалд хөрвүүлж тооцоноор 0,5389 байсан бөгөөд 113 дугаар байрт жагсаж байсантай харьцуулахад дэвшил гарсан байгаа хэдий ч энэ нь орлогын буюу нэг хүнд ногдох ДНБ-ний өсөлтөөр үндсэндээ тооцогдож байгааг дурдах нь зүйтэй.

4. Эдийн засгийн байдал

Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн харилцаанд шилжээд хорь гаруй жил болж байна. Энэ шилжилтийн эхний 3 жил нь уналтын, дараахь 4 жилд уналт зогсч ялимгүй боловч өсөлт гарч эхэлсэн, 2000 оноос өсөлт хурдасч эхлээд 2007 онд 10,2 хувь болсон боловч хямралын буюу 2008 онд 8,9 хувиар өсч, 2009 онд 1,3 хувиар буурсан байна. Харин 2010 онд 6,1 хувийн өсөлттэй гарлаа. Уул уурхайн эрчимтэй өсөлт хөгжлийн дүнд манай улсын эдийн засаг ойрын 10 жилд жил бүр дунджаар 12 хувиас доошгүй өсөх тухай Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод дурдсан байна.

Судалгаагаар Монгол Улс жишигдэх 15 орны дотор эдийн засгийн өсөлтөөрөө 2 дугаар байранд орсон хэдий ч хөдөлмөр эрхлэлтийн өсөлтөөр 14 дүгээр байранд буюу сүүлээсээ хоёрт орсон нь өсөлтийн үр шимийг орлоготой ажил хөдөлмөр эрхлүүлэх, хүн амын бүх бүлэгт хүртээн шударга хандлага нэвтрүүлэх нь өнөөгийн нийгмийн анхаарал татсан асуудал болон тулгарч буйг харуулж байна. Өнгөрөгч хугацаанд ядуурал 36 хувиас доошлоогүй, бодит ажилгүйдэл хоёр оронтой тооноос буураагүй, Жини коэффициент 2002-2003 онд 0.33 байсан бол 2007-2008 онд 0.36 болж нэмэгдсэн нь дээрх дүгнэлтийн давхар баталгаа болдог.

Уул уурхайн хөгжлийг үндэсний эрх ашгийн үүднээс алсын хараатай, зөв удирдан дэд бүтцээ сайжруулах, хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүнсний болон үйлчилгээний зэрэг хөдөлмөрийн шингээц сайтай салбаруудыг төрөлжүүлэн хөгжүүлэх нь удаан хугацаанд үргэлжлэх тогтвортой хөгжлийг бий болгох юм. Манай эдийн засгийн хөгжлийн нэг онцлог нь үйлдвэрлэл үйлчилгээний дийлэнх буюу 70 гаруй хувийг хувийн хэвшлийнхэн бүтээж байгаа явдал юм. Хувийн хэвшлийн хөгжил ба өмч хувьчлал нийгмийн амьдралд хоёр талтай нөлөөлсөн юм. Улсын өмчийн үйлдвэрүүдийг бодлого муутай хувьчилсан нь ажилгүйдэл ядуурлыг өдөөсөн бол шинээр төрсөн хувийн үйлдвэр, үйлчилгээнийхэн ажиллах хүчний эрэлтийг үүсгэгч хүчин болсноор ажилгүйдэлд эерэг нөлөө үзүүлснийг судлаачид санал нэгтэй тэмдэглэн хэлдэг.

2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН СТАТИСТИК

Монгол Улсад 2010 оны жилийн эцсийн байдлаар нийт 82,631 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа бөгөөд энэ нь нийт хүн амын 2,97 хувийг эзэлж байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 45,8 хувь нь эмэгтэй, 1 хувь нь 16-аас доош насны хүүхэд байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо 2010 онд өмнөх онтой харьцуулахад 1835-аар нэмэгдсэн бөгөөд нийт хүн амд эзлэх хувь нь харьцангуй тогтвортой байна.


Хүснэгт 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, шалтгаанаар 2008-2010

	ХБИ-ийн тоо	Нийт хүн амд эзлэх хувь	Төрөлхийн ХБИ-ийн тоо	Төрөлхийн ХБИ-ийн эзлэх хувь	Олдмол ХБИ-ийн тоо	Олдмол ХБИ-ийн эзлэх хувь
2008	76369	2.85	26708	35	49661	65
2009	80796	2.95	26708	33	54088	67
2010	82631	2.97	27278	33	55353	67

Эх үүсвэр: Статистикийн эмхэтгэл 2008-2010, ҮСХ

Хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаанаар авч үзвэл хөгжлийн бэрхшээлтэй нийт хүний гуравны нэг нь төрөлхийн, үлдсэн хэсэг нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй байна.

Зураг 1. Хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаан, хувиар; (2010)



Эх үүсвэр: Статистикийн эмхэтгэл 2010, ҮСХ


Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бараг 10 хувь мэргэжлээс шалтгаалах өвчин болон үйлдвэрлэлийн ослоос шалтгаалан олдмол хөгжлийн бэрхшээлтэй болсноос харахад манай улс хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, ажлын байрны эрүүл ахуйн асуудлаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээгээ илүү сайжруулах, болон урьдчилан сэргийлэх арга хэмжээнд түлхүү анхаарал хандуулах хэрэгтэй байгааг харуулж байна.

16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй 3 хүүхэд тутмын нэг нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй байгаа нь хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй болохоос сэргийлэх, осол гэмтлээс хамгаалахад чиглэсэн бодлого, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна. Олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 80 хувь нь ердийн өвчнөөс, 15 хувь нь ахуйн ослоос шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 80 хувь нь хөдөлмөрийн насны хүн байгаа бөгөөд тэднийг ажлын байртай болгож, эрхийг баталгаажуулах үүднээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн бодлого хөтөлбөрөө илүү боловсронгуй болгон, хэрэгжилтийг сайжруулах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амд хөдөлгөөний согогтой хүний эзлэх хувь өндөр буюу бараг 5 хүн тутмын нэг нь хөдөлгөөний согогтой байна.

Зураг 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, хувь, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр, 2010



Эх үүсвэр: Статистикийн эмхэтгэл 2010, ҮСГ

3. ҮНДСЭН ХУУЛЬ, УЛС ТӨР, ЭРХ ЗҮЙН БҮТЭЦ

1. 1992 онд батлагдсан Үндсэн хуулиар Монгол Улс нь парламентын бүгд найрамдах, нэгдсэн улс мөн. Монгол Улсад төрийн эрх мэдэл салбараар хуваарилагдсан бөгөөд хууль тогтоох дээд байгууллага нь Улсын Их Хурал, гүйцэтгэх дээд байгууллага нь Засгийн газар, шүүхийн дээд байгууллага нь Дээд шүүх болно.

Төрийн эрх барих дээд байгууллага УИХ нь бүх нийтийн сонгуулиар байгуулагддаг, нэг танхимтай, 76 гишүүнээс бүрддэг, хууль тогтоох онцгой эрх мэдэлтэй.

Монгол Улсын Засгийн газар нь Ерөнхий сайд, гишүүд (сайд нар)-ээс бүрддэг бөгөөд төрийн яамд тухайн салбарын бодлого боловсруулах ажил эрхлэлт, ерөнхий ба салбарын чиг үүрэг гүйцэтгэдэг, харьяандаа тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагуудтай .

Шүүх эрх мэдлийн хүрээнд шүүхийн бүх шатны байгууллага, прокурорын байгууллага, тэрчлэн Үндсэн хуулийн цэц багтан ажилладаг.

Монгол Улсын төрийн тэргүүн нь Ерөнхийлөгч бөгөөд түүнийг бүх нийтийн сонгуулиар сонгодог. Тэрээр хууль санаачлах, хуульд хориг тавих эрхтэй, шүүгчдийг томилох, чөлөөлөх, Ерөнхий сайдыг томилох саналыг УИХ-д оруулах эрх, үүрэгтэй.

Монгол Улс нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь сумд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдах бөгөөд эдгээр нэгжийн удирдлага нь өөрөө удирдах ёсны нийтийн буюу Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн удирдлага хэрэгжүүлэх бүх шатны Засаг дарга нар болно.

Монгол Улсад иргэний нийгмийн байгууллага, төлөөллийг ТББ-ууд гүйцэтгэдэг бөгөөд 1997 онд батлагдсан “ТББ-ын тухай” хуулийн дагуу байгуулагдан ажилладаг. Түүгээр сайн дураар эвлэлдэн нэгдэх эрхийн үндсэн дээр, гишүүддээ болон нийгэмд үйлчлэх үүрэгтэйгээр байгуулагдах, Улсын бүртгэлийн газарт бүртгүүлснээр үйл ажиллагаа явуулах, ашгийн бус ажиллагаа эрхлэх учир татвар төлөхөөс чөлөөлөгдөх зэрэг эрх хэмжээг нь тогтоосон байна.

Монгол Улсад шашин сүм хийдийн харилцааг хуулиар зохицуулдаг бөгөөд төр шашны тус тусын хэрэгт үл оролцох зарчим, иргэдийн шүтэх, эс шүтэх эрх чөлөөг баталгаажуулж, шашны урсгалууд орж ирэх нөхцөлийг хангасан болно. Өнөөгийн байдлаар Монгол улсад Будда, Христ, Ислам, Бахай, Бөө мөргөл, Мүүн шашны байгууллагууд бүртгэгдэн ажиллаж байгаа бөгөөд эдгээрийн 50 гаруй хувь нь Буддын, 40 орчим хувь нь Христийнх байна.

2. Иргэний нийгмийн байгууллага дотроос улс төрийн нам, үйлдвэрчний эвлэл тусгай хуулийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг. Фашист юм уу коммунист чиглэлийн нам ажиллахыг зөвшөөрдөггүй болно. Өдгөө Монголд улсын бүртгэлтэй 27 нам буйгаас Монгол ардын нам, Ардчилсан нам, Иргэний зориг, Ногоон нам парламентад суудалтай байна.

2008 оны УИХ-ын сонгуулиар МАН суудлын 59,2 хувь, АН 38,9 хувийг авсан болно. УИХ-ын 76 гишүүний зөвхөн 3 нь эмэгтэй байна.

3. Шүүхийн байгууллага, шүүх ажиллагаа

Монгол Улсын Үндсэн хуульд шүүх эрх мэдэл тусгай бүлэг болж орсон бөгөөд 47-56 дугаар зүйлээр шүүх, прокурорын байгууллагын тогтолцоо, үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим зэрэг шүүх эрх мэдлийн суурь харилцааг зохицуулдаг. Эдгээрийг “Шүүхийн тухай” болон “Прокурорын байгууллагын тухай” хуульд тусгайлан авч үздэг. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд “Иргэн хүн төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх, эрх нь зөрчигдсөн гэж үзвэл түүнийгээ хамгаалуулахаар шүүхэд гаргах, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх эрхтэй, мөн гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэж буруутайд тооцож үл болно” гэсэн зарчмын заалт нь шүүх эрх мэдлийн чухал баримтлал, эх сурвалж болдог.

4. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 40.1.4-д хэлгүй, дүлий, хараагүй зэрэг эрхтэн дутуу буюу сэтгэцийн өвчний улмаас өөрийгөө өмгөөлөх эрхээ эдэлж чадахгүй нөхцөлд өмгөөлөгч болон хэлмэрч, дохионы орчуулагчийг заавал оролцуулах талаар заасан нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурор, шүүхийн аль ч шатанд хэвийн явагдаж байна. Гэвч шүүхийн практикт шүүхээр шийтгэгдэж байгаа хэргийн хэдэн хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байгааг харуулах бүртгэл судалгаа байхгүй байна.

5. Сүүлийн жилүүдэд гэмт хэргийн тоо өсөх хандлагатай, буурахгүй байгаа нь нийгмийн сэтгэл зүйг зовоох асуудал болж байгаа бөгөөд нөгөө талаас гэмт хэргийн илрүүлэлт сайжирч байгааг энд тэмдэглэх нь зүйтэй.

4. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ БА ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ

4.1. Олон улсын хүний эрхийн хэм хэмжээг хүлээн зөвшөөрөх талаар:

6. Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхтэй холбоотой олон улсын Үндсэн баримт бичгийн талаарх мэдээллийг энэ хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2. Монгол Улсын нэгдэн орсон, одоо мөрдөгдөж буй НҮБ-ын хүний эрхэнд холбогдох үндсэн конвенци, протокол

	Конвенцийн нэр	Нэгдэн орсон/ соёрхон баталсан он
1	Боловсролын талаар алагчлахтай тэмцэх тухай конвенци (1960) Convention Against Discrimination in Education	1964
2	Арьс, үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай ОУ-ын конвенци (1966) International Convention on the Elimination of All Forms of Racial Discrimination	1969
3	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966) International Covenant on Civil and Political Rights	1974
4	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай ОУ-ын пакт (1966) International Covenant on Economic, Social and Cultural Rights	1974
5	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенци (1979) Convention on the Elimination of All Forms of Discrimination against Women	1981
6	Хүүхдийн эрхийн тухай конвенци, түүний нэмэлт протокол (1990) Convention on the Rights of the Child and its Optional Protocol	1990
7	Иргэний болон улс төрийн тухай ОУ-ын пакт түүний нэмэлт I протокол (1976) Optional Protocol to the International Covenant on Civil and Political Rights	1991

8	Сайн дурын үндсэн дээр гэрлэх, гэрлэх насны доод хязгаар болон гэрлэлтийг бүртгэх тухай конвенц (1962) Convention on Consent to Marriage, Minimum Age for Marriage and Registration of Marriages	1991
9	Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц (1993) Convention on Protection of Children and Cooperation in Respect of Intercountry Adoption	1998
10	Эрүүдэн шүүх болон бусад бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенци (1984) Convention Against Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment	2000
11	Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчилахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол (2000) Optional Protocol to the Convention on the Rights of the Child on the Sale of Children, Child Prostitution and Child Pornography	2003
12	Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол (2000) Optional Protocol to the Convention on the Rights of the Child on the Involvement of Children in Armed Conflict	2004
13	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц (2006) Convention on the Rights of Persons with Disabilities	2009
14	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенци, түүний нэмэлт протокол (2006) Optional Protocol to the Convention on the Rights of Persons with Disabilities	
15	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай ОУ-ын пактын нэмэлт протокол (2008) Optional Protocol to the International Pact on Economic, Social and Cultural Rights	2010

Хүснэгт 3. Монгол Улсын нэгдэн орсон, одоо мөрдөгдөж буй ОУХБ-ын конвенциуд:

	Конвенцийн нэр	Нэгдсэн/ батламжилсан он
1	Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай конвенц (87) Freedom of Association and Protection of the Right to Organize Convention	1969
2	Хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах тухай конвенц (98) Right to Organize and Collective Bargaining Convention	1969
3	Тэгш шан хөлс олгох тухай конвенц (100) Equal Remuneration Convention,	1969
4	Эхчүүдийг хамгаалах тухай конвенц (103) Maternity Protection Convention	1969
5	Алагчлахгүй байх тухай конвенц (111) Discrimination (Employment and Occupation) Convention	1969
6	Үйлдвэрийн газарт ажилчдын төлөөлөгчдийн эрхийг хамгаалах (135) Convention on Workers' Representatives	1974

7	Газар доор ажиллагчдын насны доод хязгаарын тухай (123) Minimum Age (Underground Work) Convention	1981
8	Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай (138) Minimum Age Convention	1981
9	Гурван талт зөвлөлдөөний тухай (144) The Tripartite Consultation (International Labour Standards) Convention	1998
10	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай (155) Convention of the Occupational Safety and Health	1998
11	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах тухай (182) Convention of the Worst forms of Child Labour	1998
12	Тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай (159) Convention 159, Vocational Rehabilitation and Employment of Disabled Persons	2002
13	Албадан хөдөлмөрийн тухай (29) Convention of Forced or Compulsory Labour	2005
14	Албадлагын хөдөлмөрийн хориглох, устгах тухай конвенц (105) Convention on Abolition of Forced Labour	2005
15	Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай (122) Employment Policy Convention	2005

4.2. Үндэсний хууль тогтоомжинд хүний эрхийг хамгаалах талаар тусгагдсан байдал:

7. Монгол Улсын Үндсэн хуульд иргэдийн эдлэх эрх, эрх чөлөөг бие даан бүлэг болгон тодорхойлсны дотор амьд явах эрх (16); ажил мэргэжлээ чөлөөтэй сонгож, хөдөлмөрийн аятай нөхцөл, цалин хөлсөөр хангагдах, амрах эрх (16-4); өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, хүүхэд төрүүлэх, асрах, тодорхой нөхцөлд эд, мөнгөн тусламж авах эрх (16-5); эрүүл мэндээ хамгаалах, эмнэлгийн тусламж авах эрх (16-6); сурч боловсрох, ерөнхий боловсролд төлбөргүй суралцах эрх (16-7)-ийг тодорхой заасан байна.

8. Дээрх эрхүүдийг бодитойгоор эдлүүлэхийн тулд тусгай салбар хуулиудыг батлан гаргасан. Үүнд; "Хөдөлмөрийн тухай хууль" (2008); "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль" (2008); "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль" (2006); "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль" (2010); "Нийгмийн халамжийн багц хууль" (2005); үүний дотор ("Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль" (2005), "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай" (2005), "Нийгмийн даатгалын багц хууль" (2008); үүний дотор "Нийгмийн даатгалын сангаас олгох ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмжийн тухай" (2008); "Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль" (2008); орно- "Эрүүл мэндийн тухай хууль", "Боловсролын тухай хууль" (багц-1995).

9. Нийгмийн эмзэг болон өвөрмөц хэрэгцээт бүлэг болох хүүхэд, эмэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хамгааллын талаар батлан хэрэгжүүлж байгаа хуулиудын дотор 2006 батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай" хууль чухал байр

суурийг эзэлдэг. Тус хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хүүхдэд нийгмээс хэрхэн туслах, тэдний эрүүл мэнд, сэргээн засалтын дэмжлэг яаж үзүүлэх, боловсрох, мэргэжил эзэмших зэрэг асуудлыг тодорхой тусгасан.

10. Тухайлбал тус бүлгийн хүмүүст төрөөс нийгмийн халамжийн дараахь агуулга бүхий тусламж, хөнгөлөлтийг үзүүлэхээр заасан. Үүнд;

- Орон сууцны хөлс, түлшний үнийг хөнгөлөх
- Протез, ортопед, тэргэнцэр, бусад тусгай хэрэгслийн үнэ, тарифыг бүрэн буюу хагаслан чөлөөлөх/бууруулах
- Рашаан сувиллын эрхийн бичгийн үнийг хөнгөлөх, замын зардлыг хагаслах буюу бүтнээр даах
- Брайль үсгээрх ном хэвлэлийг тодорхой хязгаарт (10 кг гм) үнэ хөлсгүй тээвэрлэх
- Нийтийн тээврийн хэрэгслээр (таксинаас бусад) үнэгүй зорчих гэх мэт.

11. Хүний эрхийн хамгаалалтын чухал хэрэглүүр нь хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага юм. Энд дурдсан бүх хуульд хохирогсдод нөхөн олговор, алдагдсан боломжийн төлбөр хийх болон зөрчигч этгээдэд хүлээлгэх хариуцлага аль нэг хэмжээгээр туссан байдаг боловч амьдралд эдгээрийг хэрэглэхгүй өнгөрөөх, хохирогсод ч эрхээ бүрэн мэддэггүйн улмаас гомдол, нэхэмжлэл гаргахгүй байх, нөгөө талаас хариуцлагын хэмжээ ч хангалттай биш байгааг заан тэмдэглэдэг.

12. Дээрх хуулиудаас харахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, хөгжил, хамгааллын талаар холбогдох эрх зүйн орчин харьцангуй сайн бүрдсэн хэдий ч хуулийг нэг мөр хэрэгжүүлэх хариуцлагын тогтолцоо хэт сул байгаа нь сөргөөр нөлөөлж байна. Жишээ нь: “Барилгын тухай” хуулийн 10.1.3-д барилгын зураг төсөлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг хангах арга хэмжээг тусгасан хэдий ч уг заалтыг зөрчсөн иргэнд 250,0-500,0 төгрөг, хуулийн этгээдэд 1000,0-2000,0 төгрөгийн мөнгөн торгууль оногдуулахаар заасан нь хэт чамлалттай байна.

“...Иргэний барилгын болон явган хүний замын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагыг тусган тооцох талаарх стандартууд 2010 оны 2 дугаар сараас мөрдөгдөж эхэлсэн боловч хэрэгжилтэд тавих хяналт сул, зөрчлийг илэрүүлэх, хариуцлага тооцох байдал сулаас хэрэгжилт хангалтгүй байна...”

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын тус илтгэлд өгсөн саналаас

4.3. Үндэсний түвшинд хүний эрхийг хөхиүлэн дэмжих талаар:

13. Иргэдийн эрх, эрх чөлөөг хуулиар хамгаалах явдлыг хэрэгжүүлэх нь иргэдийг эрхээ эдлэхүйц чадамжтай болгох, энэ талаар төр, олон нийтийн зүгээс зүйл бүрээр дэмжихээс ихээхэн шалтгаалах учрыг Монголын төр засаг ойлгосны үндсэн дээр чухал арга хэмжээ авсаар ирсэн. Үүнд хууль тогтоогч, гүйцэтгэгч байгууллагаас бодлого, стратеги боловсруулж, хөтөлбөр, хууль тогтоомжоор баталгаажуулах, шаардлагатай төсөв хөрөнгө хуваарилах, сургалт боловсруулалт, хэвлэл нийтлэл, мэдээлэл сурталчилгаа хийх, хүний эрхийн ерөнхий болон тусгай, бүлгийн ашиг сонирхлын төрийн ба төрийн бус байгууллага ажиллуулах зэрэг олон талт, арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

14. Төрийн эрх барих болон гүйцэтгэх дээд байгууллагын (УИХ болон Засгийн газар) бүтцэд Хүний эрхийн Үндэсний комисс, Хүүхдийн төлөө Үндэсний Газар зэрэг албан байгууллага ажилладаг бөгөөд Ерөнхий сайд болон сайдын түвшний өндөр албан тушаалтнаар толгойлуулсан Өрхийн амьжиргааг дэмжих; Хүүхдийн эрхийг хамгаалах; Мэргэжлийн боловсрол сургалтын; Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн зэрэг орон тооны бус Үндэсний хороод ажлын албадтайгаар ажиллаж байгаа. Боловсролын, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн, Эрүүл мэндийн, Дэд бүтцийн зэрэг төрийн яамдад хүний эрхийг хэрэгжүүлэх ерөнхий ба мэргэжлийн чиг үүрэг бүхий агентлагууд ажиллаж байна.

15. Нийгмийн эмзэг, өвөрмөц хэрэгцээт бүлгийнхэн, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хууль ёсны эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг, үзүүлэх талаар Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид тодорхой, чиг зорилготой заалтууд туссан. Тухайлбал:

- “Хөдөлмөрийн тухай” хуульд: Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны ажлын цагийг богиносгох, ээлжийн амралтыг уртасгах, аж ахуйн нэгжид хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах квот тогтоох, биелүүлээгүй тохиолдолд торгууль/төлбөр ногдуулах
- “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хуульд: ажил олгогч нарт хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулсны хөлсний зохих хувийг (60 хувь) нөхөн төлөх, мөн тус ажилтныг 1 жилээс илүү хугацаагаар ажиллуулбал хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 болон 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшуулал олгох
- “Боловсролын тухай” болон “Сургуулийн өмнөх боловсролын тухай” хуульд: Монгол Улсын иргэний боловсрол нь суралцагчийн хэрэгцээ, хувийн болон хөгжлийн онцлогт нийцсэн олон хувилбартай байх, хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгт ердийн бүлгийн

хүүхдүүдтэй, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 2 хүртэл хүүхэд нэг бүлэгт байж болох

- “Барилгын тухай” хуульд: барилга байгууламж нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг хангасан байх, барилгын зураг төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг хангах арга хэмжээг тусгасан байх
- “Хот байгуулалтын тухай” хуульд: дэд бүтцийн байгууламжуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст саад болохгүй нөхцөлийг хангах төлөвлөлтийг норм болон дүрэм, журамд заасныг баримтлах, ийм нөхцөлийг хангаагүй хот төлөвлөлт болон барилгажилтын шийдэл, зураг төсөл, интернетийн, нийгмийн дэд бүтцийг барьж байгуулах аливаа төсөлд зөвшөөрөл олгохыг хориглох
- “Авто тээврийн тухай” хуульд: нийтийн тээврийн хэрэгслээр зорчиж байгаа хараагүй хүнд зориулж буудлыг зарлах, сонсголын бэрхшээлтэй иргэнд зориулж, буудал бүрт нэр, хаяг, чиглэлийг бичмэл буюу зургийн хэлбэрээр байрлуулах, өөрчлөх шийдвэрийг тухайн шатны Засаг дарга гаргана.
- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хуульд: Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийгмийн харилцаанд оролцох, өөртөө үйлчлэх, бие даан хөгжихөд зориулсан сэргээн засалт хийлгэх эрхтэй. Үүнийг эмнэлэг, сувилал, сургууль, аж ахуйн нэгж (ортопед, протезийн) эрхлэх үүрэгтэй, аливаа сургуульд хөгжлийг бэрхшээлтэй хүүхдийг элсүүлэх, шалгалтад оруулахаас татгалзаж болохгүй; хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургадаг багш нарт цалингийн нэмэгдэл (10-30 хувь) олгоно; гэж тус тус заасан байна.

16. Төрийн албан хаагч, удирдах ажилтны хүний эрх, түүний дотор эмзэг, онцгой бүлгийнхний эрх, хамгаалал, хөхиүллийн талаарх мэдлэгийг сайжруулах зорилгоор ном хэвлэл олшруулж тараах, семинар сургалтад хамруулах зэргээр олон талт арга хэмжээ авагддаг хэдий ч эдгээрийн чанар, үр дүн хангалтгүй байгаа талаар олон нийтийн болоод зорилтот бүлгийнхний зүгээс багагүй шүүмжлэл гарсаар байна.

- Эдгээр асуудлаар Монгол Улсын Засгийн газраас олон талт арга хэмжээ авсаар байгаа хэдий ч Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар гаргасан хөтөлбөр, стратеги, холбогдох хуулиуд Засгийн газрын бүх түвшний байгууллага, олон нийтийн дунд нэг мөр цэгцтэй ойлгогдож, төлөвшөөгүй байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүн галт тэрэг, онгоц зэрэг нийтийн тээврээр хот хооронд зорчих нь дэмжлэг үзүүлэх тухай заалт бүхий хууль, тогтоомж байхгүйгээс хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүн төрсөн нутаг орноосоо гадагш гарч өөр газарт хүрч чадахгүй, эмнэлэг, рашаан сувилалд сувилуулах, мэргэжлийн бүх төрлийн сургуульд элсэн суралцах зэрэг нийгмийн үйлчилгээ хүртэх боломж хаалттай байна.

17. Түүнчлэн олон нийтийн болон хувийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдлэг, мэдээлэл хүргэх, тэдгээрт эрхээ ухамсарлах, холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулахад зориулсан нэвтрүүлгийн цаг гаргах, дохионы хэлтэй нэвтрүүлэгч ажиллуулах явдал өмнөх үеэс харьцангуй нэмэгдэж, чанар нь сайжирч байгаа хэдий ч энэ нь бодит хэрэгцээ, шаардлагад нийцэхгүй байна. Брайль үсгийн стандарт тогтоолт, сургалт, ном хэвлэлт, тараалт удаашралтай хөгжиж байна.

18. ХЭҮК 2010 онд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар мэдээллийг олон нийтэд түгээх нь” төслийг Европын холбоо, Раул Фолерогийн анд нөхдийн холбоо, Италийн засгийн газрын бус байгууллага /АИФО/-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн байна. Уг төслийн хүрээнд хийгдсэн ажлууд нь бүхэлдээ олон нийт, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрийн байгууллагын албан хаагч нарт хандсан цогц мэдээлэл, сурталчилгааны ажлууд байсан байна. Мөн түүнчлэн тус комиссоос 2011 онд “Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хэрэгжилт” судалгааны ажлыг хийхээр төлөвлөсөн байна.

19. Хүний эрх, эрх чөлөө, ялангуяа эмзэг, тусгай бүлгийн иргэдийн эрх ашгийг хамгаалж, дэмжихэд төр, олон нийт, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын хамтын ажиллагаа, харилцан туслалцаа их үүрэгтэйг Монгол Улсын Засгийн газар ач холбогдолтойд үзэж, багагүй арга хэмжээ авч байгаа талаар хойно уг илтгэлийн Тусгай заалт бүхий хэсэгт тодорхой тусгасан. Мэдээжээр улам сайжруулж, үр дүнд хүргэх шаардлага тавигдаж байна.

5. АЛАГЧЛАХГҮЙ БАЙХ, ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР

20. Хүн аль ч байдлаараа алагчлуулахгүй байх эрх зүйн үндэс нь Үндсэн хууль болон өмнө дурдсан суурь болон салбар хуулиудад холбогдох заалтаар тусгагдсан байдаг бөгөөд шууд нэр зааж дурдаагүй ч нийтлэг хамрах утгаараа алагчлахын эсрэг заалт үйлчилж байна. Тухайлбал Үндсэн хуульд: “Хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэж заасны дотор бие, эрхтэн, хөгжлийн онцлог гэсэн нэр томъёо байхгүй байгааг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөлөл анхааруулж байна. Үүнд хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна гэсэн Үндсэн хуулийн өөр нэг заалтад энэ болон бусад онцлог шинжүүд хамаарна гэж холбогдох мэргэжилтнүүд тайлбарладаг юм. Үндсэн хуульд нэр заагдаагүйн улмаас бусад бодлого, хуульд болон нийгмийн харилцаа, үйл ажиллагаанд

алагчлалыг өдүүлсэн болон өөгшүүлсэн зүйл гараагүй нь үүнийг батлах юм. Алагчлахын эсрэг заалт хууль тогтоомжинд ийнхүү хангалттай туссан ч амьдралд алагчлал аль нэг хэлбэрээр тухайлбал, “чимээгүй өнгөрөх”, зохих нөхцөл, стандартыг хангалттай бүрдүүлэхгүй юм уу бүрдүүлсэн зарим нормоо үл биелүүлэх, нийтэд нь хавтгайруулж тэгшитгэн хандах зэргээр тодорхой хэмжээгээр байсаар байгаа юм.

...Хууль, эрх зүйн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн илэрхий гадуурхаагүй боловч тэдний оролцоонд учирч буй саадыг арилгахад чигэлсэн арга хэмжээ хангалтгүй байгаагийн улмаас эдгээр хүмүүс, ялангуяа төвөөс алслагдсан орон нутгийн иргэд нийгмийн бүхий л харилцаанд тэгш оролцож чадахгүй, далд алагчлалд өртсөөр байна. Жишээ нь: орон нутагт амьдардаг харааны бэрхшээлтэй иргэд мэдээлэл авах боломж туйлын хомс, мөн дэд бүтэц хүртээмжгүйгээс тэргэнцэртэй иргэд гэрээс гарах боломжгүй, гадуурхагдсаар байна...

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын тус илтгэлд өгсөн саналаас

6. КОНВЕНЦИ БА ҮНДЭСНИЙ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛ

21. Үндэсний хууль тогтоомж ба бодлогыг Монгол Улсын нэгдэж орсон ХБХЭК-ийн заалтуудтай нийцүүлэх талаар сүүлийн 2 жилд зохион байгуулсан. Зарим үйл ажиллагаанаас энд дурдлаа. Үүнд: НҮБХХ-ийн “Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх төсөл” II үе шатны 4 дүгээр бүрэлдэхүүн хэсэг болгож, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм эдийн засгийн амьдралд татан оруулахад шаардлагатай бодлого, хөтөлбөрийн бүтцийг сайжруулах ажлыг НҮБХХ-ийн зөвлөхийн оролцоотойгоор манай үндэсний мэргэжилтнүүд хийж гүйцэтгэсэн байна. Энэ судалгааны ажлын үндсэн нэг хэсэг нь ХБХЭК-ийн гол гол заалтыг манай дотоодын хууль тогтоомжтой харьцуулах явдал байсан юм. Уг харьцуулсан судалгааны тайланд Монгол Улсын дотоодын хууль тогтоомжууд ХБХЭК-д тусгагдсан зөвлөмжтэй ерөнхийдөө тохирч байна. Конвенцийн ихэнх хэсгийн хувьд Монгол Улсын хууль тогтоомжуудыг түүний мандатын түвшинд, эсвэл хэрэгжилтийг сайжруулах, нэмэлт арга хэмжээ авснаар уг түвшинд хүрэх боломжтой гэж үзжээ.

22. Гэхдээ конвенцийн ба Монгол Улсын хууль тогтоомжид тусгасан зарим зүйл заалтуудын хооронд багагүй зай завсар байгааг цохон дурдсан байна. Үүнд:

- 9 дүгээр зүйл – Хүртээмж: Хуулийг хагас дутуу биелүүлж байгаа учраас хуулийн заалт ба бодит байдал зөрүүтэй.
- 19 дүгээр зүйл – Бие даан амьдрах болон тухайн сүүгаа орчиндоо байх эрх: Монгол Улсын хууль тогтоомж, бодлого хүй илгэнээр (community)

амьдарч үйлчлүүлэх эрхийг хязгаарлаж буйн улмаас энэ талаар суурь шинжтэй өөрчлөлтийн шалтгаан болж чадахгүй байна.

- 24 дүгээр зүйл – Боловсрол: Монгол Улсын Боловсролын тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах, боловсрол олж авах эрхийг хамгаалсан тусгай зүйл байхгүй буюу хүүхдийн бүрэн чадамжийг хөгжүүлэхэд чиглэсэн заалт байхгүй байна.
- 27 дугаар зүйл – Ажил, хөдөлмөр эрхлэлт: Монгол Улсын хууль тогтоомжоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэргэжлийн сургалт, санал нэгдсэн ажиллагаа, ажлын байр хадгалах зэрэг асуудлаар тэгш, жигд арга хэмжээ авахгүй байна.
- 28 дугаар зүйл – Амьжиргааны хүрэлцэхүйц түвшин, нийгмийн хамгаалал: Монгол Улсын хууль тогтоомж, эдийн засаг, нийгмийн хамгааллыг хүний эрхийн хэмжээнд авч үздэггүй.

Эдгээр үндсэн зүйл эс нийцлээс гадна хөгжлийн бэрхшээлтэй хүний тодорхойлолтын талаарх зүйлд дотоодын хууль тогтоомжид оролцох чадварыг хязгаарласан санаа байгааг дээр дурдсан судалгаа илрүүлсэн байна. (Үндсэн баримт бичгийн илтгэлийн хавсралт . . үзнэ үү)

23. Монгол Улс 2009 онд ХБХЭК-д нэгдэн орохоос өмнө болон хойно хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих талаар бодлого, хууль, эрхийн баримт бичгүүдийг шинээр боловсруулах болон нэмэлт өөрчлөлт оруулах чиглэлээр багагүй арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар боловсруулан 2008 онд батлагдсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох таатай орчныг бүрдүүлэх тухай заасан.
2. Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ая тухтай амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлж, эрхийг нь хүндэтгэсэн нийгмийн орчныг бүрдүүлж, тэднийг нийгмийн амьдралд бусад иргэдийн адил оролцох нөхцөл боломжийг хангасан орчны дэд бүтцийг бүрдүүлэхийг зорино” гэж заасан.
3. Засгийн газраас баталсан Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрийн 2.4.6-т “Тусгай хэрэгцээ, онцлог эрх ашиг бүхий бүлгийн эрхийг хангах” талаар тусгай заалтууд тусгагдсан бөгөөд үүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой Засгийн Газрын төлөвлөгөө

(2007-2008, 2009-2010 он) түүний хэрэгжилт болон 2011-2012 оны төлөвлөгөөнд тодорхой үйл ажиллагаанууд тусгагдсан байна.

4. 2008 онд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрсэн хүний дотоодод хийлгэсэн протез, ортопед, тэргэнцэр, тусгай хэрэгслийн үнийг тодорхой заасан хугацаанд нэг удаа бүрэн чөлөөлж байхаар заасан.
5. Засгийн газрын 2009 оны 26 дугаар тогтоолоор “Хөдөлмөрийн тухай” хуулийн 111 дүгээр зүйлд заасан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах квотыг хангаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас Хөдөлмөр, эрхлэлийг дэмжих тусгай санд татан төвлөрүүлэх хөрөнгийн норматив хэмжээг тогтоосон нь эдгээр иргэдийг ажлын байраар хангах хариуцлагын чухал хөшүүрэг болж байна.
6. 2008 онд батлагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрны нөхцөл нь тэдний хөдөлмөрлөх чадварт тохирсон, орж гарахад саад болохооргүй байдлаар тоноглогдсон байх шаардлагыг ажил олгогч заавал бүрдүүлэх тухай заалт оржээ. (16 дугаар зүйл)
7. 2008 батлагдсан “Сургуулийн өмнөх боловсролын тухай” хуулийн 9.10-т хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгт ердийн хүүхдүүдтэй хамт сургаж байх, нэг бүлэгт ийм төрлийн 2 хүртэл тооны хүүхэд байж болохыг заасан байна.
8. БСШУЯ-ны ТНБД-ын 2010 оны 325 дугаар тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг илрүүлэх, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын цогц үйлчилгээ арга зүй, аргачлал боловсруулан зарим цэцэрлэг, сургуульд туршин хэрэгжүүлж байна.
9. БСШУЯ-ны ТНБД-ын 2009 оны 328 дугаар тушаалаар 2012 он гэхэд “Монгол хэлний дохионы хэлний стандарт” боловсруулан батлуулах үүрэгтэй холбогдох яамд, төрийн болон ТББ-ууд, мэргэжилтнүүдийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.
10. Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 279 дүгээр тогтоолоор “Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хамт батлуулан хэрэгжүүлж байгаа нь хүн амыг хөгжлийн бэрхшээлтэй болохоос

урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны нэгээхэн хэсэг болж байна.

11. ЭМ-ийн сайд, НХХ-ийн сайдын 2009 оны 303/126 тоот хамтарсан тушаалаар “Дүлийрэлт, сонсгол бууралтаас сэргийлэх, хянах” Үндэсний стратеги батлагдан хэрэгжиж байна.
12. ЭМ-ийн сайдын 2009 оны 221 дүгээр тушаалаар “Сэргээн засах бүтэц, үйл ажиллагааны стандарт” батлаж, хоёр дахь шатлалын эмнэлгүүдэд нэвтрүүлжээ.
13. Мөн ЭМ-ийн сайдын 2009 оны 264 дүгээр тушаалаар “Зонхилон тохиолдох өвчний сэргээн засах оношлогоо, эмчилгээний удирдамж”-ийг батлан мөрдүүлж байна.
14. 2008 онд батлагдсан “Хот байгуулалтын тухай” хууль (20.2, 20.2)-д хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нийгмийн дэд бүтцийн байгууламжуудад саадгүй хүрэх нөхцлийг хангах норм, дүрэм, журмуудыг баримтлах, энэ шаардлагыг хангаагүй барилга, байгууламжийн төсөлд зөвшөөрөл олгохгүй тухай заалт оруулсан байна.
15. 2009 онд “Иргэний барилгын төлөвлөлтөнд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай” MNS 91.040.10 стандарт, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг тооцсон төлөвлөлт” Барилгын норм ба дүрэм нормыг батлан гаргажээ.
16. 2008 онд “Авто тээврийн тухай” хуульд “Нийтийн тээврийн хэрэгслээр зорчиж байгаа хараагүй хүнд зориулж буудлыг зарлах, сонсголын бэрхшээлтэй иргэнд зориулж буудал бүрт нэр, хаяг, чиглэлийг бичмэл болон зургийн хэлбэрээр байрлуулах”, “20 ба түүнээс дээш нийтийн тээврийн хэрэгсэлтэй тээвэрлэгчийн тээврийн хэрэгслийн 10-аас доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тээвэрлэхэд зориулагдсан байх” гэсэн заалтуудыг тус тус нэмж оруулсан байна. (7.4 ба 10.2.8)
17. Дээрх заалтын дагуу 2009 онд улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан их багтаамжийн 400 автобусанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай суудлыг бий болгон мөн хараагүй хүмүүст зориулж буудлыг зарлах, төхөөрөмжийг суурилуулан ашиглаж байна. Сонсголын бэрхшээлтэй иргэдэд

зориулж буудал бүрт нэр, хаяг чиглэлийг бичмэл болон зургийн хэлбэрээр байрлуулах ажлыг хийж байна.

18. 2008 онд баталсан “Гаалийн тариф, гаалийн татварын тухай” хуулийн 38.11 дэх заалтаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл, тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгсэл, хиймэл эд эрхтэн, тэдгээрийн эд ангийг үйлдвэрлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, түүхий эд зэргийг импортлоход гаалийн татвараас бүрэн чөлөөлөх, энэ зорилгоор хүмүүнлэгийн чиглэлээр орж ирсэн буцалтгүй тусламжийн барааг татвараас чөлөөлөх тухай заалт орсон байна.
19. Сонгуулийн ерөнхий хорооны 2009 оны 05 дугаар тогтоолоор “Саналын хайрцгийг хөгжлийн бэрхшээлтэй сонгогч санал өгөх боломжтой байдлаар байршуулах, санал бэлтгэх тасалгааг хөгжлийн бэрхшээлтэй болон бусад сонгогч саналаа нууцаар тэмдэглэх боломжтой байдлаар бэлтгэх” тухай шийдвэрлэжээ.
20. 2009 оны УИХ-ын 95 дугаар тогтоолоор баталсан “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого”-ыг үндэслэн 2011 онд Засгийн газраас баталсан “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр”-т биеийн тамирыг хүн амын өдөр тутмын хэрэглээ болгох, дундаж наслалтыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд “биеийн тамир, спортоор дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж заасан.
21. АНДЭЗНК/ДБ/ДЭМБ-ын хамтарсан Ази, номхон далайн бүс нутгийн орнуудын “Хөгжлийн бэрхшээлийн статистикийг сайжруулах” төслийн хүрээнд оролцогч улс орнуудын нэг нь Монгол Улс байсан бөгөөд хөгжлийн бэрхшээлийн талаарх асуултуудын багц турших судалгааг 2009 оны 7 дугаар сард Үндэсний статистикийн хороо зохион байгуулж явуулсан байна.
22. Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөрийн 4 дүгээр зорилтын 25 дугаар зүйлд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчдыг гэр бүл, хамт олонд тулгуурласан нөхөн сэргээх эмчилгээний арга барилд сургах сургалт, сурталчилгааг өргөжүүлэх “ гэж заасан.
23. Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх стратегид /2010-2015 он/ “Хүүхдийн төлөө хэлтэс, эмнэлэг, цэцэрлэг, сургууль, сургалт, хөгжлийн төв, зуслан, асрамж, халамж, хамгааллын төв болон бусад байгууллагад хүүхэд хамгааллын бодлого, дүрэм,

журамтай ажиллахыг мөрдүүлэх” гэж заасны дагуу тусгай боловсрол олгож буй сургуулиуд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд хүүхэд хамгааллын үлгэрчилсэн журамтай болсон байна.

24. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 81 дүгээр тогтоолоор батлан хэрэгжүүлж буй “Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр”-ийн 2.4.6-д “Тусгай хэрэгцээ, онцлог сонирхол бүхий хүмүүсийг ялгаварлах, гадуурхах нийгмийн гаж сэтгэл зүй, хандлагыг өөрчлөхөд чиглэсэн ухуулга, сургалт, сурталчилгааг тогтмол явуулж, энэ ажилд тэдний өөрсдийн оролцоог хангах тухай” заасан бөгөөд энэ чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

24. НҮБ-ын нэр бүхий конвенци ба Монгол Улсын үндэсний хөтөлбөрүүд, хууль эрхийн баримт бичгүүдийн заалтыг хэрэгжүүлэх талаар багагүй арга хэмжээ авч, хэрэгжүүлсэн байна.

25. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлаар мэргэжлийн чадамжтай судалгааны багуудаар нилээд хэдэн судалгаа хийсэн нь өнөөгийн нийгэм дэх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн аж байдал, ажил хөдөлмөр, сэтгэл санааны байдлыг илрүүлж тодорхойлоход шууд чиглэснээрээ үндэслэлтэй бодлого, арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэхэд дөхөм болж байна. Эдгээрээс заримыг нэрлэвэл: Мерси Кор ОУБ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр хийсэн судалгааны тайланд дурдахдаа Монгол Улсын хууль тогтоомжинд ХБХ-ийг эрх бүхий субъект гэх хандлагаар биш, халамж, өглөг хүртэгчдийн байр сууринаас үзэх нь зонхилдог ба энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүний тодорхойлолтод тусгагдсан нь гайхах зүйл биш¹ гэжээ. Мөн байгууллагаас хийсэн өөр нэг судалгаанаас үзэхэд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 46,6 хувь нь бусад хүүхэд шоолж дээрэлхдэгээс суралцахад төвөг, бэрхшээл тулгардаг гэсэн хийгээд ийн алагчлах хандлага сургуулийн өмнөх насны хүүхдийн эцэг эхийн дунд элбэг байдгийг тогтоосон байна.² Ийм төрлийн судалгаанд Судалгаа боловсролын хүрээлэн ТББ-ын хийсэн “ХБИ-ийн эрх ашгийг хамгаалдаг байгууллагуудын зураглал”, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэгээс хийсэн “Сонсголын бэрхшээлтэй, иргэдийн нийгмийн хэрэгцээг тодорхойлох” судалгааны тайланг дурдвал зохино.

¹ “ХБИ-ийн нийгмийн үйлчилгээний хөгжил: дэд бүтэц ба үйлчилгээний хамаарлын судалгаа” тайлан Мерси Кор ОУБ 2009

² Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох, хөдөлмөрлөх эрх судалгааны тайлан 2009

26. Өмнө өгүүлсэн Засгийн газрын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийсэн НХХЯ-ны тайлангаас үзвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэний үүсгэл санаачлагыг дэмжин ажилласны үр дүнд тэдний нийгмийн амьдралд орох оролцоо урьд өмнөхөөс нэмэгдэж; цөөнгүй хот тосгодод хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст явах зорчих боломжтой зам, шат, гарц шинээр тавигдаж; мэдээлэл харилцаа холбооны техник хэрэгслийн хангамж мөн мэдэгдэхүйц сайжирснаар тэдний мэдээлэл хүртэх боломж нэмэгдсэн байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг мэргэжлийн сургалтаар эрэлт хэрэгцээтэй мэргэжил эзэмшүүлэх, хувиараа хөдөлмөр эрхлэх явдлыг нь санхүү, материаллаг хэрэгслээр дэмжих арга хэмжээ өргөжсөний үрээр тэдний орлоготой хөдөлмөр эрхлэлтийн түвшин мэдэгдэхүйц дээшилсний зэрэгцээ сурч боловсрох, мэдээллээр хангах орчинг сайжруулах, тэдний бие махбодь, оюун ухаан, мэдрэлийн гэмтэл согог үүсэхээс сэргийлэх талаар Үндэсний ба мөрийн хөтөлбөрт заасан зорилтуудыг хэрэгжүүлэх талаар тодорхой хөтөлбөр, төслийн арга хэмжээний төрөл хэлбэр олширч, хэмжээ далайц нь нэмэгдэж буй нь тодорхой харагдаж байна. Энэ талаар хойно илтэлийн Тусгай заалт бүхий баримт бичгээс тодорхой харж болох ба энд жишээ болгож хэдэн баримт дурдвал:

- Сүүлийн 2 жилд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зорилготой нийт 516 төсөл шалгаруулж, бүгд нэг тэрбум гурван зуу орчим сая төгрөгийн санхүүжилт хийж, үүний үр дүнд 1800 гаруй ажлын байр бий болсны 1130 орчимд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, бусдад нь тэдний гэр бүл, асран хамгаалагчид ажиллаж байна.
- “Боловсролын тухай” хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бусад хүүхдүүдтэй хамт сургах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоогоор хувьсах зардлыг нэмэгдүүлэх, багшид нэмэгдэл хөлс олгох тухай журам тогтоосон байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн хамгааллыг сайжруулах зорилтын хүрээнд 2008-2010 оны 3 жилд зарцуулсан мөнгөн хөрөнгийн хэмжээ өмнөх 5 жилийнхээс даруй 63 хувиар давж гарсан байна.
- 2009 онд олон нийтэд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг орон нутагт хөгжүүлэхэд зориулж 2115 хүнийг хамарсан арга хэмжээнд 175,4 сая төгрөг зарцуулжээ.
- 2010 онд НҮБ-ын хүний эрхийг хангах төслийн газар, ТББ-ууд хамтран иргэний нийгэм, ОУБ, иргэдийн дэмжлэг тусалцаатайгаар “Ялгаатай байдлаа хүлээн зөвшөөрч, алгачлах явдлыг таслан зогсооё” сэдэвт нэг сарын аян зохиожээ.

- Стандарт хэмжил зүйн газраас “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай орчин”; “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан замыг төлөвлөх заавар” үндсэн шаардлагыг батлан гаргасан. (MNS 6056,NNS 6055)

27. 2006 онд Засгийн газрын 283 дугаар тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт, үнэлгээ-шинжилгээний мэдээллээс үзвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн тусгай сургуульд ирж очих унааны зардалд хөнгөлөлт үзүүлэх, үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ өсч байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох, хөгжих эрхийг хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэн ажиллаж байгаагийн илрэл юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бэрхшээлийн төрөлд тохируулан гар урлал, эсгий болон шүрэн урлал гэх мэт төрөл бүрийн сургалтуудад жил бүр хамруулж байгаа нь тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, мэргэжил олгох замаар амьжиргаанд нь дэмжлэг үзүүлэх зэрэг ач холбогдолтой юм³ гэжээ.

28. 2010 онд 06 дугаар сарын 17-ны өдөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж шинээр батлагдсан стандартыг олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагуудад танилцуулан, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилгоор “Мэрсис кор” олон улсын байгууллага, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөртэй хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчин ба стандартын хэрэгжилт” уулзалт семинар зохион байгуулж, “Иргэний барилгын төлөвлөлтөнд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин” MNS 91.040.10:2009, “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2009 стандартуудыг танилцуулж хэлэлцүүлэг хийсэн. Мөн “Явган хүн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замын хучилт, техникийн туршлага”, “Хүртээмжтэй орчин”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох болон хөдөлмөрлөх эрх” зэрэг сэдэвт илтгэлүүдийг хэлэлцүүлж, санал солилцсон байна.

29. 2009 оны байдлаар 17 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй 3 хүүхэд тутмын нэг нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй байгаагийн дотор 15 орчим хувь /1100 гаруй хүүхэд/ нь гэнэтийн аюул осол, эрсдэлд өртөн эрүүл мэнд, амь нас, сэтгэл санаагаар хохирч улмаар хөгжлийн бэрхшээлтэй болсон байгаа нь анхаарал татсан асуудал болоод байна. Иймд олдмол хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдлыг бууруулах зорилгоор хүүхдийн эсэн мэнд амьдрах эрхийг хангахад олон нийт, эцэг эхийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд бүх Талын хамтын ажиллагааг уялдуулан Монгол Улсын Шадар сайд, Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн дэд тэргүүний санаачилгаар **”Хүүхдийг болзошгүй**

³ НХХ-ийн Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын 2010оны 06 сарын 16-ны мэдээлэл

эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах” олон нийтийн санаачилгыг орон даяар өрнүүлэн ажиллаж эхлээд байна.

Олон нийтийн санаачилга өрнүүлэх удирдамж, ажлын хэсгийг Монгол Улсын Шадар сайд 2011 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр батлан, ажлын хэсгийн ахлагч, Эрүүл мэндийн дэд сайдын удирдлаган дор үйл ажиллагааны 5 дэд зөвлөл ажиллаж байна. Үүнд:

1. Нийгэм ахуйн ослоос урьдчилан сэргийлэх санаачилгын зөвлөл
2. Зам тээврийн ослоос сэргийлэх санаачилгын зөвлөл
3. Дарамт хүчирхийллээс сэргийлэх санаачилгын зөвлөл
4. Хүнд хөдөлмөрөөс сэргийлэх санаачилгын зөвлөл
5. Гамшгийн аюулаас сэргийлэх санаачилгын зөвлөл тус тус ажиллаж байна.

30. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг стандартын дагуу бий болгох ажлын хүрээнд жилд 2 удаа зохион байгуулагддаг “Архитекторын мэргэшсэн зэрэг горилогчдод зориулсан сургалт”-ын хөтөлбөрт дээрх чиглэлээр 2-4 цагийн хичээл тусгуулан зураг төсөл зохиогчдод энэ талын зохих мэдлэг олгож байна. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг тооцсон хэрэгжилт” БНБД нормыг 2011 онд боловсруулж дуусгахаар ажиллаж байна. Зураг төсөл зохиох үндсэн гарын авлага “Өндөр барилгын төлөвлөлт” БНБД31-17-10-ийг шинээр нэмэлт, өөрчлөлт оруулан боловсруулж, “Авто зогсоол” БНБД21-05-10, “Төмөр зам ба авто замын нүхэн байгууламж”, “Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт” зэрэг нормуудыг шинээр боловсруулж, батлуулахад бэлэн болсон ба тус нормуудад дээрх арга хэмжээний талаар тусгай заалтууд оруулж, зураг төсөлд магадлал хийх үед биелэлтийг хангуулан ажиллаж байна.

31. Өмнө дурдсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо баримтаас үзэхэд ердийн ба МШӨ-өөс урьдчилан сэргийлэх, тахир дутуу болсон нөхцөлд бие махбодь, оюун ухаан, сэтгэл зүйн чадварыг нөхөн сэргээх, хэвийн түвшинд хүргэх арга хэмжээг цогцолбороор авч хэрэгжүүлэх хөтөлбөрт зорилт шаардлагатай хэмжээнд хүрээгүй байна. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хуульд нийгмийн харилцаанд оролцох чадвараар нь хөгжлийн бэрхшээлийг тогтоохоор заасан. Гэтэл “Нийгмийн даатгалын тухай” хуулийн дагуу Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах төв комисс хөгжлийн бэрхшээлийг хөдөлмөрийн чадвар алдалтаар нь тогтоож байгаа бөгөөд хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг тухайн эрхтний үйлдлийн хязгаарлалтын хувиар тооцдог байна. Тухайлбал тус комиссын дүрэмд: “...Хөдөлмөрийн чадвар алдаж, хөгжлийн бэрхшээлтэй болсныг хөдөлмөрийн чадвараа хагас буюу 50-69 бүрэн буюу 70-аас дээш хувиар алдсан гэж ангилан тогтооно” гэж заасны улмаас бодлого үйл ажиллагааны зөрчил үүсдэг, үүнд халамжийн хуульд хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүмүүс нь тэтгэврээс гадна хөнгөлөлт эдлэхээр

тусгагдсаны дагуу дээрх хүснэгтэд байгаа согогтой бүх хүмүүс ижил төрлийн үйлчилгээ авах болж байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд хөдөлмөрийн чадвар алдалтын хувиа нэмүүлж 70 хувьд хүргэх, улмаар хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдах сонирхол төрүүлж, халамжийн хүрээг тэлж байна. Иймд хөгжлийн бэрхшээлийн зэргэмжийг тогтоох өнөөгийн аргачлалд бие махбодь, оюун ухааны согог дутагдлын зэрэг ба ажиллах чадварыг хольж хутгасан зүйл байгаа нь зарим талаар нөлөөлөх магадлалтайг анхаарч, залруулах шаардлага байгаа юм.

32. “Боловсролын тухай” хуульд Брайль ба дохионы хэл сурах, дүлий иргэдийн хэл соёлын илэрхийлэмжийг дэмжих, мөн хөгжлийн бэрхшээлтэй багш нарыг ажилд авах талаар тодорхой заалт байхгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг гэр бүл, амьдрах орчноос нь хөндийрүүлдэг гэгддэг тухай сургуулиудад олон нийтийн зүгээс шүүмжлэлтэй хандаж байна.

7. ЦААШИД ТАВИХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

33. Хууль, эрх зүйн орчныг сайжруулах талаар:

ХБХ-т чиглэсэн Үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үзэл бодлоо илэрхийлэх, тэдний мэдээлэл хүртэх эрх чөлөөг хангахад чиглүүлж “Хөдөлмөрийн тухай”, “Боловсролын тухай” хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах, Үндэсний хөтөлбөрүүдэд зохих засвар хийх;

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцах орчин, хамт олон дунд нийгэмшүүлэх асуудлыг тодорхой тусгасан зүйл заалтыг “Боловсролын тухай”, “Мэргэжлийн сургалт, боловсролын тухай” хуулиудад нэмж оруулах;

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөрлөх нөхцөл бололцоог илүү хангасан, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг зөв тодорхойлох зэрэг заалтуудыг “Хөдөлмөрийн тухай”, ҮОМШӨ-ний даатгалын тухай зэрэг хуулиудад тусгах;

Олон заалт хэрэгжихгүй байгаа нэг үндсэн шалтгаан болж байгаа хуулиудад санкци/хариуцлагыг орхигдуулсан буюу дутуу, хангалтгүй заасан зүйлийг нөхөх, чангатгахад чиглэсэн арга хэмжээ авах;

34. Хуулийн хэрэгжилт, хяналтыг хүчтэй болгох талаар:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэд бүтцийг бий болгох талаар холбогдох хуулиудад тусгасан заалтууд, норм ба дүрэм, стандартуудыг сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулах;

Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар бодитой ажил зохион байгуулахыг хариуцсан яамд онцгой анхаарах;

35. Зохион байгуулалтын талаар:

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээ шаардлагад нийцсэн дэд бүтцийг бий болгох, сайжруулах санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах:

Холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, зохицуулах арга хэмжээ авах:

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээ шаардлагад нийцсэн дэд бүтэц бий болгож байгаа олон улсын сайн туршлагыг судалж, нэвтрүүлэх:

Одоогоор Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаарх Үндэсний хороог төрийн болон төрийн бус байгууллагууд, нийгмийн зөвшлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан шинэчлэн байгуулаад байгаа бөгөөд уг хороо нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, хөгжил, хамгааллын асуудлаарх салбар хороодтой ажиллаж байна. Мөн уг хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллах орон тооны ажлын албыг байгуулаад байна.

Гэсэн хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах зорилготой тусгай агентлагийг байгуулж доорхи үүргийг хариуцуулах шаардлагатай байна.

- Шүүхэд татах эрх эдлүүлэх, хууль зөрчсөн тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хувь иргэнд давуу гарцтай нөхцөл бүрдүүлэх:
- Хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, ноцтой зөрчлийг мэдээллийн дагуу авч хэлэлцэх, шийдвэр гаргах:
- Энэ талаар зохих байгууллагад хандах, бусад институцтэй хамтран ажиллах:
- Эдгээр үүрэгтэй холбогдуулж эрх тэгш хөдөлмөр эрхлэх боломж олгох газар, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн газар зэргийн зайлшгүй бүтцийг бүрдүүлэх

ХОЁР. ТУСГАЙ ЗААЛТ БҮХИЙ БАРИМТ БИЧИГ

1. КОНВЕНЦИЙН ЕРӨНХИЙ ЗААЛТ (1-4)

1. Тодорхойлолт:

Монгол Улсын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хуульд [“Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж ойлгоно.”] гэж тодорхойлсон байдаг бол ЭМЯ “Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж бие бялдар, оюун санааны чадавх нь төрөлхийн болон олдмол шалтгаанаар дутмаг болсны улмаас нийгмийн болон хувийн амьдралын хэвийн шаардлагаа бие дааж хангаж чадахгүй хүнийг хэлнэ” гэсэн ДЭМБ-ын тодорхойлолтыг баримталж байна.

Дээрх зөрүүтэй тодорхойлолтуудаас хамаарч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн статистик тоо мэдээ зөрүүтэй гарч байна.

2. Конвенцид дурдсан байнгын гэж томьёолсон ойлголтыг өмнөх зүйлд иш татсанчлан Монгол Улсын хуульд бүрэн болон нэг жилээс дээш хугацаагаар авч үзсэн нь өнөөгийн нөхцөлд тохирно гэж үзэж байна. Мөн “боломжит хэрэглэгдэхүүн”, “түгээмэл загвар”-ын тухай ойлголтыг конвенцид заасан утгаар нь авч хэрэглэхэд хууль, журам, хэв заншлын хувьд саад болох зүйлгүй бөгөөд үндэсний хууль, тогтоомжид шууд тусган хэрэглэх боломжтой.

3. Конвенцийн зарчмууд үндэсний хууль тогтоомжид ерөнхийдөө бүрэн тусгагдсан гэж үзэж байгаа бөгөөд (d) болон (h) заалтуудыг үндэсний холбогдох баримт бичгүүдэд тодруулан оруулах боломжтой болно. Түүнчлэн конвенцийн зүйл заалтуудаас 9, 19, 24, 27, 28 дугаар зүйлүүдийг үндэсний хууль, тогтоомжид илүү нийцүүлэх, хэрэгжилтийг нь хангах явдал нэн тэргүүний асуудал гэж үзэж байна.

2. КОНВЕНЦИЙН ТУСГАЙ ЭРХҮҮДИЙН ТАЛААР

2.1. УЛС ТӨР, ИРГЭНИЙ ЭРХ

5 ДУГААР ЗҮЙЛ

АДИЛ ТЭГШ БАЙДАЛ БА ҮЛ АЛАГЧЛАЛ

4. Монгол Улсын Үндсэн хуульд “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.” гэж заасан /Үндсэн хуулийн 14.2/

5. Үндэсний хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, эрх зүйн актуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлан ялгаварласан заалт одоогоор байхгүй бөгөөд хуулийн хүрээнд тэгш хамгаалуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүх шатны боловсрол эзэмшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх, эрүүл мэндийн болон нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах, ажил хөдөлмөр эрхлүүлэх, нийгмийн хамгааллын үйлчилгээ авах зэрэг төрийн зүгээс үзүүлэх аливаа үйлчилгээнд тэгш хамрагдах боломж хуулиар нээлттэй байна.

6. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хуулиар сүрьеэ зэрэг архаг халдварт өвчний халдвартай үед байгаагаас бусад тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүл иргэдтэй хамт сурч, боловсрох, мэргэжил эзэмших, тусгай хэрэгцээт боловсролд үнэ төлбөргүй хамрагдах эрхийг баталгаажуулсан ба хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүх шатны боловсролын болон мэргэжил олгох байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаанаар элсүүлэх, элсэлтийн шалгалтад оруулахаас татгалзах, “Хөдөлмөрийн тухай” хуулиар аж ахуйн нэгж, байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлаас халах, халдварт өвчнөөс бусад тохиолдолд боломжтой ажил, албан тушаалд ажиллуулахаас татгалзахыг хориглодог.

7. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг боловсролын үйлчилгээнд хамрагдах тэгш боломжийг бүрдүүлэх үүднээс дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад элсэх хөнгөлөлттэй нөхцлийг бүрдүүлэх, оюутны сургалтын зардлыг төрийн сангаас санхүүжүүлэх, тусгай хэрэгцээт боловсролоор дамжуулан их, дээд сургуульд бэлтгэх, түвшинг нь ахиулах, “Хөдөлмөрийн тухай” хуулиар ажлын цагийг богиносгох, ээлжийн амралтын хугацааг уртасгах, ажлын байрны зохистой нөхцлийг бүрдүүлэх, ААНБ-д хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажиллуулах ажлын байрны квотыг тогтоох, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиар хөдөлмөрийн зах зээлд бусад иргэдийн нэг адил нээлттэй оролцуулах жижиг зээл, зуучлал, мэргэжлийн ба аж

ахуй эрхлэлт, бизнесийн сургалт, нийтийг хамарсан ажил зэрэг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих идэвхитэй бодлогоор дэмжих зэргээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдлыг хөхиүлэн дэмжих, алагчлахыг устгах бодлогыг хэрэгжүүлж байна.

8. “Эрүүл мэндийн тухай”, “Нийгмийн Даатгалын тухай” зэрэг хууль, тогтоомж, “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эмнэлэгт үзүүлэхэд дараалал харгалзахгүй үйлчлэх тухай” ЭМ-ийн сайдын тушаал зэрэг холбогдох эрх зүйн баримтаар баталгаажигдсан эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүн амд адил тэгш, алагчлалгүйгээр хүргэж байна.

8 ДУГААР ЗҮЙЛ

МЭДЛЭГ ОЙЛГОЛТЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ

9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар 2008 онд хийгдсэн эрх зүйн шинэчлэл, түүний хэрэгжилт нь нийгмийн дундах сөрөг ойлголт хандлагыг өөрчлөх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст өөрөө өөртөө итгэх итгэлийг төлөвшүүлэх, бусад иргэдийн нэг адил эрхээ эдлэх боломжийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой болсон. Ялангуяа “Хөдөлмөрийн тухай” болон “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хуулиудад орсон нэмэлт, өөрчлөлтөөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөрлөх эрхийг хангах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр ажил олгогчдыг дэмжих олон талт эдийн засгийн хөшүүргийг бий болгосон нь ажил олгогчдын дунд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх эерэг ойлголт, тэдний давуу талыг танин мэдэх боломжийг бүрдүүлсэн гэж үзэж болно.

Конвенцийн энэ заалтын мөрөөр багагүй ажил хийгдсэнээс зарим жишээ баримтыг дурдвал:

- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих Үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах, тэдний талаарх эерэг ойлголт, мэдлэгийг нийгэмд төлөвшүүлэх олон талт ажлыг зохион байгуулснаар сүүлийн жилүүдэд нийгэм, хамт олны зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандах хандлага сайжирч байгааг олон жишээгээр илэрхийлж болно. 2009 оноос эхлэн МҮХАҮТ-аас “Шилдэг 100 аж ахуйн нэгж” зарладаг шалгаруулалтад хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжигч, нийгмийн хариуцлага бүхий аж ахуйн нэгжийн номинацийг шинээр бий болгосон нь ажил олгогчдын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх үндсэн шалгууруудын нэг болж байгаа юм.
- МҮОНРТ-ээр “Хөшгөө татсан цонх” нэвтрүүлгийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоотойгоор 208 цуврал бэлтгэсэн нь

хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн амьдралд оролцох, сурч боловсроход бодит хувь нэмэр болж, тэднийг өрөвдөх, туслах биш, дэмжиж хамтран ажиллахыг уриалсан нөлөөллийн ажил болсон байна.

- МҮОНРТ-ийн “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрийг дохионы орчуулгатай хийж байна. Цаашид бусад телевиз, радиогийн мэдээллийн, хүүхдийн танин мэдэхүйн болон эрх зүйн нэвтрүүлэгт дохионы орчуулга шаардлагатай юм.
- НХХЯ-аас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрхлэн явуулдаг “Тулга-5” студитэй гэрээ байгуулж, 2010 онд “Хөгжлийн бэрхшээлтэй ч бид сайхан амьдарна” телевизийн 4 цуврал нэвтрүүлэг бэлтгэн, МҮОНТ болон арилжааны 5 телевизээр цацсан байна.
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах” ойлголтыг эмч, багш бэлтгэх сургуулиудад оруулж байна. Үүнд:
 - 2007 онд бага ангийн багш бэлтгэдэг Багшийн сургуулийн Сэтгэл судлалын тэнхимд “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах” ойлголтын талаар 20 цагийн лекц, 32 цагийн дадлагын ажлыг төгсөх курсын оюутнуудад оруулсан.
 - 2008 онд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах ойлголтын талаар 16 цагийн лекц, 32 цагийн дадлагын цагийг ЭМШУИС-ийн Уламжлалт анагаах ухааны сургууль, Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн төгсөх курсын оюутнуудын хичээлийн хөтөлбөрт оруулсан.
 - 2008 онд Дорнод аймгийн Багшийн Дээд сургуулийн Сургалт заах арга зүйн тэнхимтэй хамтарч тэнхимийн багш нарт НХОТСЗ анхан шатны ойлголт өгөх, 3, 4-р курсын оюутнуудын хичээлийн хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг энгийн сургуульд элсэн ороход тэднийг сургах, тэдэнтэй ажиллах арга зүйн талаар ойлголт өгөх семинарыг зохион байгуулсан.
 - 2010 оноос Сувилагчийн сургуулийн хичээлийн хөтөлбөрт Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах ойлголтыг оруулахаар хамтарсан ажлын хэсэг ажиллаж байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар нийгэмд эерэг ойлголт өгөхийн тулд хэвлэл мэдээлэл, телевиз, радиогийн сэтгүүлч нарт

“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах” ойлголтын талаар сургалт зохион байгуулж байна.

- “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах - Тэгш дүүрэн” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулж буй үйл ажиллагаануудын талаарх шинэ мэдээллүүдийг “Тэгш дүүрэн – Хайр энхрийлэл” сониноор дамжуулан улирал бүр нийтийн хүртээл болгодог. Уг сонинг 2006 оноос тогтмол хэвлэн түгээж байна.

➤ Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрүүдийг эрт илрүүлэх, сэргээн засах эрүүл мэндийн сургалт сурталчилгааны богино хэмжээний кино хийж, Нийгмийн эрүүл мэндийн төвүүдээр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх арга хэмжээ авч байна.

- 2005 онд хөгжлийн бэрхшээлийн хэлбэрүүдээс урьдчилан сэргийлэх, мөн хоёрдогч, гуравдагч хүндрэлээс сэргийлэх зорилгоор богино хэмжээний кино хийж, сургалтандаа ашиглаж байна.

- “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах – Тэгш дүүрэн” хөтөлбөрийн хүрээнд зүүн 9 аймагт нийт хүн ам, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрүүл мэндийн боловсрол олгох, хөгжлийн бэрхшээлтэй холбоотой хууль эрх зүйн баримт бичгүүдийг танилцуулах, гарын авлага, материалаар хангах, мэдээлэл олгох зорилгоор Нийгмийн эрүүл мэндийн төвийг аймгийн Эрүүл мэндийн газар дээр, Улаанбаатар хотод Сэргээн засалтын үндэсний төв дээр тус тус байгуулсан.

➤ Хөгжлийн бэрхшээлийн шалтгааныг эрт илрүүлэх, тэднийг сэргээн засах ном, гарын авлага, нугалбаруудыг 1997-2000 онд АИФО байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр Монгол хэл рүү орчуулж, хэвлэж, эмч эмнэлгийн ажиллагсдын ширээний ном болгон хэрэглэгдэж байна.

- Харааны бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийг дэмжин, хамгаалах үйлсэд тэдний оролцоог нэмэгдүүлэх замаар харааны бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн боловсрол олгоход зориулж өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх зэрэг эрүүл мэндийн сургалт, сурталчилгааны санамжуудыг жил бүр брайль үсгээр хэвлэн тарааж байна.

- 2008-2010 онд дараах гарын авлагууд монгол хэлээр хэвлэгдсэн байна.
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм хамт олонд түшиглэн сургах багц гарын авлага, ДЭМБ – 900 ширхэг
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах гарын авлага, Давид Вернер – 900 ширхэг
 - Тархины саатай хүүхэдтэй ажиллах гарын авлага, ДЭМБ – 1500 ширхэг
 - Нуруу нугасны гэмтэлтэй хүмүүстэй ажиллах гарын авлага, ДЭМБ – 1500 ширхэг
 - Цус харвалттай хүмүүстэй ажиллах гарын авлага, Лоренцо Карраро – 1500 ширхэг
 - 0-5 насны хүүхэдтэй ажиллах гарын авлага – 1500 ширхэг
 - Гэрийн нөхцөлд хийх дасгал хөдөлгөөн гарын авлага – 1500 ширхэг
 - Төслийн үр дүнд Монголд хүний эрхийн сургагч багш нар бэлтгэгдсэн. Мөн анх удаа ХБИБ-уудад зориулсан гарын авлагыг англи, монгол хэлээр хэвлүүлж, нийтийн хүртээл болгосон.
- НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц батлагдсанаас хойш “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах–Тэгш Дүүрэн” хөтөлбөрийн хүрээнд ХЭҮК нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг олон нийтэд сурталчлах, ялангуяа төрийн байгууллагын албан хаагчдыг хөгжлийн бэрхшээлийн талаар мэдлэг, мэдээлэлтэй болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх ашгийг хөндөж буй аливаа асуудалд тэдний оролцоог хангах талаар ТББ-уудтай санал солилцсоны дагуу 2009 оноос эхлэн төрийн байгууллагын албан хаагч нар, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамтарсан уулзалтыг цуврал хэлбэрээр зохион байгуулж байна.
 - Хүүхдэд бага наснаас нь эхлэн хүний эрх, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн ажлыг ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлж байна.

- Ерөнхий боловсролын сургуулийн “Иргэншил”, “Түүх”, “Нийгмийн тухай мэдлэг” хичээлийн агуулгад суралцагчдад ардчилсан нийгмийн үнэт зүйлс болох хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, эрх тэгш байдал, ёс, зан заншлын талаарх мэдлэг чадвар эзэмшүүлэх, тэднийг ардчилсан нийгмийн иргэн болгон төлөвшүүлэх талаар тусган 2004-2005 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлж байна. Тухайлбал, “Иргэншил” хичээлээр ёс зүйн ойлголт, үнэт зүйл, ёс зүйн хэм хэмжээ, уламжлалт зан үйл, “Нийгмийн тухай мэдлэг” хичээлээр нийгмийн харилцааг зохицуулж буй албан бус хэм хэмжээний хүрээнд ёс зүй, ёс суртахууны агуулгыг тодорхой сэдэв болгон судалж байна. Эдгээр хичээл нь суралцагчдад ёс зүйн боловсрол олгох, ардчилсан нийгмийн үнэт зүйлс болох хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, эрх тэгш байдал, ёс, зан заншлын талаарх мэдлэг чадвар эзэмшүүлэх, тэднийг ардчилсан нийгмийн идэвхитэй иргэн болгон төлөвшүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулах болно.

9 ДҮГЭЭР ЗҮЙЛ

ХҮРТЭЭМЖ

10. Хөгжлийн бэрхшээтэй хүмүүс бие даан амьдрах нийгмийн бүхий л харилцаанд бүрэн дүүрэн оролцох боломжийг бий болгох тухай конвенцийн заалтыг биелүүлэх үүднээс Засгийн газар, түүний яамд, холбогдох агентлагууд багагүй ажил зохион байгууллаа.

1. Нийслэлд шинээр барих болон өргөтгөл шинэчлэлт хийх авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль ”БД” 31-101-04-ийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, замын байгууламжийг тусгаж, шинээр болон шинэчлэгдэн баригдаж байгаа авто зам, замын байгууламжийг тэргэнцэртэй хүнд зориулсан рампан зам, хараагүй хүмүүст зориулсан явган хүний замын хөтөч хавтантай хийгдэж эхлээд байна.

Мөн 2010 онд “Хөгжлийн бэрхшээлтэй хүн ба хүртээмжтэй орчин” аяны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, замын байгууламжийн танилцуулгын самбар бэлтгэж үзэсгэлэнд оролцсон бөгөөд үзэсгэлэнгийн үеэр иргэдийн сонирхсон мэдээлэлд хариулт өгөхийн зэрэгцээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд

зориулсан зам, замын байгууламжийн төлөвлөлтийн талаар танилцуулга хийж, ярилцлага өгч ажилласан.

2. “Барилгын тухай” хуулийн 9.1.3-д барилга байгууламж нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээг хангасан байх, 10.1.3-д барилгын зураг төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг хангах арга хэмжээг тусгасан байхаар тус тус заасныг зураг төслийн экспертизээр дамжуулан хэрэгжүүлж байна.
3. Зураг төсөл зохиох үндсэн гарын авлага “Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт” БНБД 31-01.10, “Өндөр барилгын төлөвлөлт” БНБД31-17-10-д нэмэлт, өөрчлөлт оруулан батлуулж, “Авто зогсоол” БНБД21-05-10, “Төмөр зам ба авто замын нүхэн байгууламж” зэрэг нормуудыг шинээр боловсруулж, батлуулахад бэлэн болсон ба тус нормуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг хангах арга хэмжээг тусгуулан зураг төсөлд магадлал хийх үед биелэлтийг хангуулахаар ажиллаж байна.
4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах цэцэрлэг, сургууль, дотуур байр, олон нийтийн барилгын ажлын зураг төсөлд “Барилгын тухай” хуулийн 10.1.3-д заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан арга хэмжээг тусгуулах талаар хяналт тавьж, 2010 онд ЭМЯ болон БСШУЯ-ны захиалгаар 87 объект, орон сууц, олон нийтийн зориулалттай 75 объектын зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулсан.
5. БСШУЯ-наас Монгол улсын Засгийн газрын 2010 оны 302 дугаар тогтоолоор батлагдсан Эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд “Шинээр барих сургуулийн барилгад Монгол Улсын MNS-6055:2009, MNS-6056:2009 стандартыг мөрдүүлэх”-ээр тусган батлууллаа. Энэ хичээлийн жилд шинээр баригдах бүх сургуулийн барилга, түүний орчин 2010 оны 2 дугаар сарын 1-нээс мөрдөж эхэлсэн “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS-6056:2009”, “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага” Монгол Улсын MNS-6055:2009”-ыг баримтлан баригдана.
6. БСШУЯ, Шведийн олон улсын хөгжлийн агентлаг /SIDA/-тай хамтран хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол” төслийн хүрээнд нийслэлийн Хан-Уул дүүргийн 46 дугаар цэцэрлэг, ерөнхий боловсролын 15 дугаар сургуулийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ердийн сургууль, цэцэрлэгт сурч, хөгжих загвар орчин бүрдүүлэх зорилт тавьж зарим тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнийг нийлүүлсэн юм. Төслийн эхний үр дүн нь ердийн сургууль, цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах тэгш боломжоор хангасан орчныг


бүрдүүлэх, багшийг бэлтгэж чадвал тэдгээр хүүхдэд боловсролын үйлчилгээг үзүүлэх бүрэн боломж байгааг харуулсны гадна нийслэлийн 15 дугаар сургуулийн арга туршлагыг харуулсан тусгай нэвтрүүлгийг Монголын үндэсний олон нийтийн телевизээр явуулсан. Сүүлийн жилүүдэд ерөнхий боловсролын сургуулиуд өөрсдийн боломжид тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Нийслэлийн 15 дугаар сургууль

Зураг 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан налуу зам



Зураг 4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан бие засах газар



7. 2010 онд “Амаржих газрын бүтэц, үйл ажиллагаа” MNS 6188:2010 стандартыг боловсруулж, Стандартчилал, хэмжил зүйн Үндэсний зөвлөлийн 2010 оны 46 тоот тогтоолоор баталж, улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Уг стандартад хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд зориулж налуу зам, босгогүй өрөө, төрөхийн өмнөх өрөө, хонгил, ариун цэврийн өрөөний хана, цахилгаан шатанд зориулалтын бариул ханын дагуу байрлуулах гэх мэт дэд бүтцийг онцгойлон зааж өгсөн.
8. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн их багтаамжийн 400 автобусны 300-д нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон ахмад настанд зориулсан тусгай суудал гаргаж, суудлын бүрээсийг өөр өнгөөр ялган, суудлын хажууд тэмдэглэл байрлуулсан. Мөн хараагүй хүмүүст зориулж буудлыг зарлах, төхөөрөмжийг суурилуулан ашиглаж байна. Сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулж буудал бүрт нэр, хаяг чиглэлийг бичмэл болон зургийн хэлбэрээр байрлуулах ажлыг хийж байна.

9. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоонд “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль /БД 31-101-04/ барилгын дүрэм, “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин /MNS 6055:2009/ Монгол Улсын стандарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шаардлага хангасан зураг төсөл зохиох заавар боловсруулагдаж байгаа бөгөөд тус зааварт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зай хэмжээ ба бүсчлэл, явган зам, явган замын болон шалны хучилт, авто машины зогсоол, шат ба пандус, барилга байгууламж болон өрөө тасалгаа руу орох орц, цахилгаан шат, аж ахуйн зориулалттай өрөө, тоног төхөөрөмж гэх мэт үндсэн элементүүд багтсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан хөтөч зам, тэмдэг тэмдэглэгээг авто зам, гүүр, зам талбай, төлбөртэй зогсоол, тохижилтын ажлын 2010 оны 22 объектын зураг төсөлд тусгасан эсэхэд магадлал хийсэн байна.

10. Сонсгол, хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн харилцааны үндсэн хэрэглүүр болсон дохионы хэлийг хөгжүүлэх, дохионы хэлний мэргэжлийн орчуулагчийг бэлтгэх талаар бодлогын түвшинд зарим нэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Гэсэн хэдий ч энэхүү арга хэмжээг үндэсний түвшинд улам өргөжүүлэх, мэргэжлийн дохионы хэлний орчуулагчийг бэлтгэх сургалтын төв байгуулах замаар дохионы хэлний мэргэжлийн орчуулагчийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

11. Дохионы хэлний анхан шатны сургалтыг 3 аймаг, багш бэлтгэдэг сургуулийн багш, оюутан, түүнчлэн цагдаагийн болон хүүхдийн байгууллагын ажилтан, эцэг эх, ерөнхий боловсролын сургуулийн сурагч зэрэг нийт 3000 гаруй хүнийг хамруулан зохион байгууллаа. Дохионы хэлний толь бичигт үндэслэн аймаг, нийслэлд дохионы хэлний сурагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөр, багш нарт зориулсан сургалтын гарын авлага боловсруулан гаргав. Энэхүү сургалтын хөтөлбөрийн дагуу аймаг, нийслэлийн дохионы хэлний сурагч багш бэлтгэх сургалт зохион байгуулж, түүнд аймаг бүрээс 2-3 багшийг хамруулж, орон нутагт сургалт явуулах 65 хүний нөөцийг бүрдүүлсэн байна. Мөн дохионы хэлний анхан, дунд, гүнзгий шатны сургалтын хөтөлбөр боловсруулаад байна.

10 ДУГААР ЗҮЙЛ

АМЬД ЯВАХ ЭРХ

12. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн 16-д “Монгол Улсын иргэн амьд явах эрхтэй. МУ-ын эрүүгийн хуульд онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад

тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно” гэсэн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд нэгэн адил үйлчилж байна.

13. Монгол Улсын Эрүүгийн хуульд онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд /46.1.7-д/ цаазаар авах ялын төрөлтэй. Нийт 7 төрлийн гэмт хэрэгт цаазаар авах ялаар шийтгэх заалттай. Монгол Улсын Ерөнхийлөгч нь цаазаар авах ял оногдуулсан хүнд өршөөл үзүүлэх эрхтэй бөгөөд тэрээр уг ялыг хэрэглэхийг хориглосон уриалгыг 2010 онд гарган энэ онд уг шийтгэлийг түдгэлзүүлээд байна. Үүнтэй холбогдуулан НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн пактын 2 дугаар нэмэлт протоколд нэгдэн орох асуудал Засгийн газраар дэмжигдэн, одоо Улсын их хурлын холбогдох Байнгын хороогоор хэлэлцэгдэж байна.

11 ДҮГЭЭР ЗҮЙЛ

ХҮМҮҮНЛЭГИЙН ГАМШИГ БОЛОН ЭРСДЭЛ БҮХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

14. Монгол Улсын “Гамшгаас хамгаалах тухай” хуульд зэвсэгт мөргөлдөөн, байгалийн аюул гамшиг зэрэг эрсдэлт нөхцөл байдлын үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах талаарх тусгайлсан зохицуулалт байхгүй боловч “Онц байдлын тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 /шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Зэвсэгт хүчний ерөнхий штаб, цагдаа, тагнуул, хил болон иргэний хамгаалалтын асуудал эрхэлсэн төв байгууллагуудын дарга нарын бүрэлдэхүүнтэй шуурхай штаб байгуулж ажиллуулах/-т заасны дагуу шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлнэ.

15. Монгол Улсад зарим өвөл байгалийн онц ноцтой үзэгдэл болох зудын гамшиг нүүрлэдэг бөгөөд ЭМЯ 2001 оноос эхлэн АИФО ТББ-тай хамтран “Зудын тусламж”-ийг үзүүлж байна. “Зудын тусламж”-ийн үед дараах арга хэмжээнүүдийг авдаг. Үүнд: Аймгийн ЭМГ-аар ахлуулж, Нэгдсэн эмнэлгийн мэргэжлийн эмч нар сумдын хүн амд үзлэг оношлогоо /мэдрэл, дотор, сэтгэц, эмэгтэйчүүд, шүд, эхо г.м/ хийх; Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эмнэлэг, хөдөлмөр магадлалын комисс”-ын хурлыг газар дээр нь хийж, хугацааг нь хамгийн багадаа нэг жилээр сунгах; Зарим орон гэрээ алдсан хүнд гэр олгох; Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрх гэрт нийтлэг хэрэгцээний өрхийн эмийн сан олгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

16. 2009-2010 оны өвөл анх удаа “Өвөлжилт хүндэрсэн орон нутгийн хүүхэд, өсвөр үеийнхний нөхцөл байдлын түргэвчилсэн үнэлгээ”-г хийж хүүхдийн эрүүл мэнд, амьдарч буй орчин нөхцөл, хоол хүнсний судалгааг гарган ажилласан нь үр дүнд хүрлээ. Зудын хүндрэлийн улмаас олон гэр бүлийн

амьдралд өөрчлөлт гарсантай уялдуулан хүүхэд, өсвөр үеийнхний нөхцөл байдалд түргэвчилсэн үнэлгээ хийж хүүхдийн хөгжил, хамгаалал, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн асуудал хангалттай байгаа эсэх, яаралтай болон цаашид авах арга хэмжээг төлөвлөхөд үндэслэл болохуйц нэмэлт мэдээлэл авах зорилготой байлаа.

Энэхүү үнэлгээнд 12 аймгийн 65 сумын 73364 өрхөд нийт хүн амын 36,7 хувь буюу 97106 нь хүүхэд амьдарч байгаагийн дотор сургуулийн дотуур байранд амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй 244 хүүхэд хамрагдаж хүмүүнлэгийн тусламж үйлчилгээ авсан байна.

17. Өмнөх жилийн зудын гамшгаас сургамж авч 2010-2011 оны өвөлжилтийн нөхцөл байдалд түргэвчилсэн үнэлгээ боловсруулах ажлыг 2010 оны 12 дугаар сараас эхлэн Монгол Улс дахь НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд болох холбогдох олон улсын байгууллагууд, Хүүхдийн төлөө газар, Гамшигтай тэмцэх үйл ажиллагаанд оролцох чиг үүрэг бүхий яам, агентлагийн төлөөлөгчөөс бүрдсэн чиглэлийн багууд зохион байгуулсан нь оролцогч байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх, хүндрэлтэй нөхцөл байдал үүсэхэд аргачлалаа зөв тодорхойлох, шаардлагатай тохиолдолд олон улсын байгууллагаас хүмүүнлэгийн тусламж авах нөхцлийг бүрдүүлсэн.

18. “Гамшгаас хамгаалах тухай” хуулийн нэмэлт, өөрчлөлтөд хүүхэд хамгааллын асуудлыг цогцоор тусгах асуудлыг судлан ажиллаж эхлээд байна.

19. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өгсөн үүрэг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс гаргасан зөвлөмж, тэмдэглэл, Засгийн газрын 2010 оны 76 дугаар тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгийн нэгдсэн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах зорилгоор орон нутгийн болон Нийслэлийн Хүүхдийн төлөө газар, хэлтсүүд болон тусгай сургуулиудад гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг гарган 1 удаагийн сургуулилт хийсэн .

20. Томуугийн H1N1 цар тахлын вирусийн халдварын үед Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвийн Хүүхдийн тасагт эмчлүүлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй 25 хүүхэд, Хүүхэд асран хамгаалах төвд амьдарч буй 33 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд буцалтгүй тусламж үзүүлэн ажилласан байна.

12 ДУГААР ЗҮЙЛ

ХУУЛИЙН ӨМНӨ ТЭГШ БАЙХ ЭРХ

21. Монгол Улсын Үндсэн хуулиар хуулиар хүн бүрийн хөдөлмөрлөх, сурч боловсрох, эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх тэгш зарчим, түүнчлэн

хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн материаллаг болон санхүүгийн туслалцаа авах эрхийг тунхаглан заасан. Энэхүү үзэл санаанд тулгуурлан “Хөдөлмөрийн тухай”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай”, “Нийгмийн даатгалын тухай”, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай”, “Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай” болон “Эрүүл мэндийн тухай” зэрэг үндэсний хууль тогтоомжуудаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн амьдралд оролцох, нөхөн сэргээгдэх, сурч боловсрох, бусдын адил ажил, хөдөлмөр эрхлэх, нийгмийн хамгааллын үйлчилгээ авах тэгш эрхийг баталгаажуулж өгсөн юм.

22. Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээ авах эрхийн тухайд хууль, эрх зүйн орчин боломжийн бүрдсэн хэдий ч хуулийн хэрэгжилтийг хангах явдал хангалттай биш байгааг тэмдэглэх ёстой.

23. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна гэж заасны дагуу Эрүүгийн хуульд “Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх” зарчим баримтална гэжээ. Энэ хуулийн 5.1-д гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд түүний угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролыг үл харгалзан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэж заасан. Одоогийн байдлаар иргэдийн хөгжлийн бэрхшээлтэй байдлаас хамаарч энэ зүйл заалт нь зөрчигдсөн тохиолдол бүртгэгдээгүй бөгөөд хууль бүх иргэнд тэгш үйлчилж байна. Гэсэн хэдий ч энэ нь хууль, шүүхийн өмнө тэдний эрх огт зөрчигдөхгүй байгаа гэсэн үг биш бөгөөд тэдгээр хүмүүс шүүх ажиллагаанд тэр бүр өөрийнхөө хүссэнээр оролцож санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хууль, шүүхийн ажилтнуудтай өөрийнхөө хүссэн цагт ирж уулзах боломж хязгаарлагдмал байна. Энэ байдлыг өөрчлөх үүднээс шүүхийн ажилтнууд, шүүгч нарт сургалт явуулах, санал авах, өөрчлөх шаардлага гарч байгаа.

13 ДУГААР ЗҮЙЛ

ШҮҮХ АЖИЛЛАГААНД ХҮРТЭЭМЖТЭЙ ОРОЛЦОХ

24. Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд заасан “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. Хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.” мөн хуулийн 49 дүгээр зүйлийн 1дэх хэсэгт заасан “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд

захирагдана.”, Шүүхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан “Монгол Улсад хүн бүр үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад байдал, түүнчлэн аж ахуйн нэгж байгууллага амчийн хэлбэр, эрх хэмжээний ялгаваргүйгээр хуулийн өмнө эрх тэгш байна.” гэсэн зарчмуудын үндсэн дээр Монгол Улсын Шүүхийн үйл ажиллагаа явагдаж байна.

25. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 7 дугаар зүйлд “Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төр, алдар хүндийг нь гутаах зорилго, хэлбэр агуулж болохгүй” гэж заасан.

Иймд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад иргэдийн адил шүүхийн бүх шатны үйл ажиллагаанд тэгш эрхтэй оролцох боломжийг хангадаг болно. Тухайлбал, сонсголын бэрхшээлтэй хүмүүс шүүх хуралдаанд оролцсон тохиолдолд тусгай хэлмэрчийг оролцуулдаг.

Мөн насанд хүрээгүй иргэд оролцсон хэргийг шүүн таслах үйл ажиллагааг хаалттай хэлэлцдэг.

26. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг шүүх болон цагдан хорих үйл ажиллагааг хэрэгжүүлэгч албан хаагчдыг зохих сургалтад хамруулах асуудал хангалттай хийгдэхгүй байна. Тухайлбал: ЦЕГ-ын нийт албан хаагч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, нарт явуулдаг сургалтын хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар агуулгад нь тусгаж өгөх шаардлагатай байна.

27. Монгол Улсын Дээд Шүүхийн 2009 оны 10 дугаар тогтоолд “Эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр нотлогдсон” гэж сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүх “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай” хуулийн 3 дугаар бүлэгт заасан журмын дагуу Иргэний хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т зааснаар иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцно гэж тайлбарлажээ.

28. Сүүлийн үед баригдаж буй шүүхийн барилгууд, тухайлбал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, Өвөрхангай аймгийн Хархорин дахь сум дундын шүүх, Ховд аймгийн Булган дахь сум дундын 2 дугаар шүүх, Хэнтий аймгийн Бор-Өндөр дэх сум дундын 2 дугаар шүүх болон Өмнөговь аймгийн шүүхийн барилгуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай шат, довжоо, бариул зэргийг тусган бариулахаар төлөвлөж байна.

14 ДҮГЭЭР ЗҮЙЛ

ЭРХ ЧӨЛӨӨ, ХУВИЙН ХАЛДАШГҮЙ ЭРХ

29. Монгол Улсын Үндсэн хуулийн 13-д Халдашгүй чөлөөтэй байх эрхтэй, хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ гэж хуульчилсан байгаа. Энэ заалт нь иргэдийг хөгжлийн бэрхшээлтэй байдлаас нь үл шалтгаалан Монгол Улсын иргэдэд нэгэн адил үйлчилж байгаа бөгөөд энэ заалт нь бусад хууль тогтоомжид нэгэн адил үйлчилнэ.

15 ДУГААР ЗҮЙЛ

ЭРҮҮДЭН ШҮҮЛТ, ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУС, НЭР ТӨРИЙГ ДОРОМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХЭЭС АНГИД БАЙХ ЭРХ

30. Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүдэн шүүх аливаа үйлдлийг гаргахгүй байх, түүнээс урьдчилан сэргийлэх, гарсан нөхцөлд хариуцлага тооцох, түүнийг арилгах, засч залруулах талаар хуульд тусгайлан заасан байдаг бөгөөд 2007 онд “Эрүүгийн байцаан шийтгэх” хууль, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуульд эрүүдэн шүүх аливаа үйлдлийг урьдчилан сэргийлэх, тийм нөхцөл байдалд хүргэхгүй байх үүднээс тодорхой өөрчлөлтүүд орсон.

31. Хүний эрхийг хязгаарлах, хүнийг нэгжих, баривчлах үндэслэл журам, түүнд хяналт тавих, хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, бусдын эрх, эрх чөлөөг хүндэтгэж, нийгмийн хэв журмыг сахих зарчмыг мөрдүүлэх чиглэлээр нарийвчилсан зохицуулалт хийх зорилгоор Эрүүгийн хууль, “Эрүүгийн байцаан шийтгэх тухай”, “Иргэний хууль”, “Шүүхийн тухай”, “Прокурорын байгууллагын тухай”, “Өмгөөллийн тухай” зэрэг хуулийг 2002 онд тус тус шинэчлэн баталсан.

- 2010 оны 3 дугаар сард “Эрүү шүүлтээс ангид байх эрх” сэдвээр шүүх, УПЕГ, УПЕГ-ын дэргэдэх МБА, ШШГЕГ-ын албан хаагчдад зориулан сургалт зохион байгуулсан. Тус сургалтыг цаашид тогтвортой явуулах үүднээс ХЗҮХ-ийн магадлан итгэмжлэх хороогоор оруулж кредит авсан.
- Холбогдох хуулийн байгууллагууд хооронд эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэхэд хамтран ажиллах зорилгоор байгуулсан Санамж бичгийн хэрэгжилтийг танилцуулах зөвлөлдөх уулзалтыг

зохион байгуулсан. Уулзалтаар Санамж бичгийг дахин 3 жилээр сунгахаар харилцан тохиролцсон бөгөөд хамтран ажиллах дараагийн нэг чиглэл нь ЭШЭК-ийн Нэмэлт протоколд нэгдэн орох асуудлыг дэмжиж болох талаар санал солилцсон.

32. Хүний эрхийг хангах, хүнлэг бус хэрцгий харьцах явдлыг арилгах үүднээс 2002 онд батлагдсан “Эрүүгийн байцаан шийтгэх тухай” хуулиар цагдаа, шүүх, прокурорын ажилтнуудаас хүнлэг бус хэрцгий хандсан талаарх гомдол, мэдээлэл, хэргийг Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба шалгаж байхаар шинэчлэн хуульчилж, Монгол Улсын Ерөнхий Прокурорын дэргэд Мөрдөн байцаах алба байгуулан ажиллуулж байна.

16 ДУГААР ЗҮЙЛ

ХҮЧИРХИЙЛЭЛ, ДОРМЖЛОЛ, МӨЛЖЛӨГӨӨС АНГИД БАЙХ ЭРХ

33. УИХ-аар 2011 оны 2 дугаар сард баталсан “Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай” хуулиар улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендерийн эрх тэгш байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлсон. Хуулийн хүрээнд “жендерийн эрх тэгш байдал”, “жендерийн ялгаварлан гадуурхалт”, түүний шууд ба шууд бус хэлбэр, “жендерт суурилсан хүчирхийлэл” зэрэг ойлголтуудыг нэг мөр болгож, жендерийн тэгш эрхийн зарчмыг “эрэгтэй, эмэгтэй хүн бүр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн ба бусад харилцаанд тэгш эрхтэй байх, нийгмийн амьдралд адил оролцох, хөгжлийн үр шим, нийгмийн баялгаас тэнцүү ашиг хүртэх боломж, нөхцлийг хангах” гэж тодотгож өгсөн байна.

34. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийн зарчим нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хууль дээдлэх, хүчирхийлэл үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээг шуурхай авах, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх зарчимд үндэслэнэ. Энэ хуулийн зарчмын дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэд ч энэ хуулиар бүрэн хамгаалагдсан. Тус хуульд зааснаар хохирогчдод мэргэжлийн төрөлжсөн үйлчилгээг хүргэх гэсэн зорилгод тулгуурлаж, үүнийгээ Засгийн Газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу төрийн зарим чиг үүргийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудлаар мэргэшсэн ТББ-уудаар гэрээлэн гүйцэтгүүлж, төрийн болон ТББ-ын хамтын ажиллагааг идэвхжүүлж байна.

35. Гэр бүлийн орчинд бие махбодийн шийтгэлээс хүүхдийг хамгаалах зорилгоор олон нийтийн дундах ойлголтыг дээшлүүлэх үйл ажиллагааг Английн Хүүхдийг ивээх сан, Дэлхийн зөн Монгол зэрэг байгууллагуудын санхүүгийн

болон техникийн дэмжлэгтэйгээр явуулж байна. Энэ хүрээнд “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргууд” номыг хэвлэн гаргасан бөгөөд эцэг, эхэд хүүхэдтэй ажиллах талаархи зөвлөгөө, үйлчилгээг 24 цагийн турш төрийн бус байгууллагууд үзүүлж байгаа⁴.

17 ДУГААР ЗҮЙЛ

ХУВИЙН НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ

36. Бүх хүмүүс, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд ямар нэгэн алагчлалгүй өөрийн үр удмаа үлдээх эрхтэй. “Жендэрийн тэгш байдлыг хангах тухай” хуулийн 13 дугаар зүйлд хүсээгүй жирэмслэлт, бэлгийн замын халдвараас урьдчилан сэргийлэх, хамгаалах эрхийг хүч хэрэглэх, тулган шаардах буюу аливаа арга, хэлбэрээр зөрчих, эрэгтэй, эмэгтэй хүнийг нөхөн үржихүйн болон эрүүл мэндийн чиглэлийн бусад сургалт, сурталчилгаанд оролцох, үзлэг, шинжилгээнд хамрагдахад саад учруулах, эрүүл мэндийн үйлчилгээнд эрэгтэй, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, үр хөндүүлэхийг ятгах, шаардах, дарамтлахыг хориглох тухай заасан байдаг. (13.3; 13.4; 13.5;) Гэхдээ дараах тохиолдолд эхийн ургийг таслан зогсоох, эсвэл үр тогтохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг Эрүүл мэндийн тухай хуулийн 37-р зүйлд заасны дагуу арга хэмжээ авдаг. Үүнд:

1. Эхийн хэвлий дэх ураг удамшлын болон бие эрхтний гажиг хөгжилтэй болох нь тогтоогдсон, эсхүл тухайн жирэмслэлт нь эхийн амь насанд аюул учруулж болох онцгой нөхцөлд жирэмсэн эх, шаардлагатай гэж үзвэл нөхрөөс нь бичгээр зөвшөөрөл авч, жирэмслэлтийг эмнэлгийн аргаар таслаж болно.

2. Удамших хандлагатай сэтгэцийн өвчин, оюун ухааны хомсдолтой хүнийг жирэмслэх, үр тогтохоос сэргийлэх арга хэмжээ авна.

Дээрхээс өөр тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйд ямар нэгэн хүч хэрэглэж үр хөндөлт хийх, эсвэл жирэмснээс хамгаалах хэрэгсэл тавьдаггүй.

18 ДУГААР ЗҮЙЛ

ЧӨЛӨӨТЭЙ ЗОРЧИХ БОЛОН ИРГЭНИЙ ХАРЬЯАЛЛАА СОНГОХ ЭРХ

37. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд “Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаад

⁴ Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол улсын үндэсний III IV тайлан илтгэл

явах, оршин суух, эх орондоо буцан ирэх эрхтэй. Гадаад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.” гэж заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэд улсынхаа нутаг дэвсгэрт түр болон байнга оршин суух эрхийг бусад иргэний нэгэн адил эдэлж байна.

38. Түүнчлэн Монгол Улсын “Иргэний бүртгэлийн тухай” хуульд “Эцэг, эх хэрэв эцэг, эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлэх буюу хорих газарт ял эдэлж байгаа зэрэг аргагүй шалтгааны улмаас бүртгүүлэх боломжгүй бол тэдний төрөл садны хүн буюу хүүхэд байгаа эмнэлгийн байгууллагын эрх бүхий ажилтан хүүхдийг төрснөөс хойш төв суурин газарт 15 хоног, алслагдсан сум, багт 30 хоногийн дотор иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд бүртгүүлнэ.” гэж заасан бөгөөд энэ нь хөгжлийн бэрхшээлээс үл шалтгаалан Монгол Улсад төрсөн хүүхдүүдэд үйлчилж байна. Одоогийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд төрөхөөс, эсхүл төрсөн даруй улсын бүртгэлд бүртгэгдэх, нэртэй болох, иргэний харьяалал олж авах болон эцэг эхээ мэдэх, тэднээрээ асран тэтгүүлэх эрх нь зөрчигдсөн тохиолдол бүртгэгдээгүй байна.

39. Монгол Улс тус конвенцид оролцогч тал болохынхоо хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын адил чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох болон иргэний харьяаллаа чөлөөтэй сонгохыг хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрдөг бөгөөд тэдгээр хүмүүсийн эрхийг ямар нэг байдлаар зөрчсөн, хязгаарлаж, хориглосон тохиолдол одоогоор гараагүй болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүн Монгол Улсын “Харьяатын тухай” хуульд (1995) заасан эрхийг ямар нэг алагчлалгүйгээр баталгаатай эдэлж байна.

19 ДҮГЭЭР ЗҮЙЛ

БИЕ ДААН АМЬДРАХ БОЛОН ТУХАЙН ОРШИН СУУГАА ГАЗРЫНХАА НИЙГМИЙН АМЬДРАЛД ОРОЛЦОХ

40. Хувийн асаргаа шаардлагатай хүмүүсийн асрагчийн асуудлыг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие даан амьдрах тогтолцоо, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тухайн орчныхоо нийгмийн амьдралд оролцоход чиглэсэн гэрийн үйлчилгээний талаар, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийг харгалзан оршин суух байрны болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан асрамжийн газрын нөхцөл хүртээмж, нийт хүн амын хэмжээнд нийгмийн үйлчилгээ ба хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үйлчилгээний хүртээмжийн түвшний асуудлын талаар 2011 онд ХХҮГ-аас Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх асаргаа сувилгааны талаар журам гарсан. Уг журамд асаргааны талаар нэг бүрчлэн заасан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгайлсан

асрамжийн газар одоогоор байхгүй. Эдгээр иргэд улсын төвлөрсөн асрамжийн газруудаар үйлчлүүлж байна. Жишээ нь:

- 2009-2010 онд нийт 21 аймгийн эрүүл мэндийн газрын дарга, өрхийн эмч, сургуулийн удирдлага, эцэг эх нарын төлөөлөл оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг асарч сувилах, өөрөө өөртөө туслах бүлгийн хандлагыг сайжруулах, эв дүй олгох талаар нийслэлд тогтмол сургалт явуулж хэвшээд байна. Үүнд нийт 30 орчим сая төгрөг зарцуулаад байна.
- 2009-2010 онд: Чингэлтэй дүүргийн Улаан загалмайн хороо, дүүргийн ХХҮХ-тэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан “Асрамжлагч сайн дурынхны гэрийн үйлчилгээ” төслийн хүрээнд сайн дурын асрамжлагч, халамжлагч сургагч багш нарыг бэлтгэж асрамжийн үйлчилгээг хүргэж байна. 2009 онд байнгын асаргаа шаардлагатай 100 иргэнд асрамжийн үйлчилгээ үзүүлж, 2010 онд гэрийн асаргаа өдрөөр 25, амьдрах ухааны сургалтанд 50, өдрийн үйлчилгээнд 25 хүн, нийтдээ 100 хүн хамрагджээ.
- 2009-2010 онд: Дүүргүүдийн ХХҮХ-ийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг энэхүү конвенцийн агуулга, зарчимтай танилцуулах сургалтанд хамруулж уг арга хэмжээ тогтмолжсон байна.
- 2009 он: Засгийн газраас хэрэгжүүлж буй “Нийгмийн эмзэг бүлэгт хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөр”-ийг үр дүнтэй хэрэгжүүлэх, хөтөлбөрийн зорилтот иргэдийг зөв тодорхойлох, сонгож авах бүртгэлийн ажлыг зохион байгуулж нийслэлийн 9 дүүргээс 9517 ядуу эмзэг бүлгийн өрх, иргэний мэдээллийн санг бий болгон ганц бие, харж хандах хүнгүй 723 ахмад настан, байнгын асаргаа шаардлагатай 1635 ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй 544 иргэн, байнгын асаргаа шаардлагатай 1420 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, байнгын асаргаа шаардлагатай 511 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, бүрэн хараагүй 29, сэтгэцийн өвчтэй 0-18 насны 127 хүүхдийн бүртгэлийг гаргаад байна.
- 2010 он: “Нийгмийн эмзэг бүлэгт хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөр”-ийн хүрээнд 3 зорилтот бүлгийн судалгааг гарган ажиллав. Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг хувийн хэвшил төрийн бус байгууллага, иргэдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх асуудлыг судлан хэрэгжүүлж байна.

20 ДУГААР ЗҮЙЛ

ХУВИЙН ХӨДӨЛГӨӨН

41. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн хөдөлгөөнт байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай зүйлсийн нэг нь сэргээн засалтын энгийн /ортопедийн/ туслах хэрэгслүүд /таяг, бэхэлгээт сандал, булангийн сандал, зогсоох хэрэгсэл, алхуулагч, хөл, гарын чиг, хүзүүвч, дөрөөвч, улавч, эрхий хуруу салгагч г.м/ юм. АИФО ТББ-тай хамтран хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах–Тэгш Дүүрэн” хөтөлбөрийн хүрээнд 1997-2010 оны хооронд 21 аймаг, Улаанбаатар хотын Тархины саажилттай хүүхдийг сэргээн засах 10-р цогцолбор, Сэргээн засалтын үндэсний төвд тус тус Ортопедийн цехийг байгуулсан.

42. Ортопедийн цехийг ажиллуулах боловсон хүчин /мужаан, оёдолчин/-ийг 1999 оноос Сэргээн засалтын үндэсний төв дээр 10 хоногийн сургалтанд хамруулан бэлтгэж байна. Ихэнх аймгийн ортопедийн цехэд ЭМГ-ын мужаан ажиллаж байна. Мөн 2008 оноос орон нутгийн нэгдсэн эмнэлгийн гэмтлийн эмч, мэс заслын эмчийг Гэмтэл согог судлалын Үндэсний төвтэй хамтран мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулж байна.

43. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хуулийн 2008 оны шинэчилсэн найруулгаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэнд хөдөлгөөн дэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн үнийн хөнгөлөлт олгох нөхцлүүдийг тодорхойлж өгсөн ба түүний дагуу Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2009 оны 24 дүгээр тушаалаар 53 нэр төрлийн протез ортопедийн хэрэгслийн зах зээлийн жишиг үнийг баталсан. Энэ жишиг үнээр тооцож, Нийгмийн халамжийн сангаас хөдөлгөөн дэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэсэн төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, ТББ-уудад санхүүгийн дэмжлэг олгодог. Тухайлбал, Сэргээн засалтын Үндэсний төв, “Эрхэм чанар”, “Сайхан сэтгэл”, “Мобилити Монгол” зэрэг ТББ-ууд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт гэрээний дагуу ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан протез, ортопед, тусгай хэрэгслийг нийлүүлж, үнийн хөнгөлөлт авдаг. Жишээ нь:

- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөнгөлөлт авах эрх үүсээгүй 2904 хөгжлийн бэрхшээлтэй хүний дотоодод хийлгэсэн 19 нэр төрлийн протезийн үнэнд мөн сангаас 2010 онд 681.4 сая төгрөгийг зарцуулсан байна.
- 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, ҮОМШӨ-ний даатгалын сангаас протез, сэргээн засалтын хөнгөлөлт авах эрх үүсээгүй 8504 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн худалдан авсан болон дотоодод хийлгэсэн тэргэнцэр, алхуулагч, таяг, магнитофон, сонсголын аппарат,

хөтөвч зэрэг 21 нэр төрлийн ортопед, тусгай хэрэгслийн үнэнд 1127.1 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн байна.

21 ДҮГЭЭР ЗҮЙЛ

ҮЗЭЛ БОДОЛ, ИТГЭЛ ҮНЭМШЛЭЭ ИЛЭРХИЙЛЭХ, МЭДЭЭЛЭЛ ХҮРТЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

44. Сонсгол, хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн харилцааны үндсэн хэрэглүүр болсон дохионы хэлийг хөгжүүлэх, дохиотой үгсийн санг нэмэгдүүлэх, Монгол дохионы хэлний нэгдсэн стандартыг бий болгох чиглэлээр багагүй ажил хийж гүйцэтгэлээ.

- БСШУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2005 оны 58 тоот тушаалаар байгуулагдсан дохионы хэлний мэргэжилтэн, тусгай сургуулийн багш, сонсголгүй болон хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагын төлөөлөл, монгол хэлний мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсгээс 3000 үгтэй “Монголын дохионы хэлний толь бичиг” боловсруулан хэвлүүлж 2006 онд олон нийтэд хүргэлээ. Энэхүү толь бичгийг боловсруулан гаргаснаар сонсгол, хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн харилцааны хэрэглүүр болсон Дохиотой үгийн тоо нэмэгдэн тэдний бусадтай харилцах харилцаанд чанарын өөрчлөлт гарч, богино хугацаанд их мэдээлэл авч, тасралтгүй суралцах боломж бүрдэж байгаагаараа ач холбогдолтой болсон юм.

45. 2010 оны байдлаар улсын хэмжээнд 200 орчим интернэт кафе ажиллаж, интернэтийн байнгын хэрэглэгчийн тоо 199,849 хүрч, интернэтийн үйлчилгээг гэрээсээ авах бүх нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн гар утаснаасаа төлбөр тооцоо, шилжүүлэг хийх боломжууд нээгдэж, МҮОНТ мэдээллийн хөтөлбөрөө монгол болон англи хэлээр, мөн дохионы орчуулгатай хүүхдийн нэвтрүүлгийн “Dream” суваг мэдээллийн хөтөлбөрөө дохионы орчуулгатай давхар мэдээлж байна.

46. Бүх нийтэд мэдээллийн технологийн хөгжил дэвшлийг тэгш хүргэх зорилгоор Олон улсын цахилгаан холбооны байгууллага /ITU/-ын санхүүжилтээр харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан Монгол хэл дээр дэлгэц уншигч хөгжүүлэх төслийг МУИС, Тайланд улсын NECTEC компанитай хамтран эхлүүлээд байна.

47. Одоогоор МУИС, МТҮП-ын технологийн судлаач багш, ажилтан, Монголын хараагүйчүүдийн холбооны төлөөлөгч зэрэг хүмүүс Тайланд улсад бичвэрийг авиа болгох програм хангамж дээр ажиллаж байна.

22 ДУГААР ЗҮЙЛ

ХУВИЙН АМЬДРАЛЫН ХАЛДАШГҮЙ БАЙДАЛ

48. Сэргээн засалтын Үндэсний төвийн протез, сэргээн засалтын албаны дэргэд эмч, мэргэжилтний ёс зүйн хороо ажилладаг ба тус хорооны үндсэн чиг үүрэгт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн, эрүүл мэндийн болон нөхөн сэргээлтийн талаарх мэдээллийн нууцыг хамгаалах асуудал багтдаг.

49. Эрүүл мэндийн яамнаас Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг 2007 оны 12-р сард баталсан. Ёс зүйн хэмжээний 3.13-т заасны дагуу Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчтэй холбоотой мэдээллийн нууцыг “Хувь хүний нууцын тухай” хуулийн 6-р зүйлд зааснаас бусад тохиолдолд түүнийг амьд сэрүүн байх хугацаанд төдийгүй нас барсных нь дараач чандлан хадгална гэж заасан байдаг. Мөн 3.14т “Эмнэлгийн мэргэжилтэн нь өвчний түүх болон үйлчлүүлэгчийн нууцтай холбоотой бусад баримт бичгийг үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах буюу бусдад ашиглуулахаар хувилан өгч болохгүй” гэж заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн мэдээллийг хамгаалдаг.

50. Дээрх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээн дээр үндэслэж Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан Ёс зүйн хороо 2007 онд байгуулагдсан. Мөн эмнэлэг бүрт Ёс зүйн салбар хороо ажиллаж байна. Эрүүл мэндийн тухай хуулийн 26-р зүйлд Эмнэлгийн мэргэжилтний үүргийг

- эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг биелүүлж, хүнлэг энэрэнгүй үзлийг эрхэмлэн, мэргэжлээ хүний эрүүл мэндийн эсрэг ашиглахгүй байх
- иргэний эрүүл мэндийн болон байгууллагын нууцыг хамгаалах гэж заасан байна.

23 ДУГААР ЗҮЙЛ

ОРОН БАЙР, ГЭР БҮЛИЙГ ХҮНДЭТГЭХ

51. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 11-д гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаалахаар хуульчилсан билээ. Энэ заалтыг “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” хуулиар төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн эрх ашгийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэх, мөн хүүхэд оюун ухаан, авьяас билэг, бие бялдар, ур чадвараа хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг авах эрхтэй хэмээн баталгаажуулж өгсөн

болно. Мөн “Гэр бүлийн тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх заалтад “Хүүхэд гэр бүлийн дотор тэгш эрх эдэлнэ” гэж заасан байна⁵.

52. Монгол Улсын “Гэр бүлийн тухай” хуульд гэрлэхэд харшлах шалтгаанд хөгжлийн бэрхшээлийн төрлүүдээс гагцхүү удамших хандлагатай сэтгэцийн өвчинг хамааруулан тооцогддог, түүнчлэн гэр бүлийн дотор хөгжлийн бэрхшээлтэй хүн, хүүхэд адил тэгш эрхтэй байхаар зааснаас гадна гэр бүлийн дундын хөрөнгө хуваах, асрамж халамж тогтоох зэрэгт давуу боломж олгох зохицуулалтууд байдаг.

53. Гэр бүлийн гишүүдийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, гэр бүлд хүчирхийлэлгүй амар амгалан байдлыг бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асран халамжлахад эрэгтэйчүүдийн бодитой оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн таниулан ойлгуулах, сурталчлах үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо /цаашид ХБХЭЭХ гэх/-той хамтран явуулж байна. Энэ хамтын ажиллагааны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эхэд хүүхдэдээ хандах эерэг хандлагатай болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг энгийн хүүхдийн адил сургах, давуу талыг нь хөгжүүлэх, нийгэмшүүлэх, амьдрах ухаанд сургах, тэдэнд халамж тусламж үйлчилгээ үзүүлэх зорилгоор ХБХЭЭХ 17 аймаг, нийслэлийн дүүргүүдэд салбар зөвлөлтэй, 4600 гаруй гишүүд, дэмжигчидтэйгээр үйл ажиллагаа нь тогтворжоод байна. Салбар бүрт мэдээллийн төв тухайн орон нутгийн ХТХ-ийн байранд ажиллаж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдэд хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээ, зэрэг асуудлаар зөвлөгөө өгөх, сургалт явуулах зэргээр 5500 гаруй хүнд үйлчилгээ үзүүлжээ. Түүнчлэн 2010 онд нийслэл /Сонгинохайрхан дүүрэг/ болон 8 аймгийн /Орхон, Дархан-Уул, Дорнод, Ховд, Сэлэнгэ, Дундговь Баян-Өлгий, Архангай/ хэмжээнд 97 зөвлөгч эцэг эх бэлтгэгдэж 1500 орчим хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчид үр дүнгээ өгсөн байна⁶.

54. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг төрийн бус байгууллагын сүлжээтэй хамтран Хүүхдийн эрхийн хорооны зөвлөмжид тусгагдсан заалтуудыг хэрэгжүүлэх ажлын байран дээрх сургалтын модуль боловсруулан хэрэгжүүлж эхлээд ажиллаж байна.

55. Мөн Хараагүй иргэдийн сургалт, үйлдвэрлэлийн төв дээр ажлын байрны сургалт зохион байгуулсан байна. Түүнчлэн гамшгийн болон онцгой байдлын үед хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, байнгын асаргаа хэвтэрт байдаг хүүхдийг хэрхэн хамгаалах арга зүй боловсруулах, урьдчилан сэргийлэх арга зүй

⁵ Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол улсын үндэсний III IV тайлан илтгэл

⁶ ХБХ-тэй ажилладаг ТББ-ын сүлжээний гишүүн “ХБХЭЭХ”-ны тайлангаас

боловсруулж байна. Хүүхдийн төлөө сангийн санхүүжилтээр ГССҮТ-ийн нөхөн сэргээх тасаг, “Ухаарахуй төв”, ХБЭЭХ төсөл хэрэгжүүлсэн байна⁷.

2.2 НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ

24 ДҮГЭЭР ЗҮЙЛ

БОЛОВСРОЛ

56. Монгол хүний эрх, эрх чөлөө, нэн ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, ялгаатай байдлыг хүндэтгэх явдлыг бэхжүүлэх зорилготой хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх үйл ажиллагаа амжилттай хийгдэж байна.

57. “Монгол Улсын иргэн сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно...” хэмээн Монгол Улсын Үндсэн хуульд заасан нь хүний ялгаатай байдлыг харгалзахгүйгээр бүх иргэнд сурч боловсрох эрх тэгш үйлчлэх болохын илэрхийлэл болно.

58. Үндсэн хуулийн заалтад нийцүүлэн иргэдийн сурч боловсрох эрхийг “Боловсролын тухай” хууль (2006)-нд “Монгол Улсын иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана” гэж заасан. Энэ нь хүний эрхийг ардчилсан хэм хэмжээнд нийцүүлсэн төдийгүй иргэд боловсрол эзэмшихэд өргөн эрх эдэлж, сурах арга хэлбэрээ сонгох боломж олгож байгаагийн баталгаа болж байна.

59. Түүнчлэн боловсрол нь суралцагчийн хэрэгцээ, хувийн болон хөгжлийн онцлогт нийцсэн олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй байна⁸, эцэг, эх, асран хамгаалагч нь хүүхэддээ 16 хүртэл насанд нь суурь боловсрол заавал эзэмшүүлэх, суралцах хүсэл, сонирхлыг хааж боогдуулахгүй байх үүрэгтэй⁹ зэрэг “Боловсролын тухай” хуулийн заалт нь охид, хөвгүүдийг сурах, боловсрол эзэмших эрхээ бүрэн хэрэгжүүлэх баталгаа болж байна. Энэхүү хуулиар хөгжлийн бэрхшээлтэй суралцагч гэдэг нэр томъёог тайлбарлаж, тэдний сурч боловсрох тэгш боломжийг бүрдүүлэх орчин нөхцөлийг төрөөс хангах, сэргээн засах үйлчилгээ үзүүлэх, ердийн сургууль хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэг хүлээсний гадна хөгжлийн бэрхшээлтэй суралцагч суралцаж буй цэцэрлэг, ЕБС, МСҮТ-д нэг суралцагчид

⁷ ХБХ-ийн оролцоог дэмжих дэд хөтөлбөрийн 2010 оны тайлангаас

⁸ Боловсролын тухай хуулийн 5 дугаар 5.1.3 дэх заалт

⁹ Боловсролын тухай хуулийн 46 дугаар 46.2.3 дахь заалт

ногдох хувьсах зардлыг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээтэй уялдуулан ялгавартай тогтоож санхүүжүүлэхээр тус тус хуульчилсан юм. “Боловсролын тухай” хуульд орсон эдгээр заалтууд нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг нийгэм, хамт олны дунд хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэж улмаар ердийн цэцэрлэг, ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг сургах эрх зүйн орчныг бүрдүүлж өгснөөрөө ихээхэн ач холбогдолтой болсон юм.

60. Монгол Улсын Их хурлаар 2008 онд батлагдсан “Сургуулийн өмнөх боловсролын тухай” хуулийн 9.10-д “Хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгийн ердийн бүлгийн хүүхдүүдтэй хамт сургаж болох бөгөөд хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүртэл хүүхэд нэг бүлэгт байж болно” гэж заасан нь хөгжлийн бэрхшээлтэй сургуулийн өмнөх насны хүүхдүүд эрүүл хүүхдүүдтэй хамтдаа сурч хөгжих боломжийг эрх зүйн хувьд бүрдүүлж өгсний зэрэгцээ нэг ангид байх хүүхдийн тоог зааж өгснөөрөө хөгжлийн бэрхшээлтэй болон эрүүл хүүхдийн аль алинд нь үзүүлэх сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний чанарыг алдагдуулахгүй байхад чиглэгдсэн юм.

61. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургахад чиглэсэн эрх зүйн орчин бүрдүүлэх, бодлого, стратеги тодорхойлж хэрэгжүүлэхэд анхаарч “Монгол Улсын Боловсролын тухай багц (2006 он) хууль”, Монголын боловсролыг 2006-2015 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө, “Хүүхдэд ээлтэй сургуулийг хөгжүүлэх бодлого” “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах хөтөлбөр” зэрэг баримт бичгүүдийг батлуулан хэрэгжүүлж байна.

62. Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 192 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын Боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-нд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үзүүлэх нийгмийн үйлчилгээг өргөжүүлж, тэднийг боловсролд бүрэн хамруулахад чиглэхүйц 11 багц арга хэмжээг гарах үр дүнгийн хамтаар тодорхойлсон. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийг эрт оношлох, нөхөн сэргээх, асаргаа сувилгаа, боловсролын үйлчилгээнд хамруулах, суралцах явцад үүсч буй бэрхшээлийг оношлон сурах бэрхшээл үүссэн хүүхдэд тухайн бэрхшээлээс гарахад нь туслах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ердийн сургуульд хамруулан сургах, ердийн сургуулийн багш, суралцагчдад мэргэжлийн байгууллагууд, ажилтнуудаас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчныг бий болгох ажлуудыг тус тус тусган хэрэгжүүлж байна.

63. Хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, тэднийг өөрсдийнх нь боломжид тулгуурлан хөгжүүлэх нь үр дүнтэй байдаг билээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч хөгжих эрхийг хангах зорилгоор бодлогын түвшинд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

64. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол эзэмших эрхийг ханган тэдэнд чанартай, хэрэгцээнд нь нийцсэн, үр өгөөж бүхий боловсрол эзэмшүүлэхэд чиглэгдсэн “Хүүхдэд ээлтэй сургуулийг хөгжүүлэх бодлого”-ын баримт бичгийг БСШУ-ы сайдын 2004 оны 190 дүгээр тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Энэхүү бодлого нь багш-суралцагч-эцэг эх-олон нийтийн бие биенээ ойлгож хүндэтгэсэн таатай харилцаанд суурилсан, хүүхэд бүрийн онцлогийг харгалзсан, сурлагын амжилтын үр дүнгээр болон хөгжлийн бэрхшээл, амьдралын нөхцөл байдлаас үүдэн хүүхдийг ялгаварлах аливаа хандлагыг халсан; сургалтын ардчилсан, оролцоонд суурилсан, хүүхэд төвт сургалтын арга зүйд тулгуурласан; аюулгүй, хэвийн материаллаг орчин бүхий хүүхдэд ээлтэй сургалтын орчин, үйл ажиллагааг бий болгоход чиглэгджээ. Эл бодлогод хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд адил тэгш суралцах боломж олгох, суралцах эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, тусгай дэмжлэг тусалцаа үзүүлэхээр заасан байна. Уг бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сургууль бүрт 9 чиглэлээр сургалтын модул боловсруулан 2 удаагийн үе шаттай Үндэсний сургалт зохион байгуулсны нэг нь “Сургуульд тэгш боломжтой, суралцах таатай орчныг бүрдүүлэх арга зүй”-н сургалтын модуль юм. Уг сургалтын модульд бүх хүүхдийг зохих насанд нь боловсролд хамруулж, сургалтын үйл ажиллагаанд тэдний идэвхтэй оролцоог хангах, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч тэдний суралцах, хөгжих үйл явцыг дэмжих, тэдэнд тохиолдох бэрхшээлийг илрүүлэх, түүнийг даван туулахад туслах зорилго агуулсан болно.

65. БСШУ-ы сайдын 2005 оны 387 дугаар тушаалаар “Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын хөтөлбөр”-ийг баталж, 2005-2006 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын сургуулиудад мөрдөж байна. Энэхүү хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол эзэмшүүлэхэд тэдний бэрхшээлийн онцлогт тохируулан уян хатан, эрэлт хэрэгцээнд нь нийцсэн сургалт явуулахад чиглэгдсэнээрээ ач холбогдолтой байгаа юм.

66. БСШУ-ы сайдын 2005 оны 387 дугаар тушаалаар “Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын хөтөлбөр”-ийг баталж, 2005-2006 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын сургуулиудад мөрдөж байна. Энэхүү хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол эзэмшүүлэхэд тэдний бэрхшээлийн онцлогт тохируулан уян хатан, эрэлт хэрэгцээнд нь нийцсэн сургалт явуулахад чиглэгдсэнээрээ ач холбогдлоо өгч байна. Мөн ЕБС-ийн сурагчдын сурлагын дүнгээс хамааран тэдний нэр хүндийг хамгаалах, багш, сурагчийн болон сурагчдын хоорондын харилцаанд үүсэх сөрөг үр дагаврын нөлөөллийг багасгах, сурагчдын өөртөө итгэх итгэл, эрхэмсэг оршихуйг дэмжих, сурах хүсэл сонирхлыг урамшуулж хувийн нууцад нь хамаарах дүнгийн нууцлалыг хадгалах зорилгоор БСШУ-ы сайдын тушаалаар 2005 оноос эхлэн ЕБС-д суралцагчийн дүнгийн нууцлалын системийг хэрэгжүүлж байна. Энэ нь хүүхэд бүрийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тулгардаг сурлагын

дүнгээс үүдэн тэдэнд тулгардаг хүндрэлтэй асуудлуудыг арилгахад тус нэмэр болсон арга хэмжээ юм.

67. Бага ангийн хүүхдийн хичээл таслалт, сургууль завсардалтыг багасгах, сурагчдын эрүүл мэндийг хамгаалах улмаар сургалтын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн “Үдийн цай хөтөлбөр”-ийг Засгийн газар 2006-2007 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын сургуулийн бага ангид хэрэгжүүлж байна. Үдийн цайны 1 хүүхдэд ногдох зардал 300 төгрөг байсныг 2008 онд Засгийн газраас 400 төгрөг болгож нэмэгдүүлсэн.

Хүснэгт 4. ЕБС-ийн сурагчдын “Үдийн цай” хөтөлбөрт хамрагдалтын байдал, 2006-2010

Хичээлийн жил	Анги	Нэг хүүхдэд ногдох зардал /төгрөг/	Хамрагдсан хүүхэд /мянгаар/	Санхүүжилт /тэрбум төгрөг/
2006-2007	I-III	300	109.9	9.6
2007-2008	I-IV	400	187.8	16.5
2008-2009	I-V	400	252.6	18.5
2009-2010	I-V	400	273.9	17.7

68. БСШУ-ны сайд, ЭМ-ийн сайд, НХХ-ийн сайдын хамтарсан тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах хөтөлбөр (2004-2008)-ийг батлан хэрэгжүүллээ. Энэ хөтөлбөрт хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд суралцах нөхцөл бололцоог хангах, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тусгай сургуульд суралцуулах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрийг ерөнхий боловсролын сургуульд хамруулан сургах бодлогыг тодорхойлсон юм.

69. ҮСГ, БСШУЯ хамтран НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхцөл байдлын зураглал” судалгааг хийж, түүнд суурилсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаархи бодлогын зөвлөмжийг боловсруулсан юм. Үндэсний статистикийн газрын 2006 оны судалгаагаар 0-16 насны хөгжлийн бэрхшээлтэй нийт 6897 хүүхдийн 37 орчим хувь нь олдмол хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй байгаагийн дотор 75.6 хувь нь ердийн өвчнөөс, 18.9 хувь нь ахуйн ослоос, 2 хувь нь мэргэжлээс шалтгаалах өвчнөөс, үлдсэн 3.5 хувь нь үйлдвэрлэлийн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Хүснэгт 5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт

<i>Хичээлийн жил</i>	<i>Нийт суралцагчдын тоо</i>	<i>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо</i>	<i>Нийт суралцагчдад эзлэх хувь</i>
2006-2007	122536	1058	8.6
2007-2008	130758	1031	7.8
2008-2009	130710	988	7.5
2009-2010	142065	1156	8.1

Эх үүсвэр: БСШУЯ-ны статистик мэдээ

Хүснэгт 6. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ерөнхий боловсролд хамрагдалт

<i>Хичээлийн жил</i>	<i>Нийт суралцагчдын тоо</i>	<i>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо</i>	<i>Нийт суралцагчдад эзлэх хувь</i>
2006-2007	542505	38569	7.1
2007-2008	537546	35899	6.6
2008-2009	532058	23969	4.5
2009-2010	522066	22966	4,3

70. 2009-2010 оны хичээлийн жилийн Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам (БСШУЯ)-ын мэдээгээр 1-ээс 11 дүгээр ангид нийт 22966 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа нь нийт суралцагчдын 4.3 хувь нь болж байна. Хөгжлийн бэрхшээлтэй нийт суралцагчдын 51,5 хувь нь эмэгтэй суралцагч байна. Бага боловсролын түвшинд 11311 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч суралцаж байгаагийн 5364 буюу 47,4 хувь нь эмэгтэй суралцагч байна. Бага боловсролд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бэрхшээлийн байдлаар нь авч үзвэл, харах эрхтний бэрхшээлтэй-3943, сонсох эрхтний бэрхшээлтэй-1984, хэл яриа өгүүлэх эрхтний бэрхшээлтэй 2315, оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй 1208, бие эрхтний хөгжлийн бэрхшээлтэй 1147, хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй 714 суралцагч байна.

71. “Улсын болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад төрөөс буцалтгүй тусламж олгох журам”-ын хоёрдугаар хэсэгт

2.1.5-д “хөгжлийн бэрхшээлтэй суралцагч буюу эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сургалтын төлбөр”-ийг Сургалтын төрийн сангийн хяналтын орон тоонд багтаан буцалтгүй тусламж хэлбэрээр олгохоор журамлаж, энэ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг хамруулж байна.

72. Засгийн газрын 177 дугаар тогтоолын хүрээнд 2010 оны сүүлийн хагас жилийн байдлаар их дээд сургууль, коллежд суралцагч 215 хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст 22.8 сая төгрөгийн сургалтын төлбөрийг нь санхүүжүүлээд байгаа бөгөөд сүүлийн 4 жилийн байдлаар давхардсан тоогоор 900 орчим суралцагчид хамрагдаад байна.

73. 2011-2012 оны хичээлийн жилээс ОХУ-ын Засгийн газрын тэтгэлгээр 1 оюутныг тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр суралцуулахаар шийдвэрлээд байна.

74. Монголын Мянганы сорилын сангаас зарлагдсан Тэргүүн туршлага түгээн дэлгэрүүлэх төслөөр Сэргээн засалтын Үндэсний төвийн “Сонсголын бэрхшээлтэй иргэдийг мэргэжлийн боловсролд тэгш хамруулах нь” төслийг дэмжин хоёр дахь жилдээ хэрэгжүүлж байна.

75. Төрийн өмчийн их, дээд сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад зориулсан 389,8 сая төгрөгийн өртөг бүхий номын сангийн тусгай хэрэглэгдэхүүн, тоног, төхөөрөмжийг 2009 онд улсын төсвийн хөрөнгөөр худалдан авч, Монгол Улсын Боловсролын их сургууль, Монгол Улсын их сургууль, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, түүний харьяа Дарханы Технологийн сургуулиудад нийлүүсэн бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын хэрэгцээнд ашиглаж байна.

76. Монгол Улсын “Боловсролын тухай” хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүлээн авч сургах үүргийг ЕБС-иудад хүлээлгэсэн байгаа. Одоогоор ямар нэгэн байдлаар хөгжлийн бэрхшээлийн улмаас хүүхдийг сургуульдаа авахаас татгалзсан тохиолдол гараагүй бөгөөд сургалтын явцад тухайн хүүхдэд тулгамдаж буй хүндрэл бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх талаар сургууль, багш нарын туршлага дутмаг, сургалтын тусгай хэрэглэгдэхүүний хангамж тааруу байгаагаас шалтгаалж сургуульд элсээд дараа нь гарах тохиолдол байсаар байна. Мөн үүнд нөлөөлж буй хүчин зүйлийн нэг нь ялангуяа төв суурин газарт анги дүүргэлт өндөр байгаатай холбоотой байна. Нөгөө талаас хэдийгээр нотлох баримт хангалттай байхгүй ч сүүлийн үед эдгээр хүүхдийн бэрхшээл ихээхэн хүндэрч улам давхцах тохиолдол ихэсч байгаа нь нөлөөлж байх талтай байна.

77. “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах” хандлагын талаарх ойлголт, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрүүд, хүүхдүүдтэй хэрхэн харилцах арга зам, хамран сургалтын зарчмын талаарх сургалтанд сургуулийн менежер, багш, эцэг эх, эмч, хүүхдийн элч, нийгмийн

ажилтнуудыг хамруулсан. Уг сургалтанд 2008-2010 онд нийт 1800 хүмүүс сургалтанд хамрагдаж, үүний үр дүнд нийт 8660 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ЕБС-д сурч байна.

78. Гэсэн хэдий ч ЕБС-д амжилттай суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо элсэж орсноосоо бага байна. Энэ нь доорх хэд хэдэн шалтгаантай байна.

1. ЕБС-ийн багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай хэрэгцээг мэдэхгүйн улмаас зарим хүүхэд бэрхшээж сургуулиа орхиж байна.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилласан багшид нэмэлт урамшуулал байхгүйн улмаас багш хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ангидаа авах дургүй байдаг.
3. Багшийн үнэлгээг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын чанар доош татдаг.
4. ЕБС-ийн тогтолцоонд Хамран сургах (Inclusive education) ойлголт сонгодог утгаараа хэрэгжихгүй байна.
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг зөөх, тээвэрлэх, тусгай хэрэгцээт сургалтын материалаар хангах зэрэг сургуульд сурах таатай орчныг бүрдүүлээгүйгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ЕБС-ийг төгсөж чадахгүй байна.

Иймээс дээрх бэрхшээлүүдийг даван туулах арга замыг тодорхойлж, шийдвэрлэх шаардлага тулгарч байна.

79. БСШУЯ-наас сонсгол, хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын онцлог хэрэгцээнд нийцүүлэн сүүлийн үеийн сонсголын аппарат, чихний суулгацаар хангах зорилгоор тус сургуульд 130,0 гаруй сая төгрөгийн өртөг бүхий Дани улсын WIDEX фирмийн сонсголын аппаратыг нийлүүлэн, сонсгол судлалын төвийг байгуулан ажиллуулж байна. Тус төвд сонсгол судлалын мэргэжлийн эмч, техникийн ажилтан ажиллаж тус сургуулийн сурагчдын сонсголыг шалган, шаардлагатай багаж, сонсголын хэрэглэгдэхүүнээр хангах, засварлах, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулж байна.

80. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч суралцаж буй цэцэрлэг, ЕБС, МСҮТ-д нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг суралцагчийн тусгай хэрэгцээтэй уялдуулан ялгавартай тогтоож санхүүжүүлэхээр Боловсролын тухай хуульд заасны дагуу БСШУ-ны Сангийн сайдуудын хамтарсан тушаал 2007 онд гарч “ЕБС-ийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээг тооцох итгэлцүүр”-ийг баталсан. Гэсэн хэдий ч Ерөнхий боловсролын сургуулиудад суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оношлох журам, тусгайлсан

аргачлал байхгүй байгаагаас одоогийн байдлаар энэхүү итгэлцүүрийг ашиглаж чадахгүй байна. Цаашид улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлийг илрүүлэх, оношлох нэгдсэн аргачлал боловсруулан хэрэгжүүлэх нь хойшлуулалгүй шийдвэрлэх асуудал болж байна.

81. Манай улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдлэг, чадварыг үнэлэх үнэлгээний систем өнөө хүртэл төлөвшөөгүй нь ердийн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургахад зарим талаар бэрхшээл учруулж байгаа юм. Энэ нь бага, дунд боловсролын сурлагын амжилтыг үнэлэх бүхий л төрлийн шалгалт /анги дэвших болон сургууль төгсөх, Улсын мэргэжлийн хяналтын газар, аймгийн Боловсрол, соёлын газраас авч буй түвшин тогтоох шалгалт гэх мэт/-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амжилтаас шалтгаалан сургууль, ангийн сурлагын амжилт нь доогуур үнэлэгдэх тохиолдол гарч байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургууль, багш нар хүлээн авч сургахаас зарим талаар татгалзахад хүргэж, улмаар тэд боловсролд тэгш хамран сурах эрхээ алдахад ч хүрч байгааг үгүйсгэх аргагүй. Эл байдалд дүгнэлт хийж, *хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн хүүхдийн нэгэн адил арга зүйгээр үнэлж буй үнэлгээний өнөөгийн арга хэлбэрийг өөрчилж, тэдний онцлог, ялгаатай байдлыг харгалзан хөгжлийн ахицаар нь үнэлэх үнэлгээний оновчтой системийг бүрдүүлэх зорилгоор БСШУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2010 оны тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллуулж байна. Уг ажлын хэсгээс “Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг судлах, үнэлэх журам”-ын төслийг боловсруулан 2010 оны 3, 7-8 дугаар сард Ховд, Сэлэнгэ, Улаанбаатар хотод нийт 4 хэлэлцүүлэг зохион байгуулж, 120 гаруй багш, эцэг эх, захирал, эмч, олон нийтийн байгууллагын төлөөллийн саналыг авч тусган журмын төслийг эцэслэн боловсруулж дуусгалаа.*

82. Бага, дунд боловсролын тухай хуулийн 13.2 дах хэсгийг үндэслэн БСШУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2010 оны 7 дугаар сарын 5-ний өдрийн 325 дугаар тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг илрүүлэх, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын цогц үйлчилгээ үзүүлэх арга зүй, аргачлал боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллуулж байна. Уг ажлын хэсгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд нийгмийн цогц үйлчилгээ үзүүлэх арга зүй болон Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг илрүүлэх арга хэрэгслийг боловсруулан, турших ажлыг Баянхонгор, Завхан, Улаанбаатар хотын 2 дүүрэгт зохион байгууллаа.

83. БСШУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2005 оны 58 тоот тушаалаар байгуулагдсан дохионы хэлний мэргэжилтэн, тусгай сургуулийн багш, сонсголгүй болон хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагын төлөөлөл, монгол хэлний мэргэжилтэн нараас бүрдсэн ажлын хэсгээс 3000 үгтэй “Монголын дохионы хэлний толь бичиг” боловсруулан хэвлүүлж 2006



онд олон нийтэд хүргэлээ. Дохионы хэлний анхан шатны сургалтыг 3 аймаг, багш бэлтгэдэг сургуулийн багш, оюутан, түүнчлэн цагдаагийн болон хүүхдийн байгууллагын ажилтан, эцэг эх, ерөнхий боловсролын сургуулийн сурагч зэрэг нийт 3000 гаруй хүнийг хамруулан зохион байгууллаа. Дохионы хэлний толь бичигт үндэслэн аймаг, нийслэлд дохионы хэлний сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөр, багш нарт зориулсан сургалтын гарын авлага боловсруулан гаргав. Энэхүү сургалтын хөтөлбөрийн дагуу аймаг, нийслэлийн дохионы хэлний сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулж, түүнд аймаг бүрээс 2-3 багшийг хамруулж, орон нутагт сургалт явуулах 65 хүний нөөцийг бүрдүүлсэн байна. Мөн дохионы хэлний анхан, дунд, гүнзгий шатны сургалтын хөтөлбөр боловсруулаад байна.

84. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургахад багшийг бэлтгэх, улмаар тэдэнд тусгай хэрэгцээт боловсрол шаардлага бүхий хүүхэдтэй ажиллах онол, арга зүйн мэдлэг олгож, туршлага эзэмшүүлэх нь нэн чухал. Эл асуудлыг шийдвэрлэх зорилгоор зарим арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа хэдий ч одоо ажиллаж буй болон багш боллоор суралцаж буй оюутнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалт ихээхэн шаардлагатай байна.

85. Монгол улсын Боловсролын Их сургууль ЕБС-ийн багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын төлөвлөгөөнд 2004 оноос эхлэн “Тусгай хэрэгцээт боловсрол” сургалтын хөтөлбөрийг шинээр оруулж, 60 багш энэ чиглэлээр мэргэжлээ дээшлүүлжээ.

86. БСШУ-ны сайдын 2010 оны тушаалаар батлагдсан Мэргэжил дээшлүүлэх кредитын сургалтаар багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн чиглэлээр сургалт зохион байгуулах эрх олгогдож дээрх сургалтуудад хот, хөдөөгийн 1500 гаруй багш хамрагдаж хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйгээ дээшлүүлсэн байна.

87. Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлд “Боловсролын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна”, мөн 43 дугаар зүйлд “хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг сурах нөхцөл, бололцоогоор төрөөс хангах” гэж хуульчилсан байна. Иймээс Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр сүүлийн жилүүдэд ихээхэн анхаарч, үүнд зориулсан улсын төсвийн хөрөнгө жилээс жилд нэмэгдэж байна.

88. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах явцад тэднийг нөхөн сэргээх, засан сайжруулах үйлчилгээнд хамруулах

нөхцөлийг бүрдүүлэх /техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүний/ хангамжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллалаа.

89. БСШУЯ-наас харааны бэрхшээлтэй хүүхдийн 116 дугаар тусгай сургуулийн сургалтын орчныг сайжруулах зорилгоор 2006 онд ADRA-Монгол олон улсын байгууллагатай хамтран тус сургууль дээр сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоноглогдсон 16,3 сая төгрөгийн өртөг бүхий аудио студийг байгуулан харааны бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд зориулсан дижитал материалыг бэлтгэх орчин нөхцөлийг бүрдүүлэн ашиглаж байна. Тус студиэс ерөнхий боловсролын сургуулийн харааны бэрхшээлтэй сурагчид, оюутан, залуус, нийт иргэдэд зориулан эрүүл мэнд, хууль эрх зүй, амьдрах ухааны чиглэлээр нийт 35 багц CD-г бэлтгэн аймаг нийслэлийн номын сангуудад хүргэсний зэрэгцээ тус сургуулийн сурагчдын хэрэгцээнд ашиглаж байна. Энэхүү багц материалд ерөнхий боловсролын сургуулийн монгол хэл, нийгмийн ухаан, түүх, монголын түүх зэрэг 8 сурах бичгээс суут хүмүүсийн сургааль, эдийн засгийн ухаан, ДОХ болон архи, тамхины хороос сэргийлэх, нөхөн үржихүйн эрүүл мэнд, Эрүүл байхын тулд хүүхдүүд юу хийх вэ, Эрүүл мэнд ба эрүүл орчин, Монгол улсад мөрдөж байгаа хуулийн холбогдох заалтуудаас түүвэрлэн сургалтын хэрэглэгдэхүүн болгон сурагчдад сонсгох шаардлагатай хэсгийг багш нарын саналаар түүвэрлэн “Ярьдаг ном” болгон сургалтандаа ашиглаж байна.

90. Тусгай сургуулиудад суралцагчдын хөгжлийн бэрхшээлийн онцлогт үндэслэн уг ажлыг зохион байгуулсан бөгөөд принтер, хэвлэмэл материал уншигч төхөөрөмж, зөөврийн брайль дэлгэц, бичвэр томруулагч, анги нийтийн сонголын аппарат, хэл заслын тоног төхөөрөмж, харааны бэрхшээлтэй хөгжимчдэд зориулсан программ хангамж, график, томъёо зэргийг брайл руу хөрвүүлэгч программ, текст зургийг брайл руу хөрвүүлэгч программ, текстийг аудиоогоор уншигч программ болон хөгжмийн сургалтад зориулсан 300 гаруй нэр төрлийн техник хэрэгслийг тус тус нийлүүлсэн юм. 2008 онд Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуулийн дэргэд 130 хүүхдийн ор бүхий дотуур байрыг барьж ашиглалтад оруулсны зэрэгцээ 2010 онд улсын төсвөөс 1,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 150 хүүхдийн ор бүхий хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэгийн барилгыг барих ажлыг зохион байгуулж байна. Мөн БСШУЯ, Английн Хүүхдийг ивээх сангийн хамтарсан хөрөнгө оруулалтаар 2008 онд Тархины саажилттай хүүхдийн 10 дугаар цогцолборын дэргэд 150,0 гаруй сая төгрөгийн өртөг бүхий “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхөн сэргээлтийн төв”-ийг байгуулан ажиллуулж байна.

91. БСШУЯ 2008 онд ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комисстой хамтран “Брайль ном” хэвлэх төсөл хэрэгжүүлэн “Цагаан толгой”, Монгол хэл 2,3” Математик 1,2 сурах бичгүүдийг тус сургуулийн багш нар болон МУБИС-ийн багш нар хамтран боловсруулж хэвлэн хичээл сургалтандаа ашиглаж байна. 2000-2009 оныг хүртэл Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам Олон улсын дэмжлэг

туслалцаа төлөөлөгчийн газартай “Хамтын ажиллагааны гэрээ” байгуулан Харааны бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуульд суралцдаг нийт сурагчдыг хичээлийн жилд нийтдээ 8000 еврогийн өртөг бүхий нэг удаа цүнх, хичээлийн хэрэгсэл болон жилийн хэрэгцээний брайл цаасаар хангах ажлыг зохион байгуулж ирсэн.

92. Түүнчлэн 2011 оны улсын төсөвт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах орчныг бүрдүүлэх зорилгоор 400,0 сая төгрөгийг тусгасан бөгөөд уг санхүүжилтээр ерөнхий боловсролын 20 сургуулийн бие засах газар, зам талбайг бэрхшээлийнх нь онцлогт нийцүүлэн байгуулах ажлыг зохион байгуулна. Монгол Улсын 2011 оны Төсвийн тухай хуулиар боловсролын салбарын их засварт батлагдсан хөрөнгөөс Харааны бэрхшээлтэй хүүхдийн 116 дугаар тусгай сургуулийн засвар, нийслэлийн 70 дугаар сургуулийн шинэ барилга, 25 дугаар тусгай сургуулийн их засвар хийхээр тус тус хөрөнгө батлагдан зохих үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

25 ДУГААР ЗҮЙЛ

ЭРҮЛ МЭНД

93. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрүүл мэндийн анхан шатны тусламжийг өрх, сумын эмнэлгүүд, төрөлжсөн мэргэжлийн тусламжийг үндэсний төв, клиникийн эмнэлгүүд, тусгай мэргэжлийн төвүүд үзүүлдэг. Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн дагуу бүх хүмүүс, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, эрүүл мэндийн үйлчилгээг үнэ төлбөргүй авдаг. Зөвхөн гуравдагч шатлалын эмнэлэгт тодорхой шинжилгээнүүдийг хийлгэхэд Монгол улсын иргэн тодорхой хэмжээний мөнгөн төлбөр төлнө.

94. Архаг өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон настанд үзүүлэх тусламж, үйлчилгээг сайжруулахаар “Настанд ээлтэй өрхийн эмнэлэг”-ийг шалгаруулах ажлыг уламжлал болгон зохион байгуулахын зэрэгцээ гэрийн сэргээн засалтын тусламжийг багаар үзүүлэх ажлыг шинээр нэвтрүүлсэн.

95. Хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх зорилгоо 0-5 настай хүүхдийн хэвийн өсөлт хөгжилтийг гэр бүлийн түвшинд эцэг эхчүүд ба өрх, сум, багийн эмч нар хянаж байхаар “0-5 настай хүүхдийн өсөлт хөгжилтийг хянах дэвтэрийг” 2010 оноос эхлэн хөтөлж хэрэгжүүлж эхэлсэн.

96. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулахаар “Тэгш дүүрэн” хөтөлбөрийн хүрээнд сэргээн засалтын эмч, гэмтлийн эмч, мэс заслын эмч зэрэг нарийн мэргэжлийн эмч нарт клиникийн сэргээн засалтын сургалтыг Сэргээн засахын мэргэжлийн салбар зөвлөлтэй хамтарч 2008 оноос хойш зохион байгуулж байна:

- Сургалтад хамрагдсан эмч нар өөрийн орон нутгийн сумын болон өрхийн эмч нарт кредиттэй сургалтыг зохион байгуулж нийт 500 гаруй нарийн мэргэжлийн эмч сургалтанд хамрагдсан.
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах – Тэгш дүүрэн” хөтөлбөрийн хүрээнд ЭМШУИС–ын Сургалтын дараах албатай хамтран орон нутгийн нэгдсэн эмнэлэгт ажиллаж байгаа сувилагчийг сэргээн засалтын мэргэжил олгох 3 сарын сургалтанд 2008 оноос хойш хамруулж байна. 2008-2010 онд 136 сувилагчдыг сэргээн засалтын мэргэжлийн сувилагч болгосон.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үүднээс олон арга хэмжээг ээлж дараалан зохион байгуулан ажиллаж байна. Жишээ нь: 2010 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон улсын эрхийн өдрөөр хөгжлийн бэрхшээлтэй 200 хүнд чихрийн шижинг оношлох шинжилгээг үнэ төлбөргүйгээр хийж өвчнийг эрт илрүүлэх болон хэрхэн урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө өгөв.

97. Иргэний эрүүл мэндийн даатгалын талаарх өнөөгийн хууль тогтоомжууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн даатгалын аливаа үйлчилгээнээс ялгаварласан заалтгүй бөгөөд харин ч зарим талаар илүү боломж бий болгосон байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төр хариуцаж байгаа ба Хүний хөгжил сангаас Эрүүл мэндийн даатгалын санд төлөх хэлбэрээр хэрэгжиж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүн нь бусад иргэдийн нэг адил Эрүүл мэндийн даатгалын сангаас дараах үйлчилгээ авдаг. Үүнд:

- Өрхийн эмнэлгээс эрүүл мэндийн үйлчилгээ авах
- Клиник эмнэлэгээр үзүүлж буй эрүүл мэндийн үйлчилгээ
- Клиник эмнэлэгт үнэ төлбөргүй хэвтэж эмчлүүлэх
- Эрүүл мэндийн яамнаас магадлан итгэмжилсэн эмийн сангуудаас нэр бүхий 360 гаруй эмийн хөнгөлөлт авах гэх мэт

98. Хөгжлийн бэрхшээлтэй хүн Нийгмийн даатгалын сангаас үйлчилгээ авах эрх нь үүссэн тохиолдолд Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез, ортопедийн үнийн хөнгөлөлт авах боломжоор хангагддаг. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй ажилтантай ажил олгогч нь Нийгмийн даатгалын санд төлөх ажилгүйдлийн ба эрүүл мэндийн даатгалын шимтгэлээс бүрэн хэмжээгээр чөлөөлөгддөг.

26 ДУГААР ЗҮЙЛ

СЭРГЭЭЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

99. Хөгжлийн бэрхшээлтэй хүний нөхөн сэргээх үйлчилгээг Монгол Улсын “Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгааллын тухай” хуулийн 6 дугаар зүйлд зааснаар эрүүл мэнд, мэргэжил, боловсрол, хөдөлмөр, нийгмийн, сэтгэл зүйн гэсэн төрөлтэйгээр эмчилгээ, сувилгаа, сургалт, протез, ортопедийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхэлдэг ААН үзүүлэхээр хуульчилсан. Нийгмийн халамжийн сангаас үүнтэй холбоотой зардлыг хэсэгчлэн ба бүрэн хэмжээнд санхүүжүүлж, сэргээн засах үйлчилгээг иргэн, хувийн хэвшлийн ААН, ТББ-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, байна.

100. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сэргээн засах үйлчилгээг үндэсний хэмжээнд Сэргээн засалтын үндэсний төв гэх улсын үйлдвэрийн газар үндсэнд нь гүйцэтгэдэг ба үйл ажиллагааны чиглэлийг нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулиар тодорхойлсон сэргээн засалтын үйлчилгээний олон төрөл, бодит хэрэгцээнд тулгуурлан шинэчлэн тогтоосон. Уг төв хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэргэжил олгох, эмнэлгийн болон мэргэжлийн сэргээн засалт хийх, нийгэмшүүлэх, сэргээн засалтын үйл ажиллагаанд нийгэм, хамт олон, гэр бүлийг татан оролцуулах, протез, ортопедийн хэрэгслийг улсын хэмжээнд үйлдвэрлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүрэгтэйгээр ажилладаг.

101. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээнд тохирсон дэд бүтэц бүхий үйлчилгээний загвар бий болгох зорилгоор АХБ-ны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн НХСХХ-ийн хүрээнд АХБ-ны зээл тусламжаар төвийн өргөтгөлийг ашиглалтад оруулж, БНСУ-аас тоног төхөөрөмжийн дэмжлэг авч, Сургалт, мэргэжлийн зөвлөгөө өгөх, протезийн үйлдвэр, олон нийтийн хөгжлийн зэрэг 6 үндсэн нэгжтэй ажиллаж байна. Жишээ нь:

- 2010-2011 оны хичээлийн жилд 6 тусгай сургууль, нийслэлийн дүүргүүдээс 116 хөгжлийн бэрхшээлтэй оюутныг оношилгооны үндсэн дээр элсүүлж, 9 мэргэжлээр сургаж байна.
- 2010 онд 2626 хүнийг үзлэгт хамруулж, 88 хүнд дуудлагаар үйлчилж зөвлөн, шаардлагатай протез, ортопедийн хэрэгслийг үйлдвэрлэх, сэргээн засах, дасган сургах үйлчилгээг зохион байгуулсан байна. Тэдгээрийн 39.1 % нь орон нутгаас ирж үйлчлүүлсэн байна. Тусгай дугаар бүхий лавлах утсаар 300 гаруй хөгжлийн бэрхшээлтэй Хүнд мэдээлэл, зөвлөгөө өгч, ажилласан байна.

102. Сэргээн засалтын Үндэсний төв нь орон нутагт бүтэцгүй, эрүүл мэндийн нөхөн сэргээх үйлчилгээний тасаг нь хүчин чадал багатай байдаг нь

протез, ортододийн хэрэгслээр орон нутгийн иргэдийг бүрэн хэмжээгээр хангах, засварлах, клиник эмчилгээгээр нөхөн сэргээхэд хүндрэлтэй байдаг.

Орон нутгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дэргэд байгуулагдсан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сэргээн засах үйлчилгээний тасгууд нь эрүүл мэндийнхээс бусад нөхөн сэргээлтийн үйлчилгээг үзүүлэх боловсон хүчин дутагдалтай ба эрүүл мэндийн нөхөн сэргээлт үзүүлэхэд зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжөөр дутагдах явдал нийтлэг гардаг.

103. Сүүлийн жилүүдэд нөхөн сэргээлтийн асуудлаар хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих, ТББ-уудыг чадавхижуулах чиглэлээр ажиллаж байна. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн сэргээх хөтөлбөрийг өргөжүүлэх, энэ чиглэлээр “Тэгш дүүрэн” хорооны үйл ажиллагааг уялдуулах, Боловсролын Их сургуулийн хичээлийн хөтөлбөрт 20 цагийн хөтөлбөр тусгуулах зэргээр нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагыг төлөвшүүлэхэд анхаарч байна.

104. Гэвч эрүүл мэндийнхээс бусад төрлийн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх нөхцөл боломж муу, энэ чиглэлээр үндэсний боловсон хүчин бэлтгэгдээгүй, хэрэгцээ бүрэн төгс тодорхойлогдоогүй байгаа нь өнөөг хүртэл ноёрхож байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүнийг халамжлах гэдэг хандлага нийгэмд амь бөхтэй оршин тогтносоор байгаагийн илэрхийлэл юм.

105. Монгол Улсын төрөөс эрүүл мэндийн асуудлыг онцгойлон анхаарч, холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа боловч нийгмийн зүгээс анхаарал шаардаж буй хүн амын дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо, зарцуулах хөрөнгө жил ирэх тутам өсч байна. Энэ нь нөхөн сэргээлтийн үйлчилгээний зэрэгцээ хөдөлмөрийн чадвар алдалтыг тодорхойлох, тооцох аргачлалтай холбоотой байх талтай. Жишээ нь:

- Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо 2010 онд өмнөх оныхоос 2.2 % нэмэгдсэн байна. Хөдөлмөрийн чадвар нь сэргэсэн буюу сайжирсан 6353 хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалжээ. (Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах төв комиссын 2010 оны тайлангаас)

106. Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, улмаар хоёрдогч, гуравдагч хүндрэлд оруулахаас урьдчилан сэргийлэх, тэдний хэрэгцээг тодорхойлж, тохирох эрүүл мэндийн сэргээн засалтын тусламж үйлчилгээг үзүүлэх зорилгоор багийн бага эмч, өрх, сумын эмч нарт 10 хоногийн кредиттэй сургалт явуулдаг. Уг сургалтанд 2008-2010 онд нийт 5500 эмч нар хамрагдсан байна.

107. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тухайн баг, сум, өрхийн эмч нар эмнэлэг, амбулаторын үзлэгээр үзүүлэхээс гадна гэрийн эргэлтийг хийж, тэднийг эрт илрүүлэх, хэрэгцээг тодорхойлох,

тохирох сэргээн засах эмчилгээг үзүүлж, гэр бүлийнхэнд нь зааж өгч, эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээ үзүүлдэг. Хөтөлбөрийн хүрээнд “Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ба тэдний ар гэрийнхэнд туслах сайн дурын гэрийн үйлчилгээ” -ний багууд 21 аймаг 8 дүүргийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг. Бүрэлдэхүүнд нь эмч, сувилагч, нийгмийн ажилтан, сайн дурын идэвхтэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөллүүд ордог. Жишээ нь:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хэлбэрийн 3700 орчим хүнд сэргээн засах тусламж үйлчилгээг гэрээр үзүүлсэн.
- Эрүүл мэндийн сэргээн засалтанд 27,500 хүнийг хамруулсан байна.

27 ДУГААР ЗҮЙЛ

АЖИЛ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ

108. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх тэгш эрхийг хангах, бусад иргэдтэй нэг адил ижил ажилд тэнцүү цалин хөлс авах, хөдөлмөрийн аятай тавтай нөхцлөөр хангуулах, тэдний хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжих эрх зүйн зохицуулалт Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай”, “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулиудаар бий болсон. Түүнчлэн Засгийн газрын нэгдэн орсон “Ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтэд алагчлахгүй байх тухай” ОУХБ-ын 111 дүгээр Конвенцийн дагуу ижил ажилд тэнцүү цалин хөлс авах зарчмыг хөдөлмөрийн хүрээндээ баримталдаг ба энэ нь хөдөлмөрийн харилцааны хууль тогтоомжуудад тусгагдсан байдаг. Гэвч ажил олгогчдын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй ажилтны хөдөлмөрийн бүтээмж, ур чадвар муу гэх шалтгаанаар бусад иргэдээс бага цалин хөлс олгох тохиолдол гардаг боловч энэ талаарх хөдөлмөрийн маргаан, зөрчил, баримт мэдээлэл одоогоор тэмдэглэгдээгүй байна.

109. Хуулийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг үндсэн 4 хэлбэрээр дэмжиж байна. Үүнд:

- Квот (Хөдөлмөрийн тухай хууль)
- Квотын бус (Хөдөлмөрийн зах зээлд хөдөлмөрийн чадвар алдалтын бага хувьтай иргэнийг ажлын байраар хангах зарчмаар хэрэгждэг)
- Хөдөлмөр эрхлэлтийн хамгаалагдсан систем (хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хэлбэр)

- Давуу эрх хуваарилах систем (Хөгжлийн бэрхшээлийн төрөлд нийцүүлэн ажлын байрыг олноор бий болгох)

110. “Хөдөлмөрийн тухай” хуулиар хөгжлийн бэрхшээлтэй ажилтны ажлын цагийг богиносгох, ээлжийн амралтын хугацааг уртасгах зэргээр бусад ажилтны нэг адил ажиллах тохиромжтой нөхцлийг бүрдүүлсний зэрэгцээ ААНБ-д хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах квотыг тогтоон, түүнийг биелүүлээгүй тохиолдолд төлөх төлбөрийн хэмжээг ААНБ-ын ажиллагчдын тоо, төлбөрийн хэмжээ, бүс нутгийн хөгжлийн ялгавартай байдлыг харгалзан тогтоон мөрдүүлж байна. Хуулийн дагуу 2009 онд гэхэд л 2633 ААНБ-ын 7.9 мянган ажлын байранд хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллахаас 80 гаруй хувь нь төсвийн байгууллагад ногдож байна. Төсвийн байгууллагын үйл ажиллагааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж, хуулийн хэрэгжилт хангалтгүй байх явдал нийтлэг байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй ААНБ сар бүр Засгийн газраас тогтоосон төлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Засгийн газрын тусгай санд төвлөрүүлэх үүргийг хүлээдэг ба жилд дунджаар 300 орчим сая төгрөг төвлөрч байгаа нь бодит хэмжээнээс ихээхэн доогуур буюу тухайн заалт хангалтгүй хэрэгжиж байгааг илэрхийлж байна.

111. Энэхүү хуулиар дээрх төлбөрийг 24 сар тасралтгүй төлсөн бол дараагийн 12 сард төлбөрөөс чөлөөлөгдөх давуу эрхийг ААНБ-д олгосон нь нэг талаас хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах сонирхлыг ажил олгогчдод бий болгохыг зорьсон байна.

112. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөдөлмөрийн зах зээлд нээлттэй оролцуулахад зайлшгүй шаардлагатай төрийн үйлчилгээ үзүүлэх асуудлыг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хуулиар зохицуулдаг. Хуулийн дагуу хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхлэх чадварыг нь хөдөлмөр эрхлэлтийн албанаас сорилын аргаар тодорхойлсон хөгжлийн бэрхшээлтэй хүнд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө, мэдээллээр хангах, мэргэжил эзэмшүүлэх, давтан сургах, ажилд зуучлах, нийтийг хамарсан ажилд оролцуулах, бага хүүтэй жижиг зээл олгох, зээлийн хүүг нөхөн төлөх, бизнес инкубаци зэрэг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээг бусад иргэдийн нэг адил үзүүлдэг. Жишээ нь:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд зориулж ХЭДС-аас 1030424,6 мянган төгрөгийг зарцуулж ажилласан байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд 2010 онд аймаг, дүүргийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсүүдийн ирүүлсэн мэдээгээр 1232 хүнийг аж ахуй эрхлэх, ур чадвар эзэмшүүлэх, давтан сургалтад хамруулж 598 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байранд зуучилсан бол 1684 хүнийг нийтийг хамарсан ажилд хамруулан түр ажлын байраар хангасан байна.

- 2010 онд НХХЯ-наас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үүднээс 392 төслийг 2 үе шаттай сонгон шалгаруулж, 850 орчим сая төгрөгийн санхүүжилт хийж, 1700 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн орлогыг нэмэгдүүлсэн байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд хараагүй иргэд олноор ажилладаг массажийн төв, Хараагүйчүүдийн сургалт, үйлдвэрлэлийн төв, хараагүй иргэдийн FM радио, тэргэнцэртэй иргэдийн оёдлын цех зэрэгт санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. НХХЯ энэ үйл ажиллагаагаар дамжуулан хөгжлийн бэрхшээлийн төрөлд нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих загвар бий болгохыг зорьж байгаа.

113. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөдөлмөрийн нээлттэй зах зээлд оролцуулах эрх зүйн орчин харьцангуй сайн бүрдсэн боловч хамрах хүрээ хязгаарлагдмал байгаа. Энэ нь нэг талаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ үзүүлж байгаа төв, орон нутгийн ХХҮХ-ийн ажилтнуудын чадавхи, ойлголт хандлага, мэдээлэл муутай холбоотой. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулсан ажил олгогчид ажилтанд эхний 6 сар олгосон цалин, хөлсний 60 %-ийг нөхөн олгох, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг 24 сараас доошгүй хугацаанд ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-10 дахин нэмэгдүүлсэн хэмжээний урамшууллыг олгох, хөдөлмөрийн зах зээлд бие даан оролцох боломжгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүнд ажлын байр бий болгох зорилгоор хөдөлмөр сургалтын төв, ААНБ-ын дэргэд байгуулагдсан үйлдвэрлэлийн тусгай цех, тасгийн үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр илүү боломжийг олгосон байна. Гэвч хуулийн эдгээр боломжуудын талаар ажил олгогчдын мэдлэг, мэдээлэл хангалтгүйгээс хэрэгжилт төдийлөн сайн биш байдаг.

114. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дотор боловсролгүй, мэргэжилгүй хүний эзлэх хувь өндөр байдаг. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэргэжил олгох, дахин мэргэшүүлэх асуудлыг Засгийн газар онцгойлон анхаарч, түр сургалтын байгууллагуудаар дамжуулан сургах ажлыг зохион байгуулдаг ба зардлыг нь эрүүл хүнийхээс 30%-иар илүү байх зохицуулалтыг мөрдүүлдэг боловч сургалтын байгууллагад нэвтрэх дэд бүтэц байхгүйгээс хамрагдалт муутай. МСҮТ-үүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сургах боломж байвч өнөөгийн хууль эрх зүйн хүрээнд заавал сургах квотгүйгээс төдийлөн анхаардаггүй байна. Цаашид ийм квот тогтоож өгөх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг түр сургалтын байгууллагаар дамжуулан хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй мэргэжлээр сургаж, хөдөлмөр эрхлэх боломжийг дээшлүүлэхэд заавал нөлөөлнө гэж үзэж байна.

115. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийн 16 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлд тавигдах шаардлагыг “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажлын байрны нөхцөл нь тэдний хөдөлмөрлөх чадварт тохирсон, түүнийг орж, гарахад нь саад болохооргүй байдлаар тоноглогдсон байх ёстой” хэмээн тодорхойлжээ. Харин ажил олгогчдын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулахтай холбоотой нэмэлт тоног төхөөрөмж, дэд бүтцийг бий болгоход шаардлагатай зардлын эх үүсвэр хязгаарлагдмал тул ийм нөхцлийг бүрдүүлэхэд бэрхшээл учирдаг. “Хөдөлмөрийн тухай” хуулиар тогтоосон квотоор хөгжлийн бэрхшээлтэй хүнийг авч ажиллуулж байгаа ажил олгогчид ийм нөхцлийг бүрдүүлж байгаа эсэхэд хяналт тавих бүтэц, тогтолцоо, албадлагын механизм харахан бий болоогүй байна. Энэ үүргийг тухайн асуудлаар холбогдох мэргэжлийн ТББ-аар гүйцэтгүүлэх боломжтой.

116. Тодорхой боловсрол, тусгай мэргэжил үл шаардах энгийн ажилд хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах бусад гэрээгээр ажиллаж байгаа нийт ажилтан, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй ажилтанд Засгийн газар, ажил олгогч, үйлдвэрчний төлөөллийн байгууллагуудын зөвшилцлөөр тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин хөлс олгохыг хуулиар хориглодог. Уг хэмжээг хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлт, хөдөлмөрийн бүтээмж, дундаж цалингийн зохистой харьцаа, нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ, эдийн засгийн өсөлт, хөдөлмөр эрхлэлтийн түвшинг харгалзан 2 жилд нэг удаа тогтоохоор хуульчилсан байдаг. Энэхүү хууль нь хөгжлийн бэрхшээлтэй ажилтныг бусад ажилтнуудтай ижил ажил эрхэлсэн тохиолдолд адил цалин хөлс авах, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин хөлс авч байгаа эсэхийг хянах боломжийг олгож байгаа.

28 ДУГААР ЗҮЙЛ

АМЬЖИРГААНЫ ХҮРЭЛЦЭХҮЙЦ ТҮВШИН, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

117. “Нийгмийн халамжийн тухай” хуулийн 3.1.2 -д хөгжлийн бэрхшээлтэй хүнийг “Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа шаардлагатай хүн” гэж тодорхойлсон ба тэдний амьдралд хүрэлцэхүйц хэмжээний тэтгэмж, тэтгэвэр олгох, зайлшгүй шаардлагатай үед өөрт нь болон гэр бүлийн гишүүдэд нь тусламж, хөнгөлөлтийг Нийгмийн даатгалын болон Нийгмийн халамжийн сангаас холбогдох хуулийн дагуу олгодог. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэнд нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, төрөлжсөн асрамжийн үйлчилгээ, олон нийтийн оролцоонд

түшиглэсэн халамжийн зэрэг 13 төрлийн тусламж, хөнгөлөлт олгохыг хуульчилсан байна.

Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 2010 оны 10 сарын 1-нээс 30%-иар нэмэгдүүлж, 27.6 тэрбум төгрөгийг Халамжийн сангаас зарцуулсан байна.

118. “Нийгмийн халамжийн тухай” хуулийн 3.1.3 –д бусдын туслалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй, бусдын асрамжид байнга байгаа хүнийг “байнгын асаргаа шаардлагатай иргэн” хэмээн тодорхойлж, эдгээр иргэдийг асрамжилж байгаа иргэдэд мөн хуулийн 3.1.7 –д заасан нөхцөлт мөнгөн тэтгэмжийг тодорхой шалгуур, болзолтой олгохоор заасан байдаг.

Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүний амьжиргааны баталгааг хангах үүднээс Нийгмийн халамжийн сангаас эмнэлгийн байнгын хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаа иргэнд болон эмнэлгийн байнгын хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүний эм тарианы зардалд, 18 нас хүрээгүй, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асардагийн улмаас хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа хүнд, тэжээн тэтгэх үр хүүхэд, төрөл садангийн хүнгүй, ганц бие, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг гэртээ асран халамжилж байгаа хүнд тус тус сар бүр хуулиар тогтоосон тэтгэмж, тусламж олгож байна.

Нийгмийн халамжийн сангаас 2010 онд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай дээр дурдсан 33.9 мянган хүнд 4.3 тэрбум төгрөг, мөн сангаас нөхцөлт мөнгөн тэтгэмжид 33.0 мянган хүнийг хамруулж, 8.2 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

119. 2005 оноос хувь хүн, төрийн болон ТББ, ААНБ-ын оролцоотойгоор хөгжлийн бэрхшээлтэй хүнийг чадваржуулах, дэмжин туслах, сэргээн засах, зөвлөгөө өгөх, амьжиргаанд нь дэмжлэг үзүүлэх агуулга бүхий цогц арга хэмжээ болох “олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ”-ээг туршиж, хөгжлийн бэрхшээлтэй хүнд тулгамдаж буй хэрэгцээг орон нутагтаа шийдвэрлэдэг болоход анхаарч байна.

120. Нийгмийн халамжийн хуулийн 3.1.9 дэх заалтын хүрээнд асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах хөгжлийн бэрхшээлтэй хүнийг “төрөлжсөн асрамжийн үйлчилгээн”-нд хамруулж, хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэх, тэдний амьдралын хэвийн нөхцлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Баян-өлгий, Увс, Ховд, Баянхонгор, Дорноговь, Дорнод аймгуудын Хөдөлмөр, халамжийн

үйлчилгээний хэлтсийн дэргэд байнгын үйлчилгээтэй асрамжийн тасгууд, Хөвсгөл аймаг, Батсүмбэр дахь асрамжийн газруудад нийт 350 гаруй хүнийг асрамжилж байгаагийн 30 орчим хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүн байна.

121. Сүүлийн жилүүдэд төсвийн санхүүжилттэй төвлөрсөн асрамжийн газрыг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж үйлчилгээтэй уялдуулах замаар төвлөрлийг сааруулахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч байна. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүн, байнгын асаргаа шаардлагатай хэсгийг улсын асрамжид үлдээх, боломжтой хэсгийг нь асрамжаас гарган, нийгэм, хамт олны дотор интеграцлах, нийгмийн салбарын хувьчлалын хүрээнд тогтвортой ажиллах асрамжийн газрын удирдлагыг мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, ТББ-аар гэрээгээр гүйцэтгүүлэх, нөхцөл, үйлчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж байна. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа шаардлагатай иргэдэд үзүүлэх нийгмийн халамж, асрамж, сувиллын үйлчилгээний стандартыг батлуулан хэрэгжүүлж байна. 2010 онд Нийгмийн халамжийн сангаас 17.6 мянган хүнийг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамруулж, 1.3 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

122. Засгийн газар 2009 оноос Азийн Хөгжлийн Банктай хамтран хүн амын эмзэг хэсэгт хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд уг хөтөлбөр нь халамжийг зорилтот бүлэгт оновчтой чиглүүлэх үйлчилгээний нэг хэлбэр болж байна. Хөтөлбөрийн хүрээнд хүнсний талон олгох зорилтот бүлгийг “Орлогыг орлуулан тооцох аргачлал”-аар тодорхойлон хэрэгжүүлж байна.

123. “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд: Төв аймгийн Батсүмбэр дэх ахмадын асрамжийн төвийг түшиглэн 90 хүний асрамжийн төв байгуулах, Улаанбаатар хотын Зүүн Сэлбэ хороололд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настанд зориулсан нөхөн сэргээх, сувилах эмнэлэг бүхий тусгай зориулалттай ахмадын 90 айлын орон сууцыг 2010-2012 онд барихаар тус тус төлөвлөөд байна.

29 ДҮГЭЭР ЗҮЙЛ

УЛС ТӨР, НИЙГМИЙН АМЬДРАЛД ОРОЛЦОХ

124. Монгол Улсын “Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэгт “Сонгогч саналаа нууцаар гаргана. Сонгогчоос саналаа чөлөөтэй илэрхийлэхэд саад учруулахыг хориглоно.”, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт “Сонгогч санал хураах байранд ирж, саналаа өөрөө өгөх бөгөөд харин

биеийн эрүүл мэндийн байдлын улмаас санал хураах байранд хүрэлцэн ирж чадахгүй сонгогч зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгөх хүсэлтээ санал хураах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө сонгуулийн хэсгийн хороонд бичгээр гаргах бөгөөд тухайн сонгогчийн саналыг сонгуулийн хэсгийн хорооны нэг намын бус төлөөлөлтэй хоёроос доошгүй гишүүн оршин суугаа газрын хаягаар очиж авна.” гэж, 33.4 дэх хэсэгт “Санал бэлтгэх тасалгаанд тухайн сонгогчоос өөр хэн ч байж болохгүй. Саналын хуудсанд саналаа өөрөө тэмдэглэж чадахгүй сонгогч өөрийн итгэмжилсэн хүний туслалцаа авч болно. Харин аль нэгэн намын сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, сонгуулийн хорооны гишүүн болон ажиглагчаар ийнхүү туслалцуулж болохгүй.” гэж заажээ.

125. Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэгт “Сонгогчоос саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хэн боловч албадан нөлөөлж, саад учруулахыг хориглоно.” гэж, 47 дугаар зүйлийн 47.7 дахь хэсэгт “Бие эрхтэний согог, эрүүл мэндийн байдал, боловсролын түвшингээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогч өөрийн итгэмжилсэн хүний туслалцаатайгаар санал өгч болох бөгөөд тэр нь сонгуулийн эрх бүхий иргэн байна.” гэж, 47.10 дахь хэсэгт “Биеийн эрүүл мэндийн байдлын улмаас санал авах байранд хүрэлцэн ирж чадахгүй сонгогч зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгөх хүсэлтээ санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө хэсгийн хороонд бичгээр гаргана.” гэж, 47.11 дэх хэсэгт “Хэсгийн хороо энэ хуулийн 47.10-т заасан хүсэлтийг үндэслэн зөөврийн битүүмжилсэн хайрцгаар саналыг нь авах сонгогчдын нэрийн жагсаалтыг тусад нь гаргаж, нэрийн жагсаалт, санал авах чиглэл, хуваарийг хуралдаанаараа хэлэлцэн батална.” гэж, 47.12 дахь хэсэгт “Энэ хуулийн 47.11-д заасан сонгогчийн саналыг тухайн хэсгийн хорооны нэг намын бус төлөөлөлтэй хоёроос доошгүй гишүүн оршин суугаа газрын нь хаягаар очиж авна.” гэж заажээ.

126. “Ард нийтийн санал асуулгын тухай” хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “Иргэн санал өгөх байранд ирж, саналаа өөрөө өгнө. Харин биеийн эрүүл мэндийн байдлаас болон хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас санал авах байранд хүрэлцэн ирж чадахгүй иргэний саналыг түүний хүсэлтээр санал авах хэсгийн хорооны хоёроос доошгүй гишүүн очиж, битүүмжилсэн хайрцгаар авна.” гэж, 21.5 дахь хэсэгт “Санал бэлтгэх тасалгаанд санал өгөгч тухайн иргэнээс өөр хүн байхыг хориглоно. Саналын хуудсанд саналаа өөрөө тэмдэглэж чадахгүй хүн санал авах хорооны гишүүнээс бусад гагцхүү өөрийн итгэмжилсэн хүний туслалцаа авч болно.” гэж заасан байна.

127. Сонгуулийн ерөнхий хорооны 2008 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор баталсан “Улсын Их Хурлын сонгуулийн хэсгийн хорооны болон санал авах байрыг бэлтгэх заавар”-ын 3 дугаар зүйлийн 3.7 дахь хэсэгт “Саналын хайрцгийг хөгжлийн бэрхшээлтэй сонгогч саналаа өгөх боломжтой байдлаар байрлуулна” гэж, 3.9 дэх хэсэгт “Санал бэлтгэх тасалгааг

хөгжлийн бэрхшээлтэй болон бусад сонгогч саналаа нууцаар тэмдэглэх боломжтой байдлаар бэлтгэнэ.” гэж заажээ.

128. Сонгуулийн насны санал өгөх эрхтэй хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэд 39265 байгаа нь нийт сонгогчдын 2,54 хувь болж байна. 2008 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын Үндэсний холбооноос хийсэн судалгаагаар 2008 оны сонгуульд сонгуулийн насны хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэдийн 34.7 хувь буюу 13625 хүн оролцсон байна. Энэ нь саналаа өгсөн нийт сонгогчдын 1,15 хувь болж байна.

Хүснэгт 7. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгуульд оролцоогүй шалтгаан

Шалтгаан	Сонгуульд оролцоогүй иргэд-25640
Сонгуулийн байр тохиромжгүйгээс	Тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэдийн 48 % буюу 4721хүн
Брайл шаблон байхгүйгээс	Харааны бэрхшээлтэй иргэдийн 40% буюу 2785 хүн
Дохионы орчуулгагүйгээс	Сонголын бэрхшээлтэй иргэдийн 7% буюу 557 хүн
Бусад	Үлдсэн нь бусад шалтгаанаар оролцоогүй байна

/2008 оны УИХ-ын сонгуулийн үеэр МХБИБҮХ-ны хийсэн судалгаа/

30 ДУГААР ЗҮЙЛ

СОЁЛЫН АМЬДРАЛД ОРОЛЦОХ, ЧӨЛӨӨТ ЦАГ, АМРАЛТАА ӨНГӨРҮҮЛЭХ, СПОРТООР ХИЧЭЭЛЛЭХ

129. БСШУЯ-наас боловсруулж буй “Монгол улсын төрөөс соёлын талаар баримтлах бодлого”-ын шинэчилсэн төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг соёлын үйл ажиллагаанд татан оролцуулах, тэдний авьяас, хөдөлмөр бүтээлийг үнэлэх” асуудлыг тусгайлан авч үзэж тусгасан байна.

130. Хүүхдийн төлөө газар 2009 онд Хүүхдийн ивээх сангаас олон нийтэд түшиглэсэн 4 төвийг хүлээн авснаас 2011 онд Чингэлтэй дүүргийн “Олон нийтэд түшиглэсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхөн сэргээх төв”-ийг хүлээн авч үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулах бэлтгэл ажил хангагдаад ажиллаж байна. Энэ төвд Чингэлтэй дүүргийн 17, 18, 19 дүгээр хороодын 200 гаруй хүүхдүүдэд ахуйн болон хөдөлгөөний засал, сургалт, сурталчилгааны ажил, тэдгээрийн гэр

бүлд үзүүлж буй нөхөн сэргээх үйл ажиллагаа, нийгмийн ажлын үйлчилгээг илүү цогцоор, чанартай хүргэхэд чиглэгддэг¹⁰.

131. Олон Улсын Театрын Институтын Монголын төвөөс санаачлан “ТЕАТР-ХҮҮХЭД-ИРЭЭДҮЙ” сэдэвт олон улсын хүүхдийн жүжгийн их наадмыг 2010 онд МУЗГ, БСШУЯ, ХТГ-ийн дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотод зохион байгуулсан. Энэхүү их наадамд Швейцарь, Швед, Норвеги, Болгар, Хорват, Вьетнам, Монгол, Буриад, Саха Якут зэрэг нийт 9 орны төлөөлөгч оролцож 100 гаруй зочид төлөөлөгчдийн хүрээнд оролцогч орнуудын тоглолт, “Хүүхдийн театр” мэргэжлийн сургалт, “ТЕАТР-ХҮҮХЭД-ИРЭЭДҮЙ” олон улсын бага хурал зэрэг ажлуудыг зохион байгуулсан. Олон улсын бага хурлаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг театраар дамжуулан нийгэмшүүлэх нь”, “Театрын ирээдүйн үзэгчдийг хэрхэн бэлтгэх вэ” гэсэн хоёр үндсэн асуудлын хүрээнд театрын өнөөгийн үйл ажиллагаа, ирээдүйн үзэгчид, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх, тэдэнд тулгардаг хүндрэл бэрхшээл, цаашид хэрэгжүүлэх арга замын талаар харилцан туршлага солилцож, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Төр засаг, соёл урлаг, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааг идэвхжүүлж, хүүхэд, багачуудынхаа хөгжил, хамгаалал, оролцоог хангах, тэднийг оюунлаг иргэн болгон төлөвшүүлэхэд театр урлагийн үр өгөөжийг дээшлүүлэх талаар санал, зөвлөмжийг гаргаж шийдвэр гаргах түвшнийхэнд хүргүүлснээр ХБХ-ийг урлагаар дамжуулан нийгэмшүүлэх асуудалд бодит дэмжлэг үзүүлэх эхлэл тавигдлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийг театрт ирж үзвэр үзэх таатай орчин нөхцлийг сайжруулах зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгай суудал, орц гарцын асуудлыг Улсын Драмын Эрдмийн Театрт бий болгосон.

132. Хүүхдийн төлөө сангийн санхүүжилтээр найруулагч Ч.Түвшингийн найруулсан “Үнсгэлжин”, Б.Мөнхдоржийн найруулсан “Буратино” зэрэг хүүхдийн жүжгүүдийг харааны бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээнд зориулж 300 хувь хэвлүүлж олон нийтэд хүргэлээ. ДУЭТ-т “Лусын дагина” хүүхдийн жүжгийг “Оюу толгой” ХК-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 600хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулан үзүүлсэн¹¹ Түүнчлэн бизнесийн болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран ХБХ-ийг урлагаар дамжуулан нийгэмшүүлэх зорилготой “ХАМТДАА ХӨГЖИЦГӨӨ” төсөл хэрэгжүүлэх эхлэл тавигдаад ажиллаж байна.

133. 1991 онд Хүүхдийн төлөө Үндэсний төвийн даргын тушаалаар батлагдсан **“ОНЫ ШИЛДЭГ ХҮҮХЭД”** шалгаруулах үйл ажиллагааг жил бүр зохион байгуулж тухайн онд амжилт, бүтээлээрээ манлайлсан хүүхдийг 5 номинациар шалгаруулан олон нийтэд сурталчилдаг билээ. Энэхүү

¹⁰ Олон нийтэд түшиглэсэн ХБХ-ийн нөхөн сэргээх төвийн тайлангаас

¹¹ ХБХ-тэй ажилладаг ТББ-ын сүлжээний 2010 оны тайлангаас

шалгаруулалтанд сүүлийн 2 жилд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нэр дэвшин **“ОНЫ ШИЛДЭГ ХҮҮХЭД”**-ээр шалгарсан нь сэтгэл санааны хувьд өөрийгөө жолоодох, ирээдүйдээ итгэх итгэл нэмэгдэх, тэднийг гадуурхан хайхрамжгүй ханддаг байдлыг арилгах, хүн хүнээ хүндэтгэх зэрэг ёс зүйн зөв чиг хандлагыг төлөвшүүлэх, гэр бүл, өөрийн орчиндоо хандах хандлагад эерэг өөрчлөлт гарч улмаар их, дээд сургуульд дэвшин суралцах боломж гарсан нь томоохон амжилт боллоо. Үүнд:

- **“2009 ОНЫ ШИЛДЭГ ХҮҮХЭД”** өргөмжлөлт, алтан медальт **Д.Наваанжамц** /сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн 10 дугаар ангид сурч байсан үедээ/ одоогоор биеийн тамирын “Шонхор” дээд сургуульд суралцаж байгаа.
- **“2010 ОНЫ ШИЛДЭГ ХҮҮХЭД”** өргөмжлөлт, алтан медальт сурагч **П.Болортуяа** харааны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн 9-р ангийн сурагч

134. Мэргэжлийн байгууллагатай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нар, ус, агаар, сүү, цагаан идээ, бариа заслаар хүүхдийг үнэ төлбөргүй амрах, тэдний эцэг эх асран хамгаалагчийг хүүхдийн амрах эрхийн бичгийн 50%-ийн хөнгөлөлттэйгээр амрааж тэдэнд зориулсан нөхөн сэргээх сургалт, нөхөн үржихүйн эрүүл мэнд /ХДХВ/ДОХ/-ийн төсөл 14 аймгийн 15 зусланд зохиогдож 5000 гаруй өсвөр насныхан хамрагдсан.

135. 2010 онд Хүүхдийг ивээх сангаас олон нийтэд түшиглэсэн 3 төвүүдийг хүлээн авч ажиллуулж байгаагаас Чингэлтэй дүүргийн “Олон нийтэд түшиглэсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхөн сэргээх төв”-ийг АДРА-Монгол олон улсын байгууллагын Боловсролын хөтөлбөр хүлээн авч үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулж байна. Энэ төвд Чингэлтэй дүүргийн 17, 18, 19 дүгээр хороодын 200 гаруй хүүхдүүдэд ахуйн болон хөдөлгөөний засал, сургалт, сурталчилгааны ажил, тэдгээрийн гэр бүлд үзүүлж буй нөхөн сэргээх үйл ажиллагаа, нийгмийн ажлын үйлчилгээг илүү цогцоор, чанартай хүргэхэд чиглэгддэг¹².

136. 2010 онд Баянхонгор аймгийн Баянхонгор суманд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа, үйлчилгээний төв”, Завхан аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийг түшиглэн “Хөгжлийн бэрхшээлтэй болон суурь өвчтэй хүүхдүүдийн нөхөн сэргээх клиник сувилал”-ыг ашиглалтанд оруулснаар хөгжлийн бэрхшээлтэй болон цус багадалт, сульдаа, тураалтай хүүхдийг хүлээн авч эмчлэн эрүүлжүүлэх, нөхөн сэргээх боломж бүхий тохилог орчин бүрдсэн байна.¹³

¹² АДРА-Монгол жилийн тайлан-2009

¹³ ХБХ-ийн оролцоог дэмжих дэд хөтөлбөрийн 2010 оны тайлангаас

137. Түүнчлэн оюуны өмчийн эрхийг хамгаалсан Монгол Улсын “Патентын тухай” “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай”, “Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай” хуулиудад тус тус заасны дагуу “Үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай” Монгол Улсын Шадар сайдын 2006 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 41 тоот, мөн 2006 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 59 тоот тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн урлагийн бүтээлийн эрхийг хамгаалж, тэдний холбогдох үйлчилгээний хөлсийг чөлөөлж байна.

138. 2011 оны 2 дугаар сард батлагдсан Биеийн тамир, спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тусгайлан зааж өгсөн: Биеийн тамирыг хүн амын өдөр тутмын хэрэглээ болгох, дундаж наслалтыг нэмэгдүүлэх 1-р зорилтын хүрээнд “биеийн тамир, спортоор дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлнэ.” Биеийн тамир, спортын материаллаг баазыг бэхжүүлэх 4 дүгээр зорилтын хүрээнд: “спортын шинэ ордны орчимд үндэсний шигшээ багийн болон бусад тамирчид байрлах, бэлтгэл хийх Тамирчдын хотхон, Өвлийн спортын ордон, “Үндэсний цэнгэлдэх хүрээлэн” цогцолбор барьж байгуулах”, “үндэсний шигшээ багийн тамирчдын бэлтгэлд хэрэглэх техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах” талаар зүйл, заалт оруулсан.

139. Биеийн тамир спортын газрын дэргэд Паралимпийн Үндэсний баг ажиллаж байна. Уг баг жүдо бөх, хөнгөн атлетик, байт харваа, буудлагын төрлүүдэд 12 хүний бүрэлдэхүүнтэй бэлтгэл сургуулилтаа хийж байна. Пара байт харвааны төрлөөр 2008 оны Бээжингийн Паралимпоос Д.Баатаржав Монгол Улсаас Паралимпийн анхны алтан медаль хүртсэн. Түүнчлэн нэгдсэн журмаар бэлтгэл хийсний дүнд БНХАУ-ын Гуанжоу хотноо 2010 онд зохиогдсон Паралимпийн Азийн спортын X их наадмаас Пара жүдо бөхийн тамирчид мөнгө, хүрэл медаль хүртэн шагналт 5 дугаар байрт гурван тамирчин шалгарч, өндөр амжилт үзүүлсэн. Баг тамирчдын Азийн наадамд оролцох зардалд 30 гаруй сая төгрөгийг зарцуулсан.

140. 2012 онд Паралимпийн наадамд оролцох эрх олгох томоохон арга хэмжээ болох Турк улсын Анталая хотноо 2011 оны 4 дүгээр сарын 1-10-ны өдрүүдэд зохиогдож буй Паралимпийн Дэлхийн наадамд жүдо бөх, хөнгөн атлетикийн төрөлд тамирчин, дасгалжуулагч, албаны 13 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцож байна.

141. Түүнчлэн Пара байт харвааны баг тамирчид Тайланд улсын Бангкок хотноо 60 хоногийн олон улсын хамтарсан бэлтгэл цугларалтад хамрагдан 2012 онд паралимпийн наадамд оролцох эрхээ авахаар Азийн цомын болон Азийн аварга шалгаруулах тэмцээнүүдэд оролцохоор бэлтгэж байна. Паралимпийн баг

тамирчдын бэлтгэл, цугларалт, тэмцээний зардалд 80 гаруй сая төгрөгийг одоогоор зарцуулаад байна.

3. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЭМЭГТЭЙЧҮҮД, ХҮҮХДҮҮДИЙН ТАЛААР

6 ДУГААР ЗҮЙЛ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЭМЭГТЭЙЧҮҮД

142. Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 45.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Тэдний хөгжлийн бэрхшээлийн төрлийг шалтгаанаар аваад үзвэл 33 хувь нь төрөлхийн, үлдсэн 67 хувь осол, гэмтэл, өвчлөлийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон нь иргэдийн осол гэмтэл, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөр хамгааллын асуудалд анхаарал хандуулах шаардлагатай юм.

143. Эрүүл мэндийн яамнаас “Эхийн эндэгдлийг бууруулах” 2000-2004, 2005-2010 оны стратегийг боловсруулан хэрэгжүүлж, жил бүр Эрүүл мэндийн сайдын зөвлөлийн хурлаар уг стратегийн хэрэгжилтийн явц, тулгамдсан асуудлыг хэлэлцэж холбогдох арга хэмжээг авч байсан. Уг стратегийг хэрэгжүүлэхдээ эх, нярай бүрт яс үндэс, шашин шүтлэг, нийгмийн гарал, газар зүй бүс нутгийн байдал, орлого, бие бялдрын байдлыг харгалзахгүй жендерийн мэдрэмжтэйгээр эсэн мэнд амаржихуйн мэдээлэл, тусламж үйлчилгээ жигд хүргэх, жендерээс үүдэлтэй хүчирхийлэл, жендерийн тэгш байдал мэдрэмжийн талаар иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, нийгмийн эмзэг хэсгийн эх нярайн хооллолт тэжээлийн дутагдлаас сэргийлэх ажилд нийгмийн нөөцийг дайчлан оролцуулах, өсвөр үеийн ба нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрхтэн тогтолцооны эмгэгийг илрүүлж, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах ажлуудыг хийхээр тусгасан. Стратегит хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилт аймгуудын ирүүлсэн тайлан мэдээлэл болон “Эх барихын яаралтай, нярайн нэн шаардлагатай тусламжийн өнөөгийн байдал, хэрэгцээнд хийсэн үнэлгээ”-ээр харьцангуй биелэлт сайтай байгаа бөгөөд эхийн эндэгдэл буурч байна.

144. Мөн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Эсэн мэнд амаржихуйн тусламж үйлчилгээнд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, сум дундын эмнэлгийн эх, нярайд үзүүлэх тусламжийг өргөжүүлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх; хаягийн бүртгэлгүй, ядуу эхчүүдэд харьяалал харгалзахгүй аль ч эмнэлгийн байгууллагад үзүүлж, эмчлүүлэх “Эрхийн бичиг” олгох; төрөх үед “Сайн дурын туслагч”-ийг эх өөрөө сонгож туслалцаа авах ажлыг дэмжих” зэрэг үйл ажиллагаа хэрэгжилт муутай байсан гэж үзлээ.

7 ДУГААР ЗҮЙЛ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮД

145. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх, мэдээлэл хайх, хүлээн авах болон сайн дураараа эвлэлдэн нэгдэх, тайван замаар хуран цуглах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг баталгаажуулсан байна.

146. Монгол Улсын Засгийн газар 2006 оноос “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна. Хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хувь хүн, нийгмийн гишүүний хувьд өөрийн сонголт, үзэл бодол, үнэт зүйлстэй байх, бие даасан аливаа үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээх тэдгээрийн чадамж, чадварыг хөгжүүлэх, нийгмийн амьдралд оролцох оролцоог хөхиүлэн дэмжих орчин, нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 4 зорилтын хүрээнд 2006-2012 онуудад 2 үе шаттай хэрэгжиж байгаа.

Жишээ нь:

- Хүүхдийн төлөө газар “Хүүхдийн эрх НАР” сэтгүүл, “НАЙЗ -1979” утасны мэдээлэл, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар үндэсний ба орон нутгийн мэдээллийн хэрэгслээр “Мэдээллийн хуудас” бичил сонин, харилцааны алтан дүрэм, сурталчилгааны материал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд туслах, нийгэмшүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна.
- Хүүхдийн төлөө газар нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээллийн сан бүрдүүлж, бусдын адил эрхээ эдлэх нийгэм дэх оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр бодлого боловсруулахад хэрэглэж байна.
- ЕБС-ийн багш, сурагчид анги хамт олны дунд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ялгавралан гадуурхахгүй байх, тэднийг нийгэмшүүлэх талаар ойлголт хандлагыг нэмэгдүүлэх сургалтыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг “Сайн дурын туслагч” хүүхдүүдийн дэмжлэгтэйгээр явуулж 1200-аад хүүхдийг оролцуулсан. Ингэснээр сайн дурын туслагч хүүхдүүдийн оролцоотойгоор сумдад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийг хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр “Хариу нэхээгүй тус”, “Сэтгэлийн илгээмж”, “Миний илүү чамд”, “Сэтгэлийн дэм” зэрэг аянуудыг зохион байгуулж 170 гаруй хүүхдүүдийг хамруулаад байна. (Өвөрхангай аймгийн ХТХ-ийн 2010 оны үйл ажиллагааны тайлангаас)

147. Монгол Улс бүс нутагтаа хүүхэд, өсвөр үеийнхний оролцоог хөгжүүлэх талаар зохих туршлагатай орны тоонд ордог төдийгүй энэ байр сууриа улам бататгах үүднээс Хүүхдийн оролцоог дэмжих бодлогын баримт бичгийн төслийг шинэчлэн боловсруулж байна.

148. Аймаг, орон нутгийн Хүүхдийн төлөө төвийн судалгаагаар 0-17 насны 22929 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаа гэсэн судалгаа байна. Тэдгээрийн 25% харааны, 12% тулгуур эрхтэний, 12% оюун ухааны хомсдолтой, 18% сонсголын бэрхшээлтэй, 10% тархины саажилттай, 9% хэл ярианы согогтой хүүхдүүд байна. Харин МХБИБҮХ-ны хийсэн судалгаагаар 32516¹⁴ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна.

149. “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлд: “...боловсрол, эрүүл мэндийн байдлаар хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй, эрх тэгш байлгах”, “хүүхдийн бие бялдар, оюун санаа, ёс суртахууны хөгжлийг хангах, сурч боловсроход эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч адил үүрэг хариуцлага хүлээх”, “хүүхэд эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах явдал төр, гэр бүлийн үндсэн үүрэг байх”, “хүүхэд мэдээлэл хайх, хүлээн авах, эвлэлдэн нэгдэх эрх эрүүл мэнд, нийгмийн дэг журам ...харшлахгүй байх” гэж хүүхдийн эрхийг хамгаалах үндсэн зарчмыг тодорхойлсон юм.

150. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бүх шатны боловсрол эзэмшүүлэх тэгш боломжийг “Боловсролын тухай”, “Сургуулийн өмнөх боловсролын тухай”, “Бага, дунд боловсролын тухай” хуулиудаар олгодог. Төрөлхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, эсхүл осол, гэмтлийн улмаас сэтгэц, оюун ухаан, мэдрэхүйн чадавхи нь алдагдсан, түүнчлэн бие эрхтэн нь гэмтсэнээс суралцах боломж нь хязгаарлагдсан суралцагчийг “хөгжлийн бэрхшээлтэй суралцагч” гэж тодорхойлон, 2 наснаас сургуульд элсэх хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тусгай болон сувиллын цэцэрлэгээр дамжуулан асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйлчилгээ үзүүлж, бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг нь дэмжиж байна. Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх ба хүүхдийн зусланд амарсан тохиолдолд эрхийн бичгийн үнийн 50 %-ийг жилд нэг удаа нөхөн олгодог. Жишээ нь:

- 2010 онд Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй 339 хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын төлбөрт 5.0 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн.
- 2010 онд Нийгмийн халамжийн сангаас хүүхдийн зусланд амарсан 239 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн бичгийн үнэнд 12.8 сая төгрөгийг нөхөн олгосон.

151. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, ялангуяа харааны бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэх, тэднийг боловсрол эзэмшүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Монголын хараагүй иргэдийн үндэсний

¹⁴ МХБИБҮХолбооноос хийсэн судалгаа 2008 он

холбоотой хамтран Брайль ном хэвлэх, орон нутагт түгээх зардлыг Нийгмийн халамжийн сангаас олгож, ном хэвлэлээр үнэ төлбөргүй хангах ажил тогтмолжиж байна.

152. Засгийн газар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд зэрэг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдийн хүнсний хангамжийг сайжруулах чиглэлд онцгой анхаарч байна. Жишээ нь:

- Монгол Улсын Засгийн газар Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж байгаа “Хүнс тэжээл, нийгмийн халамжийн хөтөлбөр”-ийн хүрээнд 2009 онд нийгмийн эмзэг бүлгийн 25.3 мянган иргэнд 14.0 мянган төгрөгийн үнэ бүхий хүнсний талоныг сар бүр олгож байгаагийн дотор байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд -3083, 0-18 насны бүрэн хараагүй – 120, сэтгэцийн өвчтэй 872 хүүхэд тус тус хамрагдсан байна.

153. 2009 оноос “Хүүхдийн асрамж, халамж, хамгааллын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 5852-2008 стандартыг мөрдөж байна. Энэхүү стандартын дагуу асрамж, халамжийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах, амьдрах орчин нөхцөлд нь анхаарах, орон байрыг нь стандартад нийцүүлэн тохижуулах зэргээр эрх ашгийг нь хамгаалах үүргийг хүлээдэг.

154. Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бусад хүүхдийн нэг адил үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг эдлүүлэхэд чиглэсэн туслалцааг олон хэлбэрээр хэрэгжүүлж байна. Жишээ нь:

- 2010 оны 5 сард зохион байгуулсан “Монголын хүүхдүүд” нэгдсэн чуулганд 438 төлөөлөгч оролцсоны 30% нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байсан ба чуулганы үеэр НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос ирүүлсэн зөвлөмжийн дагуу зүйл тус бүр дээр өөрсдийн үзэл бодлыг илэрхийлэх ажил хийгдсэн. Чуулганд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн илтгэл хэлэлцэгдэж, Засгийн газрын Шадар сайдтай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд санал бодлоо солилцсон.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг шийдвэр гаргах түвшинд оролцох, шийдвэрт үнэлгээ өгөх, санал дэвшүүлэх соёлд сургах зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоотой чуулган, уулзалт, нээлттэй хэлэлцүүлгийг Сэлэнгэ, Дорноговь, Сүхбаатар, Говь-Алтай, Баян-өлгий, Дорнод, Дархан-Уул, Завхан, Орхон, Ховд, Хэнтий аймаг, нийслэлд зохион байгуулж хэвшээд байна. Эдгээр арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй нийт хүүхдийн 19.6 % биечлэн оролцсон нь тэдний нийгэм хамт олны дунд орж мэдээлэл хүртэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, гэр бүл, өөрийн орчиндоо хандах хандлагад эерэг өөрчлөлт гарсан байна.

- “Хүүхэд хүүхэддээ” хөтөлбөрийн хүрээнд 1300 хүүхдийг сургагч багшаар бэлтгэн, үе тэнгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд туслах, оролцоог дэмжих, харилцан ярилцах зэрэг чадварт сурган 5000 орчим хүүхэд, эцэг эхчүүдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн амьдралд идвэхитэй, өөдрөг амьдрах боломжийг бүрдүүлэх үүднээс “Хүүхдийн ертөнц” зургийн уралдаан, “Өсвөрийн шилдэг дуучин”, “Бүжигчин” уралдаан, “Цодгор хүү” шатрын тэмцээн зэрэг урлаг, соёл, спортын арга хэмжээнд хамрагдах хүрээ өргөжсөн ба нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 63.5 % буюу 14750 хүүхдийг амьдрал ахуйн сургалтад хамруулсан байна. Дархан-Уул, Увс, Ховд, Сүхбаатар, Баян-Өлгий, Өмнөговь аймгууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн танхимуудыг ажиллуулж байна.

155. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрт илрүүлж, хэрэгцээг нь тодорхойлж, тэдэнд тохирох туслах хэрэгслүүдийг хийж өгсөн. Жишээ нь:

- Тархины саатай хүүхдүүдийн эцэг эхийг 10 хоногийн сургалтанд хамруулсан. Нийт 1200 эцэг, эх сургалтанд хамрагдсан. Үүний үр дүнд сургалтанд хамрагдсан эцэг эхчүүд хүүхэдтэйгээ ажиллах арга замаа сурч, тархины саатай хүүхдүүдэд ахиц дэвшил гарсан. Тухайлбал: судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 60% -д хөдөлгөөний чадвар дээшилж, бие даан мөлхөж, сууж, босож, явж чаддаг болсон байна. Дараагийн 20%-д дунд зэргийн сайжрал гарсан нь эцэг эхчүүд тогтмол хүүхдүүдтэйгээ ажиллах цаг муутай өөр хүмүүсээр харуулдаг байсан байна. Сүүлийн 20% -д сайн өөрчлөлт гараагүй байна. Үүнээс үзэхэд тархины саатай хүүхдүүдийг 0-6 сартай байхад нь эрт илрүүлж, эцэг эхчүүдэд хүүхдээ арчлах арга барил дасгал хөдөлгөөнүүдийг сайн зааж өгснөөр тархины саатай хүүхдийн хөдөлгөөний чадварт нөлөөлж дараагийн хүндрэлээс сэргийлж, эрт сэргээн засах боломжтой байгаа нь судалгаагаар тогтоогдсон.
- Сургалтанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сэргээн засалтын туслах хэрэгслүүдийг хийж өгсөн. Туслах хэрэгслүүдийг орон нутгийн олдоц ихтэй материал болох мод, даавуу, ПВХ хоолой гэх мэтийг ашиглаж, хамгийн хямд төсөр аргаар үйлдвэрлэдэг. Нийт 3500 туслах хэрэгсэл хийж, хүүхдүүдэд үнэгүй өгсөн.

156. ЭМ-ийн сайдын 2009 оны 342 тоот тушаалаар Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг 6 дахь удаагаа шинэчлэн, үүнтэй уялдуулан хөнгөлөлттэй олгох эмийн жагсаалтыг мөн шинэчлэн баталсан бөгөөд жагсаалтад хүүхдэд хэрэглэх 26 нэр төрлийн эмийг оруулж өгсөн.

Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгох эмийн жагсаалтыг “Зайлшгүй шаардлагатай эмийн шинэчилсэн жагсаалт”-тай уялдуулан шинэчилж,

Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн 2010 оны 03 тоот тогтоолоор батлуулан мөрдүүлж байна. Худалдааны нэршлээр 357 нэрийн эмийг уг жагсаалтанд оруулсан.

157. Хөнгөлөлттэй эмийн хангамж болон Эрүүл мэндийн сайдын тогтоолын хэрэгжилт газар бүрт ялангуяа төвөөс алслагдсан хөдөө орон нутагт хангалтгүй эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүл болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хэрэгцээтэй эмээ худалдан авах санхүүгийн эх үүсвэр дутмаг байдаг. Ялангуяа хөдөө амьдарч байгаа уналт, таталттай хүмүүс уналтын эсрэг эмээ авахдаа аймгийн эмнэлэгт үзүүлж, төв суурин газрын эмийн сангаас худалдан авдаг. Энэ нь өрхийн орлого муутай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эдийн засгийн дарамт учруулах талтай байна. Мөн зарим хүмүүс холбогдох хууль эрх зүйн мэдлэг дутмагаас хангамжийг хэрэглэж мэдэхгүй тохиолдол ч байна.

158. Монгол Улсын Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бусад хүүхдийн нэг адил үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг эдлүүлэхэд чиглэсэн олон хэлбэрийн үйл ажиллагааг үндэсний түвшинд зохион байгуулж байна.

Жишээ нь:

- 2006 онд “Хамтдаа хөгжицгөө” хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үндэсний анхдугаар чуулганд 485 төлөөлөгч оролцсоны 34 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд оролцсон байна.
- 2007 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эцэг эхчүүдийн чуулгауулзалтанд оролцогчдын 46.5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд оролцсон байна.
- 2008 онд Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Хамтдаа хөгжицгөө” Хүүхдийн Үндэсний II чуулганд оролцогчдын 30 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд оролцсон байна.
- 2010 онд “Монголын хүүхдүүд” нэгдсэн чуулганд оролцогчдын 48,5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төлөөлөл байгаа нь тулгамдаж буй асуудлыг

тэдэнтэй хамтран хэлэлцэх замаар бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч болон олон нийтэд хүргэх, тэдний оролцоо, эцэг эх, нийгэм, хамт олны хандлага, хариуцлагыг нэмэгдүүлэх цогц, тогтвортой ажиллагаа, зохицуулалтыг хангахад бодит дэмжлэг болсон байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй 14 хүүхдийн төлөөлөл Монгол Улсын Шадар сайд, Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн дэд тэргүүнтэй уулзаж, нэгдсэн чуулганд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн илтгэл тавигдлаа.

159. Өнгөрсөн хугацаанд 12 аймаг, нийслэлийн 3 дүүрэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн чуулган, хэлэлцүүлэг, ярилцлага, уулзалт зохион

байгуулж, тэдгээрт биечлэн оролцсоноороо “ХБХ-ийг сургуульд суралцах, аймаг орон нутгийн төрөл бүрийн уралдаан тэмцээнд оролцох боломжоор хангах” гэсэн заалт орж, улмаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгэм хамт олны оролцоо нэмэгдсэн, Баян-Өлгий аймаг сонсголын бэрхшээлтэй хүүхдийн судалгаа гаргаж /300 орчим/ улмаар АИФО олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр казак хэл дээрх дохионы хэлний сурах бичиг хэвлүүлсэн, Өвөрхангай аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн, засаг дарга аймгийнхаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төлөөлөлтэй уулзсаны дүнд 2008 оны үндсэн чиглэлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульдаа зорчих унааны асуудлыг шийдвэрлэсэн, Дархан-уул аймагт жил бүр “хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 1 өдөр”, “Хөгжиж байгаа хүүхдүүд” уулзалтыг уламжлал болгон зохион байгуулдаг болсон, Ховд аймаг, нийслэлийн Налайх дүүрэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өөрөө удирдах зөвлөл, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сайн дурын клуб” зэрэг байгуулан үйл ажиллагаа нь тогтмолжлоод байгаа зэрэг тодорхой ахиц гарсан байна.

160. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгаанд үндэслэн аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөл, хүүхдийн өөрөө удирдах байгууллага, скаутын зөвлөл, өсвөрийн улаан загалмайчид, шинэ давалгаа, хүүхдийн оролцооны удирдах зөвлөл зэрэг хүүхдийн оролцооны байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг өөрсдийн сайн дурын үндсэн дээр хамруулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцох оролцоо 10% нэмэгдэж байна. Түүнчлэн “Бид”, “Анд нөхдийн бүлэг”, “Найз”, “Сайн дурынхны баг”, “Өөртөө туслах бүлэг” зэрэг нийт 55 сайн дурын бүлэг, клубт сайн дурын 6800 орчим /29,6%/ хүүхэд нэгдэн үйл ажиллагаа нь тогтмолжиж өөрсдийн дуу хоолойгоо холбогдох газар, албан тушаалтанд илэрхийлэх, нийгэм хамт олны сэтгэлгээ эерэг болоход зохих ахиц гарсан байна.

161. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн амьдралын хүрээнд идэвхтэй, өөдрөг амьдрах боломжийг бий болгох зорилгоор авъяас, чадварыг нь нээн илрүүлэх төрөл бүрийн арга хэмжээ “Хүүхдийн ертөнц” зургийн уралдаан, “Итгэл дүүрэн амьдарцгаая” уран бүтээлийн тоглолт, сонсголын бэрхшээлтэй охидын дунд миссийн тэмцээн, дуу хөгжим, зураг, гар урлал, шатар, оригами бүжгийн дугуйлан, шүр сувдаар гоёл чимэглэлийн зүйл хийх, дэгээ болон хос зүүний нэхмэл, нийт 142500¹⁵ хүүхэд хамрагдсанаас давхардсан тоогоор хөгжлийн бэрхшээлтэй 14750 хүүхэд байна.

¹⁵ ХХХСҮХ-ийн 3 дугаар шатны үйл ажиллагааны хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийн үр дүнгийн нэгтгэл

4. ТОДОРХОЙ ҮҮРЭГТЭЙ ХОЛБООТОЙ ХЭСЭГ

31 ДҮГЭЭР ЗҮЙЛ

СТАТИСТИК БОЛОН МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ

162. Үндэсний хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тодорхойлсон нэгдсэн тодорхойлолтууд зөрүүтэй байдгаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн талаарх статистик болон захиргааны мэдээ, мэдээлэл, төвийн болон орон нутгаас авч буй мэдээлэл өөр гардаг байна.

Мөн түүвэр судалгаагаар хийгдэж байгаа мэдээллүүд мэдээ цуглуулах аргачлал өөр, мэргэжлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо сул, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оношлох нарийн аргачлал байхгүйгээс тоо мэдээнүүд өөр өөр гардаг тал бий.

163. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой мэдээг дараах эх сурвалжаас харвал:

- Монгол Улсад 110,0 мянга гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байна гэж үздэг. /тэгвэл ҮСХ 2010 онд 82631/
- Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авагч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс 41101/16-аас дээш насны, ХХҮГ, 2009 он, /
- Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс 53832 /НДЕГ, 2009 он/
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо /ҮСХ 2009 он /7809 / / 37000, 34000/,
- Хөдөлмөрийн насны 82.6 мянган ХБИ / ХХҮГ, 2009 он, 15-59 насны/

164. Хөгжлийн бэрхшээлийг ямар аргачлалаар тодорхойлох нь олон улсын хэмжээнд хамгийн хүндрэлтэй асуудал боловч цаашид НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийн 2 дугаар зүйлийн дагуу зөв оновчтой тодорхойлж, үндэсний хууль тогтоомжуудад нэг мөр болгох нь зайлшгүй чухал болж байгаа. Энэ нь эдийн засаг, нийгмийн хүчин зүйлс талаас нэн шаардлагатай болохыг олон орнуудын практик алхмууд илэрхийлж байна.

165. Хөгжлийн бэрхшээлийн талаарх статистик мэдээллийг Үндэсний статистикийн газрын даргын 2003 онд баталсан тушаалын дагуу Өрх, хүн ам, нийгмийн зарим үзүүлэлтийн тайлан НС-1 мэдээллийн маягтаар цуглуулж, статистикийн жил бүрийн эмхэтгэлд оруулан нийтэд тархааж байна.

166. Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос хөгжлийн бэрхшээлийн талаарх албан ёсны мэдээллийг сайжруулах чиглэлээр анхааран ажиллаж байгаа бөгөөд Тахир дутуу иргэдийн нэг удаагийн бүртгэл, түүвэр судалгааг 2004 онд олон улсад мөрдөгддөг арга зүй, ойлголт, тодорхойлолтын дагуу явуулсан. Түүнчлэн 2010 оны Хүн ам, орон сууцны тооллогын асуулгад анх удаа хөгжлийн бэрхшээлийн талаарх асуултуудыг оруулж өгснөөрөө энэ чиглэлийн албан ёсны статистик мэдээллийн баяжуулах боломж, нөхцөл бүрдэж байгаа юм.

167. Түүнчлэн АНДОЭЗНК/ВБ/ДЭМБ-ын хамтарсан Ази, номхон далайн бүс нутгийн орнуудын “Хөгжлийн бэрхшээлийн статистикийг сайжруулах” төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлийн талаарх асуултуудын багц турших судалгааг 2009 онд Ази, номхон далайн бүсийн 6 оронд явуулсны нэг нь Монгол Улс байсан бөгөөд судалгааг Үндэсний статистикийн хороо зохион байгуулж явуулсан байна. Уг мэдээлэл цуглуулах туршилтын судалгааг 2009 оны 7 дугаар сард Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 7 хороо, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Мандал, Хушаат сумдыг хамруулан нийслэлээс 60 хувь, орон нутгаас 40 хувийн харьцаатайгаар өрхүүдийг сонгож, судалгаанд хамруулсан байна.

32 ДУГААР ЗҮЙЛ

ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

168. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгохын тулд ялангуяа тэдний хөгжил, хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлаар НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд болон олон улсын Засгийн газрын болон төрийн бус, хүмүүнлэгийн олон талт байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тухайлбал, ХБХ-ийн эрхийг хангах, тэгш боломж олгох чиглэлээр хүчин чармайлт гаргаж байгаа олон улсын байгууллагууд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүн амын сан, Хүүхдийн Сан, ОУХБ, ЮНЕСКО, ДЭМБ, Дэлхийн банк, АХБ, Хүүхдийг Ивээх сан, Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллага, Шведийн олон улсын хөгжлийн агентлаг /SIDA/, АИФО Италийн төрийн бус байгууллага, Английн сайн дурын байгууллага /VSO/, ADRA, Канад сан, Мерси кор, зэрэг олон байгууллагын тусламж дэмжлэгтэйгээр төрөл бүрийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

169. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, хамгаалал, хөдөлмөрлөх эрхийг хангах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр НҮБХХ, Италийн АИФО ТББ, ОУХБ, Мерси Кор зэрэг олон улсын болон ТББ-уудын төсөл хөтөлбөр хэрэгжиж, Засгийн газрын бодлого, үйл ажиллагаанд техник, арга зүйн дэмжлэг үзүүлэн хамтран ажилладаг. Тэдгээрийн заримаас дурдвал:

- НХХЯ-наас НҮБХХ-ийн “Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хөгжүүлэх” төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэм, эдийн засгийн идэвхтэй оролцоог хангах орчинг бэхжүүлэх чиглэлээр 2009-2011 онд 45695 ам.долларын санхүүжилт хийгдэхээр төлөвлөгдөж, үйл ажиллагааг авч хэрэгжүүлж байна.
- ОУХБ, Чех Улсын Засгийн газрын санхүүжилтээр 2010 оноос хэрэгжиж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьжиргааг ур чадвар, бодлогын хэрэгжилтээр дэмжих нь” төсөл нь 214 мян. ам долларын төсөвтэй. Төслийн хугацаанд Хөдөлмөрийн төв бирж, Сэргээн засалтын үндэсний төв, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо гэсэн 3 байгууллагад ХБ иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний загваруудыг бий болгох, хөдөлмөрлөх эрхийг хангах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээрх үндэсний хууль тогтоомжуудын хэрэгжилтэд мониторинг хийх, нийгмийн түншүүд, төв, орон нутгийн хэрэгжүүлэгчдийн чадавхийг дээшлүүлэх, олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх зэрэг 3 үндсэн бүрэлдэхүүнтэй үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа.
- ЭМЯ, АИФО Италийн олон улсын байгууллагатай 1991 оноос хойш одоог хүртэл хамтын ажиллагааны гэрээ байгуулан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах-Тэгш дүүрэн” хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлж байна. Энэ хугацаанд АИФО байгууллага Европын Холбоотой хамтран 2 удаагийн төслийг Монгол улсын ЭМЯ-тай хамтарч хэрэгжүүлсэн. Үүнд: “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах-Тэгш дүүрэн” төслийг 1997-2000 онд Монголын баруун талын 11 аймаг, Улаанбаатар хотын 6 дүүрэгт, 2008-2010 онд Монголын зүүн талын 9 аймагт хэрэгжүүлсэн. АИФО ТББ нь 1991 оноос одоог хүртэл “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах – Тэгш дүүрэн” хөтөлбөрөөр дамжуулан Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нийт 3,105,518,330 төгрөгийн хөрөнгө оруулалтыг хүргэсэн байна.
- Европын холбоо, АДРА /Их британи/ байгууллагын тусламжтайгаар “Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хөдөө орон нутгийн хүүхдийн боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх боломжийг нэмэгдүүлэх нь” төсөл Улаанбаатар хот /Сонгино-хайрхан, Баянзүрх дүүрэг/ Баянхонгор, Завхан аймагт 3 жилийн хугацаатай хэрэгжүүлж эхлээд байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нөхөн сэргээх, энэ чиглэлээр хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор БНСУ-ын Сеул хотын протезийн үйлдвэр, ХБХ-ийн нөхөн сэргээх төв, Ганнам дүүргийн ажлын байраар хангах мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвтэй танилцаж туршлага судлаж цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх эхлэл тавигдлаа. Сеул хотын

протезийн үйлдвэртэй харилцаж ГССҮТ-ийг холбон зуучилж туршлага солилцох, тусламж үзүүлэх, мэргэжилтэн сургах асуудал тавиад ажиллаж байна.

- ДЭМБ нь Монгол улсын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад бүхий л талын дэмжлэг үзүүлэн ажилладаг. Жишээлбэл: 2010 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхэд хамтран ажилласан. Дэлхийн хэмжээний бодлого, зохицуулалтын мэдээ, мэдээллийг авах, сургалтанд хамруулах зэрэг бүхий л үйл ажиллагааг дэмжин ажилладаг.
- Монгол орны ихэнх аймгуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд эрт үеийн оношлогоо үйлчилгээ дутмаг, салбар хоорондын /эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн үйлчилгээ г.м/ үйлчилгээнд холбон зуучлах буюу шилжүүлэх тогтолцоо сул, үйлчилгээ үзүүлэгсэд болон эцэг эхчүүдийн оюуны хөгжлийн бэрхшээлийг эрт үеийн оношилгоо, үйлчилгээний талаарх мэдлэг дутмаг, нөөц хангалтгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээний хүрээнд орхигдсон байдгаас хамаарч оюуны бэрхшээлтэй хүүхдүүд эрүүл мэндийн цогц үйлчилгээг хүртэх байдал дутагдалтай байгаа учир “Хүүхэд бүрийг боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх” зорилгоор “Оюуны бэрхшээлтэй хүүхдийг нийгмийн цогц үйлчилгээнд тэгш хамруулах нь – Хүүхэд бүрт тэгш боломж төсөл” –ийг Европын холбооны санхүүжилтээр АДРА олон улсын байгууллага 2010-2012 оны хооронд хэрэгжүүлж байна. Тус төслийн хүрээнд ЭМЯ-ны ажлын хэсэг “Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг эрт илрүүлэх, сэргээн засах чиглэлээр эрүүл мэндийн оношилгооны хэрэгслүүдийг боловсруулж, оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдэд зориулсан энгийн гарын авлагыг боловсруулаад байна.

170. Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн асуудлаарх НҮБ-ын Конвенцид нэгдэн орж, түүний заалтуудыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн нь нэг талаас өөрийн улс оронд эрх зүйн орчныг сайжруулж, хэрэгжилтийг эрчимжүүлэх эдийн засгийн нөхцөл боломжийг бүрдүүлэх хариуцлагатай алхам бөгөөд нөгөөтэйгүүр НҮБ ба түүний төрөлжсөн байгууллагууд, Олон улсын хамтын нийгэмлэгээс авах техник арга зүйн дэмжлэг тусалцааг өргөжүүлэх нөхцлийг бүрдүүлж байгаа юм.

33 ДУГААР ЗҮЙЛ

ҮНДЭСНИЙ ТҮВШИНД БОЛОН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ

171. Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн асуудлаар Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан холбогдох хууль, бусад хэм хэмжээний актууд, түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлаар тусгайлан гаргасан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай” хуулийн хүрээнд тэдгээр хүмүүсийн эрхийг хангах үйл ажиллагааг зохион байгуулж байна.

172. Монгол Улсын “Засгийн газрын бүтцийн тухай” хуулиар тогтоосон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны эрхлэх асуудлын хүрээ, чиг үүргийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ хийх үндэсний бүтэц нь тус яамны дэргэд Үндэсний хороо нэртэйгээр байгуулагдсан. Тус хороо нь холбогдох яамд, ТББ, олон улсын болон гадаад түнш байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн бөгөөд төр, ТББ-аас сонгогдсон 2 нарийн бичгийн даргатайгаар ажиллаж байна. Энэ бүтэц нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, хөгжил, хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн асуудлаарх үндэсний хэмжээнд зөвлөлдөх, салбарын бодлогын уялдаа зохицуулалт хийх, бодлогын хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих үндсэн үүрэгтэй юм. Үндэсний хороо нь дараах чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжих, аж байдлыг сайжруулах асуудлаар санал, дүгнэлт гаргах, холбогдох байгууллагад удирдамж, чиглэл өгөх, орон нутгийн зөвлөлийг арга зүйн удирдлагаар хангах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, хууль тогтоомж, Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, боловсронгуй болгон сайжруулах асуудлаар бодлогын зөвлөмж, чиглэл гаргах
- Хөтөлбөрийн хүрээнд аймаг, нийслэлийн хэмжээнд хэрэгжиж буй үйл ажиллагааг уялдуулах, дэмжлэг үзүүлэх, удирдамж, зөвлөмжөөр хангах, хяналт тавих
- Монголд үйл ажиллагаа явуулж буй гадаад түнш байгууллагаас хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний хоорондын уялдаа холбоог хангах, энэ асуудлаар холбогдох гадаад түншид санал, зөвлөмж өгөх
- Хөрөнгө дайчлах, түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх
- Үндэсний хэмжээнд зохион байгуулах арга хэмжээний талаар зөвшилцөн санал, дүгнэлт гаргах гэх мэт.

173. Үндэсний хорооны зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөрлөх эрхийг хангах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангах чиг үүрэг бүхий 3 талт Салбар зөвлөл “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хуулийн дагуу байгуулагдсан Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн дэргэд ажилладаг. Салбар Зөвлөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрхийг хангах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр бодлогын санал, дүгнэлт гаргах, зөвлөмж чиглэл өгөх, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хамруулах зэрэг санхүүгийн болон бодлогын тодорхой асуудлаар шийдвэр гаргаж ажилладаг. Түүнчлэн уг салбар зөвлөлөөс аймаг, дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан гэрээт ажилтнуудын орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй иргэн авч ажиллуулах асуудлыг судлан, шийдвэрлэх талаар холбогдох байгууллагуудад чиглэл өгөөд ажиллаж байна.

ХҮСНЭГТҮҮД:

Хүснэгт 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, шалтгаанаар 2008-2010

Хүснэгт 2. Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын хүний эрхэнд холбогдох үндсэн конвенци, протокол

Хүснэгт 3. Монгол Улсын нэгдэн орсон ОУХБ-ын конвенциуд:

Хүснэгт 4. ЕБС-ийн сурагчдын “Үдийн цай” хөтөлбөрт хамрагдалт, 2006-2010

Хүснэгт 5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт, 2006-2010

Хүснэгт 6. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ерөнхий боловсролд хамрагдалт, 2006-2010

Хүснэгт 7. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгуульд оролцоогүй шалтгаан

ЗУРАГНУУД:

Зураг 1 Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувь, шалтгаанаар 2008-2010

Зураг 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, хувь, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр, 2010

Зураг 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан налуу зам

Зураг 4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан бие засах газар

-oOo-